



ШИХИХУТУГ

ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ОНОЛ, АРГА ЗҮЙ МЭДЭЭЛЭЛ





Сэтгүүлийн эрхлэгч: Д.Лүндээжанцан
 Ерөнхий редактор: О.Амархүү
 Зөвлөлийн гишүүд: Ж.Болдбаатар
 Ж.Бямбаа
 Н.Жалбажав
 Ц.Эрдэнэболд
 Нарийн бичиг: Ч.Жадамба

ГАРЧИГ

1 Ж.БЯМБАА	
Нийгмийн шударга ёсны Үндсэн хуулийн баталгаа	5
2 П.ЭРДЭНЭБААТАР	
Захиргааны хариуцлага бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу олон төрөлт эрх зүйн хариуцлага болох нь	15
3 Ч.ЧИНЗОРИГ	
Монгол улс дахь зам тээврийн осол, зөрчлийн нөхцөл байдал, түүний шалтгаан нөхцөл, түүнд хийсэн дүн шинжилгээ	21
4 А.СУГАРМАА	
Эвтэнэрийн эрх зүйн зохицуулалтын тулгамдсан асуудал.....	34
5 Б.АНХНЫБАЯР	
Их засгийн уламжлал ба XIII-XIV зууны хууль цаазын сурвалж бичгүүд	43
6 Б.БАЯРМАА	
Шүүхийн нотолгооны зарим асуудал.....	52
7 Б.УРАНЧИМЭГ	
Насанд хүрээгүй өвлөгчийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн зохицуулалтын асуудал	57
8 Д.АЛИМАА	
Хорих ял эдэлж буй ялтны эрхийг хангах зарим асуудал	62
9 Д.МӨНХ-ЭРДЭНЭ	
Авлигатай тэмцэх улс төрийн хүсэл зориг	67

10 И.БААСАНЖАВ

Монгол орон дахь нутгийн өөрөө удирдах ёсны өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд 72

11 Н.АЛТАНГЭРЭЛ

Халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх арга замууд 81

12 П.АНХЖАРГАЛ

Үр шилжүүлэн суулгалт, тээгч эхэд холбогдох эрх зүйн зохицуулалт, шийдвэрлэх арга зам 87

13 С.ЦОГСАЙХАН

Жижиг, дунд үйлдвэрийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь 93

14 Ц.ОНОН

Марксын сүнсийг хөөх нь: албан бус өмчийн эрхийг эдийн засгийн эргэлтэнд оруулах боломжийг авч үзэх нь 97

15 Ч.ДАВААСҮРЭН

Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох эрх зүйн зохицуулалт 101

16 Э.СОЛОНГО

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь гэрч хамгаалалтын эрх зүйн зохицуулалтыг оновчлох арга зам 105

17 Э.ЭРДЭНЭТУЯА

Дэлхийн зарим улс орнуудын татварын гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчин: харьцуулсан судлал 112

18 Э.ЭРХБИЛГҮҮН

Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох тухай 118



НИЙГМИЙН ШУДАРГА ЁСНЫ ҮНДСЭН ХУУЛИЙН БАТАЛГАА



Профессор Ж.Бямбаа

Шударга ёс нийгмийн амьдралын хүрээнд тулгуур хэм хэмжээ болон үйлчилсэн цагт хэнд ч болов амьдралынхаа утга учрыг ухаарч зөвхөн чин ариун эрмэлзэл, шударга хөдөлмөрөөрөө өмч хөрөнгөтэй, хангалуун амьдралтай болж чадна, үнэн хэзээд ч, ямар ч тохиолдолд ялна, ухаалаг нийгэм, төр түүнд үйлчилнэ гэсэн өөдрөг үзэл бодол, итгэл үнэмшил бүрэлддэг бөгөөд, ингэснээрээ бодгаль хүний авъяас билэг, хичээл зүтгэл, урам зориг нь улам идэвхижиж улс эх орны хөгжин дэвших үндэс суурь

нь тавигдахад эерэгээр нөлөөлж ирээдүй нь өөдлөн тодордог жамтай.

Чухам ийм учраас шударга ёсны шаардлага эрх зүйн агуулгын гол бүрэлдэхүүн хэсэг, хуулийг хэрэгжүүлж хэрэглэх үйл ажиллагааны үндсэн зарчмын нэг болж байдаг юм.

Шударга ёсны тухай ойлголт олон талтай өргөн ухагдахуун учраас нийгмийн шинжлэх ухааны янз бүрийн салбарт, тухайлбал, гүн ухаан, ёс суртахуун, эдийн засаг, хууль эрх зүйн хүрээнд өөр өөрсдийн үзэл онолын үүднээс өвөрмөц онцлог өнгө аястайгаар тайлбарлагддаг боловч үндсэн санаа, чиглэл нь хаана, ямар ч тохиолдолд агуулга, мөн чанараараа тун төстэй нь ажиглагддаг.

Эртний философичид нийгмийн дотоод зөрчлийг арилгах үндэс нь шударга ёс гэж үзсэн бөгөөд тэрхүү онол сургааль нь ухаантан мэргэдийн зохиол бүтээлд нь тусгалаа олсон байдаг.

Тухайлбал, Сократ “шударга ёс гэдэг нь хувь хүний ёс суртахууныг тодорхойлогч бөгөөд хуульд тусгалаа олж хуулиар илэрч байх учиртай, чингэсэн цагт түүний зохицуулах хүчин чадал бодитой болно” хэмээжээ.



Платон “шударга ёс нь яруу ухаан, эр зориг, тэвчээр гэсэн гурван сайн үйлсийг өөртөө агуулж байдаг. Шударга бус үйлдэл нь санаандгүй бол муухай, санаатай өдүүлбэл жигшүүртэй”¹ гэж сургасан аж.

Монголчууд эрт дээр үеэс шударга ёсыг эрхэмлэж ирсэн түүхэн баримтууд цөөнгүй бий. “Алтан товч”-д Чингис хаан “аль хүний билиг, гэгээн өршөөл, шударга, хичээнгүй, журам ёс бүхнийг дэмжмүй”² хэмээн айлдаж байсан тухай тэмдэглэгджээ. Их хаан шударга ёсыг ямагт үнэлж амь биед нь хүртэл халдсан харь дайсныг үнэн мөнөө өчсөн гэж амийг нь өршөөж “халдсанаа ил хэлсэн чамтай, ханьсан нөхөрлөж болмуй. Чигч шударгуу хүмүүнтэй чин үнэнч нөхөрлөгтүн “хэмээн зарлиг буулгаж байв”³.

“Шударга зан чанарыг монгол гэрийн баганатай зүйрлэж болно. Гэрийн хос багана байхгүй бол тооныг тогтоож чадахгүй. Хувь хүнд авъяас эрдэм байгаад ч шулуун шударга байхгүй бол хөл дээрээ баттай зогсож чадахгүй”⁴ гэж академич С.Нарангэрэл онцолжээ.

Бодьгал биеийн хэн болохыг

¹ Философские размышления древних мыслителей М.Юрист. 1994. Том 1. Стр 28

² Мэргэн гэгээн Лувсандамбийжалцан. Алтан товч, Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал. 12-р боть. УБ. 2006.м 20 дахь тал.

³ Ванчинбалын Инжиннаши. Хөх судар, Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал., 23-р боть. 326-327 дахь тал

⁴ С.Нарангэрэл. “Шударга ёс” өгүүлэл. Шударга ёс сэтгүүл. 2010. №1. 3 дахь тал

тодорхойлогч шударга ёс нийгмийн, хувийн гэсэн хосолмол шинжийг ямагт агуулна. Энэ нь хүмүүн төрөлхтний байгалийн болоод нийгмийн бүтээгдэхүүн болох мөн чанараас улбаатай биз.

Шударга ёсны гол шинж нь нийгмийн олон талт харилцааг тэнцвэржүүлж хүмүүн хоорондын дэг журам, эе эв, хамтын зорилтыг нөхцөлдүүлж аливаад алагчлалгүй хандах эрхэм чанарыг илэрхийлдэг.

Шударга ёс нийгмийн зан суртахууны тулгуур элементийн нэг учраас хэлбэр нь улам бүр өөрчлөгдөн хөгжиж агуулга нь өргөжин баяжиж зайлшгүй даган биелүүлэхээс өөр аргагүй зүй тогтолт хэм хэмжээг бүрдүүлж байна. Шударга ёсны нийгмийн гэгдэх шинж чанар нь эрх зүйн төдийгүй /нийгмийн/ бусад хэм хэмжээнний үйлчлэлийн хүрээнд эерэг үйл бүтээх, хувь хүн, байгууллага, төр, нийгэмд сөрөг нөлөө үзүүлэх элдэв үйлдэл /эс үйлдэл/ хийхээс урьдчилан сэргийлэх зорилгоор тодорхойлогдоно.

Эндээс, нийгмийн шударга ёс зөвхөн ёс суртахууны шалгуураар хязгаарлагдах учиргүй гэсэн дүгнэлтэнд хүргэж байна. Ийм ч учраас эрх зүйн аливаа үзэгдэл үүсэх, үйлчлэх үндэслэл нь нийгмийн зайлшгүй хэрэгцээ шаардлага гишүүдийнх нь ашиг, сонирхлын илэрхийллээс улбаатай байдагт хэн ч эргэлзэхгүй учиргүй.

Хууль тогтоомжид шударга ёс



тусгалаа олсон бол тэр нь нийгмийн төдийгүй эрх зүйн хэм хэмжээний эхлэл, заавалчгүй биелэгдэх албадлагаар хамгаалагдах эрх зүйн зарчим болон үйлчлэх нь ойлгомжтой.

Ер нь эрх зүйн зарчмууд нь хуульчдын мэргэжлийн эрх зүйн ухамсрыг бүрдүүлэх тулгуур ойлголтын нэг мөний хувьд түүнийг "хасаж танах нь" бүү хэл тусгайд нь, бас зайлшгүй үйлчлэх үе шаттай нь нягт холбож байнга судлах шаардлагатай.

Онол, арга зүйн үүднээс эрх зүйн зарчим нь эрх зүйн зорилгын тухай үзэл санаа, эрх зүй ямар байх ёстой тухай төсөөллийг бэхжүүлсэн үзэл баримтлалтай уялдаа бүхийг юуны түрүүн тэмдэглэх нь зүйтэй. Тэрбээр эхлээд эрх зүйн ухамсарт бүрэлдэж агуулга нь нийгмийн нийтлэг шулгуураар баяжихын зэрэгцээ эрх зүйн соёл хөгжихтэй уялдан улам төгөлдөржинө.

Профессор Д.Баярсайхан "Эрх зүйн зарчим нь нийгмийн амьдралын хэрэгцээ шаардлагыг хангаж, түүний харилцааг зохицуулахад баримтлах хууль зүйн үндсэн чиглэмж бөгөөд нийгмийн зайлшгүй хэрэгцээг тусгаж, ардчилсан эрх зүйт төр, түүний зүй ёсны бодит шаардлагад нийцсэн байна. Эрх зүйн зарчим нь ёс зүй-хууль зүйн нөлөөлөл бүхий тэргүүлэгч үзэл баримтлал мөн бөгөөд эрх зүйн ухамсар, ёс суртахууны чиглүүлэгч хэм хэмжээнүүдээс бүрдэнэ. Зарим

тохиолдолд эрх зүйн зарчмууд нь хуулийн зохицуулалтын шинэ боломжийг нээн илрүүлэхэд ихээхэн ач холбогдолтой"⁵ хэмээжээ.

Эрдэмтэн А.Эрдэнэцогт эрх зүйн зарчмыг "Эрх зүйн мөн чанар, түүний гол шинжийг илэрхийлсэн, бүхий л субъектээс үйл ажиллагаандаа мөрдлөг болговол зохих үзэл баримтлал төдийгүй, уг эрх зүйн харилцааны явцад үүссэн бэрхшээл, төвөгтэй /эрх зүйн хийдэл, олон утга, тодорхойгүй байдал гэх мэт/ асуудлыг үр дүнтэй даван туулах үндсэн эхлэл мөн"⁶ гэж тодорхойлжээ.

Доктор (Ph.D) Ч.Нямсүрэн "Эрх зүйн зарчим нь нэг талаас эрх зүйн зүй тогтлыг илэрхийлэх, нөгөө талаас бүх субъектүүдийг хамаарч эрх зүйн зохицуулалтын хүрээнд үйлчилж байдаг хамгийн нийтлэг хэм хэмжээ. Эрх зүйн зарчмууд нь хууль тогтоогч хэрэглэгчийн удирдлага болговол зохих үзэл санааны хувьд эрх зүйн хэм хэмжээг боловсронгуй болгох арга замыг тодорхойлно. Эрх зүйн зарчмын туслалцаатайгаар эрх зүйн тогтолцоо нь нийгэм ба хүний ашиг сонирхол, хэрэгцээнд таарч тохирдог. Эрх зүйн зарчим нь хууль тогтоогчийн субъектив санаа бодлын үр дүн биш тухайн орны түүхэн уламжлал, эдийн засаг, нийгэм, улс төрийн тогтолцооны бүтэц, тэдгээрийн

⁵ Д.Баярсайхан. Эрх зүйн онол. УБ., 2010. 66 дахь тал

⁶ А.Эрдэнэцогт. Монгол улсын захиргааны процессын эрх зүй. УБ. 2006. 13 дахь тал



үйл ажиллагааны үндсэн зарчим, тухайн улс оронд ноёрхож байгаа улс төрийн дэглэм, эрх зүй, төрийн мөн чанартай холбоотой объектив шинжтэй ойлголт⁷ гэж үзсэн байна. Цухас дурдахад, зарчим нь хуульд бие даасан хэм хэмжээ болон заавалчгүй тусгагдах шаардлагагүй, тодорхой зүйл заалтуудаар, тэрч атугай эрдэмтэн судлаачдын бүтээл, хуулийн тайлбаруудаар мөн чанараа таниулахыг ч үгүйсгэхгүй⁸ хэмээн ОХУ-ын зарим эрдэмтэд үзэж байна.

Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиудад “шударга ёсны зарчим”, “нийгмийн” гэсэн томъёололтой хослон тусгагдаагүй боловч үйлчлэх хүрээндээ тэрхүү үзэл санаа, утга агуулга, мөн чанарыг байнга илэрхийлж байдаг юм.

Шударга ёс хүн нийгмийн хөгжлийн өнөө цаг үед эрх зүйн зарчим болон баталгаажих ёстойг Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 10, Улс төрийн эрхийн пактын 6 дугаар зүйлээс төвөггүй ойлгож болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 1.2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн

зарчим мөн”⁹ гэж заасныг энд онцлох нь зүйтэй биз.

Ардын багш Б.Чимид энэхүү гүн гүнзгий утга агуулгын талаар тайлбарлахдаа “Хүн төрөлхтний үнэт зүйлс, ардчилсан хууль хийгээд ёс суртахууны аль алины нь нэг иш үндэс бол шударга ёс мөн. Түүнийг чанд сахиж, хууль дээдлэх нь засаг төрийн аливаа байгууллага, ямар ч албан тушаалтны дур зоргоор авирлахыг зориуд хязгаарлаж, хуулийн хүчээр хазаарлах үндэс болно. Үүгээрээ аливаа Үндсэн хууль эрх мэдэлтний зүгээс иргэнийг дарамтлах, хүний эрх, ашиг сонирхлыг зөрчихөөс сэргийлэх хүчин зүйл мөн.

Иргэн хүн хуулиар хориглоогүй зүйлийг хийж болох эрх чөлөөтэй байдаг бол засаг төрийн байгууллага, түүний албан тушаалтан гагцхүү хуульд заасан үүргийг, түүгээр олгосон эрхийн хүрээнд биелүүлэх ёстой байдаг. Энэ бол шударга ёсны хэмжүүр болсон хууль дээдлэхийн үндсэн шаардлага мөн¹⁰ гэсэн аж.

Ер нь шударга ёс, зүй ёсны хийгээд нийгмийн бусад хэм хэмжээний үйлчлэл Үндсэн хуулийн хүрээнд тусгагдан баталгаажвал хууль дээдлэх эрхэм зорилго нь жинхэнэ утгаараа хэрэгждэг билээ.

Хууль чандлах ч бай, эрх зүйт ч бай Үндсэн хуулийн янз бүрийн

⁷ Ч.Нямсүрэн. Эрх зүйн онол. УБ. 2010. 112 дахь тал

⁸ Уголовный процесс. М.2015. коллектив авторов стр 44

⁹ Монгол Улсын Үндсэн хууль. 1 дүгээр зүйлийн 2.

¹⁰ Б.Чимид. Үндсэн хуулийн мэдлэг. УБ. 2008. 36 дахь тал



томъёолол өнөө цагт үлэмжийн ач холбогдолтойд тооцогддог ардчилал, хүний эрх, шударга ёсыг эрхэмлэн дээдлэхгүйгээр нийгмийн хөгжил дэвшилтэй хөл нийлүүлэн алхаж чадахгүй. Тэгвэл хууль дээдлэх ёсыг шударга шүүхгүйгээр төсөөлөх арга байхгүй. Шударга хуультай байж гэмээж л шударга шүүхтэйд тооцогддог. Монголчуудын эрх зүйн ухамсар, цаг үеэ мэдрэх зөн билгийн сонгодог бүтээл болсон 1992 оны ардчилсан Үндсэн хуульд "Улсын Дээд шүүх, бусад шүүх нь Үндсэн хуульд нийцээгүй, албан ёсоор нийтлээгүй хуулийг хэрэглэх эрхгүй" гэж заасан байдаг. Чингэснээр шударга шүүх нь "сайн хууль" бий болгоход шууд нөлөөлөх боломж бүрдүүлдэг юм. Энэ нь зөв сайн хууль, шударга шүүх хоёр бие биенээ нөхөх диалектик хамааралтайг харуулж буй хэлбэр.

Шүүх бол хүний эрх, ардчилсан ёсыг хамгаалах гол хэрэглүүр бөгөөд хууль тогтоох, гүйцэтгэх байгууллагаас хүний эрх, эрх чөлөөг зөрчих, хууль бус албадлага хэрэглэхийн эсрэг зогсож, засаг төрийн дур зоргын хандлага тэдний гарын доорхи албадлагын аппарат хоёрын хооронд шударга ёсны илд бамбай болон ажиллаж эрх зүйн соёлыг түгээх нийгэм-ёс зүйн журамт үүрэгтэй үүний тул хууль, шүүх хоёулаа шударга ёсны хос багана байх жамтай юм.

Тиймээс ч шүүх эрх мэдлийн байгууллагууд үл бүтэх хүмүүсийн дуудагдаж очдог газар биш, үнэн

шударгыг эрхэмлэн хүндэтгэдэг, бүх хүний өөрөө хүсэж ирдэг ариун үнэний хүрээлэн, ардчилсан засаглалын нэгэн гол цөм байх учиртайг хэн хүнгүй ойлгон мэдрэх учиртай.

Жон.Френкийн хэлснээр "Шүүхээс айх хэрэггүй, харин түүгээр дамжуулж, түүний тусламжтайгаар элдэв худал хуурмаг явдал дураараа аашлах үзэгдэл, хүнд суртал, заль мэхтэй булт олноороо шийдвэртэй тэмцэх хэрэгтэй"¹¹.

Мөрдөн, прокурор, өмгөөлөл, шүүхийн гэх тодотголт байгууллагуудын нийгмийн төрөлх зориулалт ийм бөгөөд тэр шинжээрээ засаглалын системд хүндтэй байр суурь эзэлж хууль ардчилал, шударга ёс, хүний эрхийн төлөө тэмцлийн индэр байх зүй тогтлыг агуулна.

Шүүхийн шинэтгэлийн хүрээнд хууль хяналтын бүхий л байгуулалгын байр суурийг засаглалын системд зохих ёсоор эзлүүлж түүний ролийг дээшлүүлэх явдал одоо ч тэргүүн зэргийн ач холбогдлоо агуулсаар байна. Тиймээс ч төр, эрх зүйн системд явагдсаар байгаа манай шинэтгэлийн нэг гол хандлага нь түүнд бүрэн чиглэгдэх ёстой.

Зөрчилтэй ч гэсэн хуулийн заалт зөв гэх юм уу, хуульд хэрхэхийг заагаагүй учир тухайн маргааныг шийдэхгүй орших хэрэгтэй байх

¹¹ Мурадьян Э.М. Социальное действие и резонанс судебного решения. Гос и право 1993.



хэмээж “хэт хаширласан” хандлагыг шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгчид маань гаргах учиргүй.

Чухамдаа эдгээр ээдрээтэй асуудалд үндэслэлтэй хариулт өгөхийн тулд нийгмийн шударга ёсны зарчим, эрх зүйн мэргэшсэн ухамсрын үүднээс эргэцүүлэн тунгааж дотоод итгэлээрээ зөв, зоригтой шийдэлд хүрэх шаардлагатай.

Аливаа маргаантай асуудлыг ялган тунгаахдаа тухайн тодорхой тохиолдолд л үнэн мөн шударга ёсыг тогтоож тунхаглах нь хууль зүйг хэрэглэж, хэрэгжүүлэх үйл ажиллагааны эрхэм нандин чанар мөн бөгөөд энэ нь хууль ёс, шударга ёс хоёр адил ойлголт биш боловч шийтгэл, зэмлэл, эрх үүргийн асуудлыг практикт шийдэхэд хоорондоо байнга нөхцөлдөх зүй тогтлыг харуулж буй хэлбэр. Зөвхөн шударга шийдвэр л хууль ёсны байх бөгөөд аливаа шударга бус зүйл хууль ёсны байх ямар ч аргагүй билээ¹² гэж эрдэмтэн, судлаачид үздэг аж.

Иймд хууль, шүүхийн байгууллага аль нэг асуудал, зарга маргааныг хууль зүйн үндсэн дээр шийдэхдээ тэр нь шударга ёсонд хэр нийцэж байна вэ гэдгийг ямагт нягтлан цэгнэх учиртай.

Шударга ёс гэдэг бэлэн зохиосон жор биш улс төр, эдийн засаг, ёс суртахуун, гоо зүй, нийгмийн зэрэг

12 Профессиональное правосознание юристов. Под ред Г.В.Мальцева. В книге. Политико-правовые учения АОН, М.1989. стр 48

үлэмж өргөн олон утга агуулгатай гүн гүнзгий ухагдахуун гэдгийг нэгэнт онцолсон билээ.

Тийм ч учраас шударга ёсны тухай ойлголтын Үндсэн хуулийн агуулгыг мушгин гуйвуулж аливаа нэгэн улс төрийн хүчин, хэн нэгэн “гэнэт тодорсон” шударга этгээд “зөвхөн бурхнаас түүнд заяасан” мэтээр өмчлөн авч өөрийн дурар тайлбарлаж огт таарахгүй.

Хууль хэрэглэж асуудлыг шийднэ гэдэг нь үнэхээр олон талын мэдлэг оюун ухаан, амьдралын туршлага, нягт нямбай ажиллагаа, бүтээлч сэтгэлгээний үр дүн.

Шийтгэл зэмлэлийн бодлого шударга ёсонд хэр нийцэж байна гэдгийн гол шалгуур нь хэргийн учир оноож буй хариуцлага, хийсэн сөрөг үйлдлийн нийгмийн аюул, иргэд олон нийтэд учирсан хор хохирлын хэр хэмжээ, шинж чанар болон өдүүлсэн этгээдийн хувийн байдалд яг тохирч байх цогц үзүүлэлт.

Чухам энэ л хууль цаазны хариуцлагын гол утга учир бөгөөд буруу муу зүйл хийсэн хүн тохирох цээрлэлээ заавал хүлээх ёстой гэсэн шударга ёсны үзэл санаатай дүйж байгаагийн илрэл юм. Ямар шийтгэл оноовол гэмт буруутныг цаашид засаж хүмүүжүүлэхэд илүү үр нөлөөтэй вэ гэдэг асуудал хууль цаазын хариуцлага хүлээлгэхэд яриангүй харгалзах зүйл мөн боловч шийдвэрлэх ач холбогдол бүхий үндэслэл биш, дагалдах үзүүлэлтэнд



тооцогддох учиртай.

Ийм ч учраас шүүх засаглалыг шударгаар хэрэгжүүлэхдээ хуульчдад улс орны хөрөнгө мөнгө, байгалийн баялагийг гадна дотныхонтой элдэв хорон аргаар хуйвалдан завшигчид, банк, санхүүг сүйрүүлэгчид, татвар, хураамжаас удаа дараагийн ноцтой үйлдлээр офшордон зайлсхийхийн зэрэгцээ авилга, хээл хахуулийн "түймэр асаагчдыг" яагаад хуулийн хариуцлагаас чөлөөлөх, өршөөл үзүүлэх оролдлого засаглалын янз бүрийн түвшинд байнга хийгээд байна? Ямар учраас жигшүүртэй этгээдийг бодлого тодорхойлогчид маань өөгшүүлэн өрөвдөөд байгаад нийгмийн өргөн давхарга жигшин зэвүүцдэгийг эс тоомсорлох нь "буруу замаар будаа тээхийн цондон".

Тэрхүү зэмлэл, шүүмжлэлийг чухамдаа нийгмийн шударга ёсны зарчмыг хэрэгжүүлэхийг шаардаж буй олон түмний зүй ёсны хүсэл эрмэлзлэл гэж хүлээж авах ёстой.

Үнэхээр ч муу үйл хэрэг хийсэн хүн яаж халхавчлагдсан ч зохих цээрлэл хүртэх ёстой бөгөөд шударга ёс гэдэг оюун санааны талаас авч үзвэл зөвхөн энэрч өрөвдөх биш, бас жигшин зэвүүцэхийн мөн чанарыг агуулж байдаг юм.

Шударга ёс нийгмийн сэтгэл зүйн нэгэн өвөрмөц ойлголт, категорийн хувьд хууль зүйн хариуцлагын шударга эсэхийн тухай асуудал нь олон нийт ард иргэдийн нийтлэг үзэл бодлыг харгалзан үзэхээс өөр

аргагүй зүйл.

Ийм учир манай нийгэм, олон түмний эрх ашиг сонирхолд жинхэнээсээ нийцэж буй тэр л зүйл шударга гэж үнэлэгдэх учиртай.

Үүнийг өнгөц ойлгож тодорхой асуудлыг хууль, шүүхээр шийдэхэд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан тэгэх нь зөв, ингэх нь зүйтэй гэж яаж шийтгэх талаар санал хэлэх нэрийдлээр дарамтлахыг оролдох, жагсаал цуглаанаар сүрдүүлэх, эсвэл аль нэгэн улс төрийн төлөөлөл, хүчин, хэн нэгэн "их мэдэгч" тэднийг хараан зүхэж, шударга бус хоцрогдсоноор нь дуудаж, нийгэмд онцгойрон тодорч ардын баатар болон дарамтлах гэсэн оролдлоготой адилгаж таарахгүй.

Ингэхийг эрх зүйн соёлтой аль ч оронд цээрлэдэг. Ер нь нийгэм хичнээн ардчилсан ил тод байлаа гэхэд хууль, хяналтынхны шийдвэл зохих тодорхой асуудлыг олон нийт урьдчилан шийдвэрлэх юм уу, шийдсэн хойно нь хэсэг, бүлгийн журмаар, аль эсхүл засаглалын өндөрлөгүүдээс болон "ард түмний шүүхээр" буруу зөрүүг зааж "хянаж үзэх, өөрчлөн зөвтгөх" тухай элдэв явуулга байх учиргүй.

Шударга ёсны энэ журам тус улсын хууль тогтоомжинд тод томруун тусгалаа олж хэрэгжихэд нэлээн цаг хугацаа, эр зориг шаардаж таарна. Ялангуяа, хууль цаазны хариуцлагын төрлүүд, тухайлбал, эрүүгийн, захиргааны,



сахилгын, иргэний хариуцлагын тухай холбогдох хуулийн заалт янз бүрээр нэрлэгдсэн ч чухам л энэ зарчмын утга агуулгыг бүрнээ илэрхийлж байх учиртай.

Тэгэхдээ бид хуульд заасан хариуцлага ял шийтгэлийн ерөнхий хэмжээнд л багтаж байгаа тэр бүхэн заавал шударга байна гэж туйлшруулан үзэж болохгүй биз.

Учир нь нэгдүгээрт:

Хуулийн зарим заалт нийгмийн шударга ёсны олон талт нарийн утга учир шаардлагатай зөрчилдөж болно. Эрх зүйн аль ч тогтолцоонд шударга ёсыг гагцхүү нарийвчлан заасан эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулна гэсэн ойлголт байж таарахгүй. Тиймээс аливаа хэрэг маргааныг хуульчлан шийдвэрлэхдээ эрх бүхий субъектэд, ялангуяа шүүх засаглалынханд эрх мэдлээс гадна нийгмийн шударга ёсыг чанд дээдлэх өргөн боломж олгох шаардлага улам бүр өсөж байна. Хэд хэдэн хууль ноцтой зөрчиж Эрдэнэтийн 49 хувийг зальт аргаар улс төржүүлэн хулгайлсан гэмт бүлэглэлийг “өмчөө аварсан шударга үйлстэн” мэтээр өөгшүүлэн өмгөөлөх, олон улсын хууль тогтоомж үл тоомсорлон улс орноо 100 гаруй сая долларын өрөнд унагасан Жаст.Батхүүгийнхэн гэгдэх эрх мэдэлтнүүдийн командыг улс төржүүлэн хамгаалж, албан тушаал, эрх мэдлээр шагнаж байхад хууль хяналтынхан маань гараа хумхин, “дээдсийн дохио зангаа” хүлээж

суугаа нь даанч өрөвдмөөр, даан ч харамсалтай.

Хуулийн хэм хэмжээний шийтгэл, хариуцлагыг тодорхойлсон хэсэг нь нэлээд тохиолдолд /Эрүүгийн хуулиар жишээ авъя/ нэгэн гэмт хэргийн төлөө хорих, албадан ажил хийлгэх, торгох ялын аль нэгийг оноох боломж бүхий, бас эд хөрөнгө хураах, тодорхой ажил эрхлэх эрхийг нь хасах нэмэгдэл ял хэрэглэхээр заасан байна.

Ийм сонгох ялтай үед дээрх “хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдлууд”-ыг ухаалагаар хэрэглэж чадваас холбогдох зүйл заалт ямар ч “дарамт шалгуурыг” даван гарах амьд үйлчлэл үзүүлж чадна.

Хоёрдугаарт:

Зарим зарга маргааныг хянаж үзэхэд уг асуудлыг яаж шийдэх тухай ямар ч хууль тогтоомжинд заагаагүй байх тохиолдол бий. Энэ нь эрүүгийнхээс бусад процесс ажиллагаанд цөөнгүй тохиолддог.

Тэгэхлээр эрхийн хэм хэмжээний заалт зөрчилтэй байх үед яах вэ? Хуулийн зүйл ангийн энэ олон сонгох шийдлийн чухам алиныг нь ямар хэмжээгээр оногдуулах вэ? гэсэн нарийн төвөгтэй, ээдрээтэй асуудлууд тулгарна. Чухам тийм үед л зарга, маргаан хагалагчийн мэргэн ухаан, шударга зан чанар, “оновчтой жишиглэл”, эрх зүйн мэргэшсэн ухамсар чухал үүрэгтэй.

Энэ бол зөвхөн хууль дээдлэн аль нэг нөгөө дарамтаас ангид



үйл ажилагаагаа явуулдаг эрх зүйт төрийн нэг гол шинж, Үндсэн хуулийн баталгаат шударга ёсны шалгуур мөнөөс мөн.

Үндсэн хуулийн байгуулал дахь эрх зүйн институтаас гаргаж буй хэм хэмжээ тогтоосон төдийгүй “нэг удаагийн хэрэглээний” гэгдэх ихэнх актууд Үндсэн хуулийн Цэцийн объектод хамрагддаг нь шударга ёсонд бүрнээ нийцдэг юм. Хяналтын объектыг манай эрдэмтэд Парламентын баталсан хууль, Ерөнхийлөгчийн зарлиг төдийгүй, Үндсэн хуулийн зүйл, заалтыг зөрчсөн бол Засгийн газрын бүхий л тогтоол, бүх шатны шүүхийн шийдвэрүүд байх учиртайг тэмдэглэсээр байна.

Үндсэн хуульд тусгагдсан асуудлууд зарчмын шинжтэй болохоос “тунхаглал” төдий мэтээр өнгөц ойлгож боломгүй. Зарим тохиолдолд өөртэй нь заавалчгүй нийцэж байх ёстой салбар хуулийг “даван” шууд үйлчлэх хүчин чадал Үндсэн хуульд бий. Жишээлбэл, гэрч, хохирогч ЭБШ хуулийн холбогдох зүйл заалтын дагуу “заавалчгүй мэдүүлэг өгөх” үүрэг хүлээж байсан бол Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т заасны дагуу “өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх” эрхийг эдлэх бүрэн боломж тэдэнд бий. Энэхүү хамгаалалтыг ойлгодоггүйгээс болж хэдэн арван гэрч нэг л мэдэхэд сэжигтэн, яллагдагч болон “хувирах нь” ЭБШ ажиллагааны практикт нилээдгүй тохиолдсоор ирсэн.

Иймээс ч “Үндсэн хуулийн шүүх шударга ёс, хууль дээдлэх ёсыг нийгэмд тогтоох замаар иргэний үндсэн эрхийг баталгаатай хангах нь өнөөгийн тулгамдсан асуудлын нэг мөн”¹³ гэсэн эрдэмтэн судлаачдын саналыг дэмжиж байна.

Үндсэн хууль нь чухамдаа тухайн улс орны цорын ганц, ямагт дээдлэгдэх эрх зүйн төдийгүй улс төрийн гол баримт бичиг. Тиймээс ч манаачид нь хүртэл “Хууль, улс төрийн өндөр мэргэжилтэй” байх шалгуурыг Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заан тодорхойлжээ.

Гэтэл “өөрөө шүүх засаглалын байгууллага учраас Цэцийн гишүүдийг нь зөвхөн хуульчдаас томилдог болгоё. Цэц байгуулагдсанаас хойш өнөөг хүртэл улс төрчид, төрийн захиргааны мэргэжилтэн хүмүүс Цэцийн гишүүнээр ажиллаж ирсэн” гэж зарим судлаачид шүүмжилдэг¹⁴.

Энэхүү болгоомжлолд маргаантай ч гэсэн үнэний хувь буйг үгүйсгэхгүй, гэхдээ Цэцээр хэлэлцэгдэж байгаа ихэнх асуудал улс төрийн өнгө аястай төдийгүй улс төржин “танигдахын аргагүй” болон хувирдаг нь нууц биш. Тиймээс ч энэхүү “холион бантан болсон хэцүү “субстанцыг” гагцхүү Үндсэн хуулиар тавигдсан

¹³ Монгол Улсын Үндсэн хуулийн Цэц / өгүүлэл, илтгэлийн эмхэтгэл/. УБ.2007 он, дэлгэрүүлэн үзнэ үү.

¹⁴ М.Батсуурь, Ч.Өнөрбаяр. Эрх зүйт ёс. УБ., 2011 он. Дэлгэрүүлэн үзнэ үү.



өнөөгийн шалгуурыг хангасан хос мэргэжилтэн л түүртэлгүй мэдэрч, хуулийн үндэслэлтэй, оновчтой, шударга шийдвэр гаргаж таарна.

Нөгөөтэйгүүр, улс төрийг хэт шүтэж түүнийг хуулиас ямагт дээгүүр байх ёстой мэтээр үздэг хуульч эрдэмтэд цөөнгүй байгаа нь нууц биш. Тухайлбал, нэрт эрдэмтэн Н.Лүндэндорж “Эрх зүй бол улс төрийн нэг институт. Эрх зүй нийгмийн харилцаанд зөвхөн хэм хэмжээгээр дамжуулан нөлөөлдөг бол улс төр нь маш олон чиглэл, арга хэрэгслээр, тухайлбал, — өнөөгийн зохист байдлыг хадгалах, маргаашийн эрх ашгийн /ямар?/ төлөө хэвлэл, мэдээллийн хэрэгслийг ашиглан хуурмаг тоглоом хүртэл хийж чаддаг”¹⁵ гэсэн нь судлаачдын анхаарлыг зүй ёсоор татаж байна. Гэхдээ энэ нь эрх зүйн хэм хэмжээний хуульчлагдсан хэлбэрээрээ зайлшгүй биелэгдэх мөн чанарыг дутуу үнэлсэн, эрх зүй улс төрөөс ангид бие даан орших, үйлчлэх хүчин чадалтайг эс хайхарсан, улс төр маань “хуурмаг” тоглоом хүртэл явуулдгаараа эрх зүйтэй байнга хослон үйлчилдэг шударга ёсны зарчмын “дайсан” болохыг тодруулсан юм шиг сөрөг ойлголт төрүүлж болзошгүйг анхаарахад илүүдэхгүй.

Үндсэн хуулийн хяналтын үндсэн зорилго нь улс төрийн өнгө аяс ямагт агуулагддаг Үндсэн хуулийн маргаант асуудлыг эрх зүйн хүрээнд

¹⁵ Н.Лүндэндорж. Эрх зүй судлал, философийн онол. УБ., 2011. 31 дэх тал

шийдвэрлэх, ингэснээрээ улс төрийн үйл явцыг үргэлж хуулийн хараа хяналтанд байлгах явдал юм.

Үнэхээр шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх хүрээнд хөндөгдсөн иргэний үндсэн эрхийг Үндсэн хуулийн Цэцийн хяналтанд оруулах, зөрчигдсөн үед хамгаалах эрх зүйн үндсийг бүрдүүлэх явдал өнөөгийн тулгамдсан асуудлын нэг яах аргагүй мөн. Чингэж чадваас Үндсэн хуулийн шүүх нь жинхэнэ утгаараа “газрын хөрсөнд бууж” тулгуур хуулийн бүхий л заалтыг эрх зүйн үүднээс хянах төрөлх “хувь заяа” нь танигдаж шударга ёсны шалгуурыг төвөггүй давах болно.

Үндсэн хууль, түүнд заасан үндсэн эрхийн талаархи заалтууд нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн шийдвэрийг хязгаарлах хүчин чадалтай байж гэмээж нь, дээрхи гурван эрх мэдлийн шийдвэр үндсэн эрхийг зөрчөөгүй байж гэмээж нь, зөрчсөн тохиолдолд Үндсэн хуулийн шүүх түүнийг сэргээж чаддаг байж гэмээж нь Үндсэн хууль бүхэлдээ шууд хэрэгждэг шууд үйлчилдэг шударга ёсны баталгаа бүхий эрх зүй болох юм¹⁶ гэсэн хууль зүйн шинжлэх ухааны доктор Ц.Сарантуяагийн ухаалаг “сануулгыг” онцлох нь зүйтэй биз.

¹⁶ Ц.Сарантуяа. Үндсэн хууль ба Үндсэн хуулийн шүүх МТЭЗ сэтгүүл. УБ., 2009 он. №1. 23 дахь тал.



ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГА БОЛ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ДАГУУ ОЛОН ТӨРӨЛТ ЭРХ ЗҮЙН ХАРИУЦЛАГА БОЛОХ НЬ



П.Эрдэнэбаатар

*ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн мөрдөх
албаны тэнхимийн багш, цагдаагийн
дэд хурандаа*

Abstract: According to Mongolian law administrative liability is a kind of legal liability.

Keywords: The administrative responsibility, An administrative offence, legal liability, Officials, The legal person, Jurisdiction, Punishment

Монгол улсын хөгжлийн чиг хандлага болж илрэх хүмүүнлэг, иргэншсэн, ардчилсан нийгэм бий болгохын тулд социал нийгмийн бүхий л хүрээнд ялангуяа төрийн удирдлагад ардчилалыг бий болгох ёстой.

Энэхүү ардчилалыг бий болгох үед монголын нийгмийн ёс зүйд болон амьдралын хэв маягт хууль тогтоомж, зөрчсөн аливаа хэлбэрийн илрэлийг үл тэвчих явдал нийт хүмүүсийн үндсэн шаардлага болсон.

Шинэчлэлийн үр дүнд монголчууд хязгааргүй эрх мэдэлт төрийн тогтолцооноос татгалзаж объектив эрхт нөхцөл байдал болон ардчилсан засаглал бий болгож байна.

Монгол Улсын Үндсэн хууль, хэм хэмжээг бүтээхдээ засаглалын үйл ажиллагааны үндсэн гол зарчим нь хуулийг сахих болон үндэсний эв нэгдлийг хангах, тэгш эрх, эрх чөлөө, шударга ёс, ардчилалыг сахина гэжээ¹.

Үндсэн хуулиар хүлээсэн хууль дээдлэх зарчим нь эрх зүйт засаглал бий болгох энэ ажиллагааны цөм болж илэрдэг. Энэхүү зарчим нь хуулийг чанд сахих, хуулиар хамгаалагдсан эрх ашиг сонирхлыг дээдлэх нь зөвхөн төр бус харин нийгэм, монгол улсын иргэн хангах ба мөн түүнчлэн төрийн сахилгыг бэхжүүлэх ажиллагаа юм.

Төрийн удирдлагын ардчилсан нийгэмд дэг журам бий болгох, хууль бүтээх, асуудал нь эрх зүйн

¹ Монгол Улсын Үндсэн хууль. УБ.,1992 он



соёлын түвшин, хүний эрхийн, ёс суртахууны болон улс төрийн ухамсарын түвшинг нийгмийн бүхий л хэсэгт дээшлүүлэхээс эхэлнэ. Мөн түүнчлэн материаллаг амьдралыг нь тасралтгүй дээшлүүлэхийг хангах явдал юм. Үүний тулд зохион байгуулалттай үндэсний иж бүрэн арга хэмжээ, хүний эрхийг хангах баталгааг хангахад чиглэгдсэн хууль зүйн, ёс суртахууны болон эдийн засгийн шинжүүдийг хэрэглэдэг.

Монгол улсын энэхүү тогтолцоо нь хууль зүйн хариуцлага бүхэлдээ захиргааны зарим хэсэгт чухал байр суурийг эзэлдэг.

Социал, түүхэн болон эдийн засгийн зарим нөхцлөөс объектив, субъектив, мөн зарим нэг өөр шалтгаанаас тодорхой улс төрийн тогтолцооноос хамаараад өөр өөр улс орнуудад "хариуцлага" гэдэг үг харилцан адилгүй утга санааг илэрхийлдэг.

Англи хэлэнд "хариуцлага", "хариуцлагатай" гэдэг үгнүүд "итгэл болон "нэр хүнд"² олж авах гэдэг утгыг илэрхийлдэг. Энэ нь нэг ёсондоо өөрийн үйл хэрэгт санаачлагатай байх, хариуцлагатай байж өөртөө итгэл найдвар авах утга юм.

Герман хэлэнд "хариуцлага" гэдэг нь 1-рт: хариуцлага ухамсарлах, 2-рт: хүн өөрөө ямар нэгэн юманд хариуцлагатай байх утгыг илэрхийлдэг.

² Большой англо-русский словарь. Советская энциклопедия. М., 1973.

Франц хэлэнд одоогийн болон ирээдүйн хариуцлагыг илэрхийлнэ. "Хариуцлага" нь хэтийн болон цаг үеийн хариуцлага урьдчилан тодорхойлогдох ба тэр нь эхлээд ямар нэг хариуцлагатай албан тушаал "хаших"³-тай, дараа нь хариуцлага, тухайлбал тодорхой зэмлэл, шийтгэл хүлээх-тэй холбоотой хэрэглэнэ.

Орос хэлэнд хариуцлага гэдэг ойлголт нь "зугтаах боломжгүй" өөрийн үйлдлийг хариуцах эсхүл "өөрийн үүрэг", "өөрийн нүглийн төлөө" эсхүл "ямар нэгэн зөрчил"⁴ гэсэн үг юм.

Монгол хэлний толь бичигт "хариуцлага" нь үйл үгээр тайлбарлагддаг "хувийн хариуцлага болон үүрэг"⁵ харин хууль зүйн хүрээнд хууль зөрчих гэж үздэг. Хариуцлага нь гүн утгаараа тухайн хүний нийгмийн байдлыг тодорхойлох, нийгмийн хөгжлийн процессд орлох хувь нэмэр, ингэснээр нийгэмдэх өөрийн үүргийг ухамсарладаг. Энэ онцлогоос харвал хариуцлага нь хүний зан үйлийг хянах, ёс суртахууны болон төрийн зохицуулалт болж зөвхөн өнөөдөр бус ирээдүйд ч илэрнэ.

Хариуцлага бол хууль зүйн категори бөгөөд хувь хүний, нийгмийн харилцааны тусгал юм. Энэ харилцаа нь хувь хүний, ёс суртахууны үүргээ болон эрх зүйн

³ Petit dictionnaire pratique Francaisnisme. М., 1973.

⁴ Ожерев.С.И. Словарь русского языка. М., Изд-во. Советская энциклопедия. 1973. 427 дахь тал.

⁵ Я.Цэвэл. Монгол хэлний тайлбар толь. УБ., 1966. 666 дахь тал.



хэм хэмжээгээ чанд сахих асуудалд хамаатай. Хариуцлага нь хоёр талтай зохион байгуулалтын болон төрийн-ёс суртахуун юм.

Зохион байгуулалтын тал нь бүтээлч шинж, хүний үйл ажиллагааны авьяас болон туршлага, түүнчлэн төрийн удирдлагын талбарт, өөрийн үүргийг ухамсарлахаар илэрдэг. Төрийн-ёс суртахууны тал нь хүн өөрийн үйлдлийг эцсийг ухамсарлах юм.

Ёс суртахууны хариуцлага нь нийгмийн хариуцлагын нэг бөгөөд хувь хүнээс өөрийн үүргийг сайн дураар, объективоор биелүүлэхийг шаарддаг.

Эрх чөлөөтэй болохын хэрээр хүний өөрийн үйл ажиллагааны хариуцлага нэмэгдэж байдаг. Төр засгийн зүгээс хэв журам болон сахилгыг зөрчигчдөд хариуцлага тооцохоос гадна хууль зөрчихөөс урьдчилан сэргийлэхийн тулд хууль зүйн хариуцлагыг гаргах, төрийн хуулийг биелүүлэх, хүндлэх талаар иргэдэд боловсрол олгох, хариуцлагад татах үндэс нь төрийн хуулиар тогтоогдсон байх ёстой. Үүнтэй хамт хууль зүйн хариуцлагын арга хэмжээ нь хүний нэр төр, алдар хүндийг гутаахад чиглэгдсэн байх ёсгүй бөгөөд хууль зүйн хариуцлага мэдээж хууль зөрчсөн үйлдэлтэй холбоотой байх ёстой.

Захиргааны эрх зүйн хэм хэмжээг зөрчсөнөөр захиргааны хариуцлагын асуудал үүсдэг. Дараах үндэслэлээр бусад хууль зүйн

хариуцлагаас ялгагдана.

Захиргааны хариуцлага эрүүгийн хариуцлагаас ялгагддаг. Захиргааны хариуцлага нь захиргааны зөрчил гаргасан эрх бүхий этгээд болон захиргааны байгууллагад хамааралтай.

Захиргааны хариуцлага нь сахилгын хариуцлагаас ялгагдана. Сахилгын хариуцлага нь хүлээсэн үүрэг эсвэл дотоод дүрэм, Монгол улсын хөдөлмөрийн тухай хууль болон сахилгын зөрчил гаргасан алба хаагч, ажилтанд хамаатай. Захиргааны хариуцлага нь байгууллагын тусгай эрх бүхий удирдлага, нийгмийн байгуулалт эсхүл түүний үүрэг бүхий алба хаагч, захиргааны хуулийн хэм хэмжээг зөрчсөн байна.

Материаллаг хариуцлагаас ялгагдана. Материаллаг хариуцлага нь иргэний эрх зүйд хэрэглэгддэг бөгөөд ихэнхдээ гэрээний үүргээ зөрчсөн, эсхүл иргэний эрх зүйн зөвшилцөл болон үл хөдлөх эд хөрөнгийн маргаантай холбоотой байна. Захиргааны хариуцлага нь гүйцэтгэх эрх мэдлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх процессын нийгмийн харилцааг зохицуулах үедээ захиргааны эрх зүйн хэм хэмжээг сахиагүй байдаг. Иргэний эрх зүйн хариуцлагын хэлбэр байнга материаллаг байдаг бол захиргааны хариуцлагын хэлбэр янз бүр байдаг.

Захиргааны зөрчилтэй тэмцэх процесс нь процессын хуулиар мөн түүнчлэн иргэний болон эрүүгийн



хэргээр шийддэг.

Орчин үед маш олон тусдаа захиргааны хэм хэмжээ хэрэглэгдэж байна.

Захиргааны хариуцлага нь захиргааны албадлагын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болж илэрдэг бөгөөд дараах зүйлээр ялгагдана. Үүнд:

Удирдах албан тушаалтаны хоорондын харилцаа дутмаг, эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэх гэм буруугийн асуудал нь ялгаатай байна.

Захиргааны зөрчил болон хариуцлага нь зөвхөн захиргааны хариуцлагын хуулиар бус бусад хуулиудаар мөн төрийн захиргааны эрх зүйн актаар тодорхойлогдоно.

Захиргааны хариуцлагад татахын тулд дараах үндэслэл зайлшгүй байх хэрэгтэй.

Захиргааны хариуцлагыг тодорхойлж буй эрх зүйн хэм хэмжээ

Захиргааны зөрчил, гаргагчид тооцох хариуцлагыг шийдвэрлэх эрх бүхий этгээд болон процессын үндэс шийтгэл нь бэлэн байх ёстой.

Төрийн эрх бүхий байгууллага хэрэгжүүлдэг хууль зүйн хариуцлагын бие даасан хэлбэр юм. Ийм янзаар захиргааны хариуцлага хууль зүйн хариуцлагын бие даасан хэлбэр болдог.

Захиргааны хариуцлагын тухай хуулинд захиргааны хариуцлага

гэсэн ойлголт бий. Захиргааны хариуцлага нь хууль зүйн хариуцлагын бие даасан төрөл бөгөөд эрх бүхий захиргааны байгууллага эрх мэдлээ ашиглаж захиргааны хуулийн хэм хэмжээг зөрчих үед ашиглана⁶.

Эрх бүхий захиргааны байгууллага захиргааны хариуцлагад татах ёстой хүмүүсийг хариуцлагад татдаг. Захиргааны байгууллагын шинж нь зөвхөн төрийн гүйцэтгэх байгууллага бус харин эрхгүй мөртлөө эрх олгогдсон байгууллага байж болно.

Захиргааны эрх зүйн хэм хэмжээ зөрчсөн үйлдэл захиргааны хариуцлагад татах үндэс нь захиргааны зөрчил үйлдснээр илэрнэ. Захиргааны хариуцлагын хуулийн дагуу захиргааны дэг журам бүгдэд нь бий болгодог.

Захиргааны хариуцлагад татах нь захиргааны зөрчил гаргагчдыг хариуцлагад татаж эмх цэгц бий болгодог. Өөрөөр хэлбэл, тухайн зөрчилд хариуцлага татах хэм хэмжээ байхгүй бол хариуцлага тооцож болохгүй юм.

Ийм янзаар, хууль зүйн үйлдлээр бие биетэйгээ тохиролцохоор илэрдэг эрх зүйн харилцааны хүрээнд “шалтгаан бол үр дүн” диалектик категорийн үндсэн хэлбэрээр илэрхийлэгддэг. Эдгээр ерөнхий шинж хууль зүйн хариуцлагын бүх төрөлд байдаг.

⁶ Ж.Сүхбаатар. Монгол Улсын Захиргааны эрх зүй УБ., 2001. 194 тал.



Хууль зүйн хариуцлагын албадлагын шинж нь эрх зүйн хэм хэмжээний арга хэмжээгээр хариуцлага тооцох болон хууль зөрчигчтэй хариуцлага тооцохоор илэрдэг. Ийм хариуцлагын шинж нь бүр төрийн удирдлагын эрх зүйн харилцаанд оролцогчдын талаас өөрсдийн үүргээ сайн дураар биелүүлсэн байсан ч бодитойгоор хадгалагдаж байдаг.

Үүнээс үзэхэд эрх зүйн харилцаа үүсэж дуусгавар болох хүртэл хууль зүйн хариуцлага бодитойгоор оршин тогтнодог. Хууль зүйн хариуцлага хууль зөрчих явдал хүртэл субъектив үүргээр илэрдэггүй, харин хууль зөрчигчийн үйл ажиллагаагаар бус эсхүл эсрэг үйл ажиллагаа бий болсны дараа нэмэлт үүрэг дахин бий болох үед илэрдэг.

Энэхүү үүрэг нь өөрийн шинжээс болж хууль зөрчигчдөд сөрөг үр дагавар бий болгдог, төрийн удирдлагаар түүнийг хэрэгжүүлдэг.

Хууль зүйн хариуцлагын нэг онцлог бол төрийн албадлага хэрэглэж болдогт байдаг. Бүх төрлийн эрх зүйн хэм хэмжээнд төрийн албадлага хэрэглэгддэг. Гэхдээ энэ нь бүх эрх зүйн хэм хэмжээ бүхэн өөртөө хариуцлагыг багтаана гэсэн үг биш юм.

Төрийн албадлага хэрэглэх гарцаагүй тохиолдол нь хууль зөрчсөнтэй холбоотой урган гардаг.

“Монгол Улсын захиргааны хариуцлагын тухай хууль” 1992

оны 12 дугаар сарын 15-наас эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээр захиргааны албадлагын арга хэмжээ, түүний дотор хариуцлага, шийтгэлийн төрөл, хэмжээг нарийвчлан тогтоож, захиргааны зөрчил гаргагчид захиргааны хариуцлага хүлээлгэхтэй холбогдон үүссэн харилцааг зохицуулах болсон.

Энэ хуулиар зохицуулагдах нийгмийн харилцааг цаашид улам өргөтгөн, захиргааны зөрчил ба хариуцлага, захиргааны зөрчлийн тухай хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг бүхэлд нь иж бүрэн тусгасан төрөлжсөн хуулийн төсөл боловсруулж Монгол Улсын Их хурлын чуулганд хэлэлцүүлэхээр оруулсан байна.

Гэвч энэ төрөлжсөн хуулийн төсөл Монгол Улсын Улсын Их хурлын чуулганаар хэлэлцэгдсэнгүй удаж байна.

Үүнээс дүгнэн үзвэл:

Монгол Улсын захиргааны хариуцлагын тухай хуулинд олон удаагийн нэмэлт өөрчлөлт орж сүүлийн үед салбарын бараг бүх хуулиар захиргааны хариуцлага, шийтгэл ногдуулах нь олширсоор байна.

Сүүлийн жилүүдэд монгол улсад захиргааны хариуцлага хүлээлгэх эрх бүхий албан тушаалтны хүрээ нэмэгдэн тэлэх, улмаар тэдний хууль хэрэглэх ажиллагаанд тавигдах хяналтын механизм сайжрах бус,



харин ч сулрах, бас захиргааны хариуцлага, шийтгэлийн үр нөлөө дээшлүүлэх тухай асуудал хуульч, судлаачдын анхаарлын гадна байх хандлага ажиглагдаж байгаа нь төдий л таатай зүйл биш болж байна.

Улс орон нутаг, салбарын хэмжээнд захиргааны зөрчлийн нэгдсэн тоо бүртгэл хөтлөгддөггүй, нөгөө талаас захиргааны албадлага

хэрэглэхтэй холбоотой хүний эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн халдашгүй байдал ихээр хөндөх боловч түүнд судалгаа, дүн шинжилгээ хийдэггүй, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө төр хариуцах эрх зүйн механизм учир дутагдалтай зэрэг сөрөг хүчин зүйл болж байгааг анхаарахгүй байж боломгүй юм.

Ашигласан эх сурвалж:

- Монгол Улсын Үндсэн хууль. УБ.,1992 он.
- Большой англо-русский словарь. Советская энциклопедия. М., 1973.
- Petit dictionnaire pratique Francais-russe. М.,1973.
- Ожегов.С.И. Словарь русского языка. М., Изд-во. Советская энциклопедия. 1973.
- Я.Цэвэл. Монгол хэлний тайлбар толь. УБ., 1966 он.
- Ж.Сүхбаатар. Монгол Улсын Захиргааны эрх зүй УБ., 2001он.
- П. Эрдэнэбаатар, Я. Цэлмэн, Правовые основы административной ответственности должностных лиц в Монголии. УБ., 2015 он



МОНГОЛ УЛС ДАХЬ ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН НӨХЦӨЛ, ТҮҮНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ



Ч.Чинзориг

Замын цагдаагийн албаны Чингэлтэй дүүрэг дэх Замын цагдаагийн хэлтсийн тасгийн дарга, цагдаагийн хошууч

Товч хураангуй: Энэхүү өгүүлэлд Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн чиглэлээр гаргаж буй статистик тоо, мэдээлэл, түүний бүтэц, гарч буй осол, зөрчлийн хэлбэр шалтгаан нөхцөл, осол, зөрчлийг бууруулах арга замын талаар товч авч үзлээ.

Abstract: This article about Mongolian's traffic accident's statistic of conflict, information, organization, degrade to accident's causes, conflicts.

Түлхүүр үг: Замын хөдөлгөөний аюулгүй байдал, зам тээврийн

осол, зөрчил, статистик тоо, мэдээ, хохирол, хор уршиг, тээврийн хэрэгсэл, ослын шалтгаан, нөхцөл

Keyword: Traffic security, traffic accident, conflict, result of statistics, information, damage, harm, transport, cause of accident, condition.

Үндсэн хэсэг: Дэлхий дахинд зам тээврийн ослын улмаас жилд 1.2 сая гаруй хүн амь насаа алдаж, 50 сая гаруй хүн бэртэж, гэмтэн хөгжлийн бэрхшээлтэй болж байгаагийн зэрэгцээ 5-29 насны хүүхэд, залуучуудын үхлийн үндсэн шалтгаан нь зам тээврийн осол болж байна.

Зам тээврийн осол нь зүрхний шигдээс, сэтгэлийн дарамтын дараа хүн амын нас баралтын гурав дахь гол шалтгаан болох төлөвтэй байгаа бөгөөд зам тээврийн ослоор нас барагсдын 90 гаруй хувь нь буурай болон хөгжиж байгаа улс оронд ногдож, жилд нийт 65 тэрбум ам. долларын хохирол учирч байгааг НҮБ-аас онцлон тэмдэглэж, 2010 онд Ерөнхий Ассемблейн хуралдаанаас 2011-2020 оныг "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын жилүүд" болгон зарлаж 64/255 дугаар тогтоолыг гаргаж, зам тээврийн ослыг эрс багасгаж, нас баралтыг 50 хувиар бууруулах зорилтыг дэвшүүлсэн.¹

¹ Засгийн газрын 2012 оны 146 дугаар тогтоол. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратеги (2012-2020 он)



Түүнчлэн 2010 онд Тайланд Улсын Бангкок хотод зохион байгуулагдсан Ази, Номхон далайн нийгэм, эдийн засгийн комиссын Бүс нутгийн замын хөдөлгөөний шинжээч нарын уулзалтаар улс орон бүрт зам тээврийн ослын нас баралтыг бууруулах "Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зөвлөмж"-ийг гаргасан байдаг.

Монгол Улсад зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүний шалтгаан нөхцлийг тогтоон урьдчилан сэргийлэх чиглэлээр олон ажил хийж хэрэгжүүлж ирсэн билээ.

2016 онд улсын хэмжээнд бүртгэж шалгасан 46712 зам тээврийн ослын 45508 буюу 97.4 хувь нь жолоочийн буруугаас, 1166 буюу 2.5 хувь нь явган зорчигчийн буруутай үйлдлээс, 38 буюу 0.1 хувь нь замын нөхцлөөс гарсан гэж бүртгэгджээ.

Зам тээврийн осол, зөрчлийн статистик мэдээг үнэн зөв, хурдан шуурхай гаргах нь энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцлийг судлан тогтоож, түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг зөв, оновчтой зохион байгуулах нэг чухал хүчин зүйл болох тул статистик мэдээлэл гаргах нь хариуцлагатай ажлын нэг билээ.

Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик мэдээллийн бүтэц

Монгол Улс дахь зам

тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлтийг дараах дэс дарааллаар гарган дүн шинжилгээ хийж тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтыг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлтийг дараах дэс дарааллаар боловсруулан гаргаж байна. Үүнд:

Нэг. Тээврийн хэрэгслийн тоо

1. Монгол улсад 1929- 2014 онд бүртгэгдсэн автомашины тоо
2. Тээврийн хэрэгсэл, автомашины өсөлт
3. Автомашины ашиглалтын байдал
4. Улсын хэмжээний тээврийн хэрэгсэл, автомашины тоо / аймаг, нийслэлээр/
5. Тээврийн хэрэгслийн төрөл
6. Монгол улсад бүртгэгдсэн автомашины жолооны хүрдний байрлал

Хоёр. Зам тээврийн осол

1. Зам тээврийн ослын холбогдолтой дуудлага
2. Зам тээврийн ослын холбогдолтой дуудлага (Нийслэлийн дүүргээр)
3. Бүртгэгдсэн зам тээврийн осол
4. Зам тээврийн ослын ангилал
5. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг
6. Зам тээврийн ослын олон жилийн дундаж өсөлт бууралт



(2005-2014)

Гурав. Зам тээврийн осол гарсан шалтгаан

1. Улсын хэмжээнд зам тээврийн ослын шалтгаан
2. Жолоочийн буруутай үйлдлээс гарсан зам тээврийн осол
3. Эрүүгийн гэмт хэрэгт холбогдсон жолоочийн нас, хүйс, боловсрол, нийгмийн байдал
4. Явган зорчигчийн буруутай үйлдлээс гарсан зам тээврийн осол
5. Замын нөхцөл ба техникийн гэмтлийн улмаас гарсан зам тээврийн осол

Дөрөв. Зам тээврийн ослын улмаас учирсан хохирол

1. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас нас барсан, гэмтсэн хүн
2. Зам тээврийн осолд өртсөн хүний нас, хүйсийн байдал
3. Амь насаа алдсан хүмүүсийн биеийн гэмтэл авсан хэсгүүд
4. Гэмт хэргийн улмаас улсын хэмжээнд гэмтсэн хүний гэмтлийн зэрэг
5. Зам тээврийн осолд өртөх үедээ жолооч, тээврийн хэрэгслээр зорчигчдын хамгаалах бүс хэрэглэсэн байдал.
6. Зам тээврийн ослын улмаас хохирсон хүмүүсийн замын хөдөлгөөнд оролцож байсан хэлбэр
7. Зам тээврийн ослын улмаас

иргэд, аж ахуй нэгж байгууллагад учирсан хохирол

Тав. Зам тээврийн осол гарсан хэлбэр

1. Улсын хэмжээнд бүртгэгдсэн зам тээврийн ослын хэлбэр
2. Нийслэл, орон нутагт зам тээврийн осол гарсан хэлбэр

Зургаа. Зам тээврийн осол гарсан улирал, сар, гариг, цаг, зам орчин, цаг агаар

1. Зам тээврийн осол гарсан улирал
2. Зам тээврийн осол гарсан сар
3. Зам тээврийн осол гарсан гариг
4. Зам тээврийн осол гарсан цаг, хугацаа
5. Зам тээврийн осол гарсан зам орчин, цаг агаарын нөхцөл байдал

Долоо. Зам тээврийн осолд холбогдсон тээврийн хэрэгслийн төрөл

1. Улсын хэмжээнд бүртгэгдсэн зам тээврийн осолд холбогдсон тээврийн хэрэгслийн төрөл

Найм. Хүүхэд өртсөн зам тээврийн осол

1. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас нас барсан, гэмтсэн хүүхэд.
2. Зам тээврийн осолд өртсөн хүүхдийн нас, хүйс
3. Хүүхэд зам тээврийн осолд өртөх үедээ замын хөдөлгөөнд оролцсон хэлбэр
4. Хүүхэд өртсөн зам тээврийн осол гарсан гариг.



5. Хүүхэд өртсөн зам тээврийн осол гарсан цаг.

Ес. Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үед

1. үйлдэгдсэн зам тээврийн осол, зөрчил
2. Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсоноос гарсан осол.
3. Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил.

Арав. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчсөн захиргааны зөрчил түүний шийдвэрлэлт

1. Улсын хэмжээнд илэрсэн захиргааны зөрчил.
2. Захиргааны арга хэмжээ авсан байдал

Арван нэг. Жолоочийн тоон үзүүлэлт

1. Монгол улсад жолоодох эрх олгосон байдал /2005-2014 он/
2. Жолоодох эрхтэй хүмүүсийн нас, хүйсийн байдал
3. Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн ангилал

Арван хоёр. Зам тээврийн осол гарсан замын байршил

1. Нийслэлд осол их бүртгэгдсэн замын байршил
2. Авто замын аюултай, осол гэмтлийн онцгой бүсүүдийн жагсаалт

Арван гурав. 100.000 хүнд ногдох зам тээврийн ослын харьцангуй үзүүлэлтүүд

1. 100.000 хүнд ногдох зам тээврийн ослын нас баралт
2. 100.000 хүнд ногдох зам тээврийн ослын харьцангуй үзүүлэлтүүд
3. 10.000 тээврийн хэрэгсэлд ногдох нас баралт, зам тээврийн осол
4. Дэлхийн улс орнуудын 100.000 хүнд ногдох нас баралт²

Улсын хэмжээнд 2016 онд бүртгэгдсэн зам тээврийн ослын тоон үзүүлэлтэд хийсэн дүн шинжилгээ

Зам тээврийн ослын шалтгааныг:

- Жолоочийн буруутай үйлдэл
- Явган зорчигчийн буруутай үйлдэл
- Замын нөхцөл
- Техникийн гэмтэл гэж ангилан авч үзэж байна.

Зам тээврийн гэмт явдлын шалтгаан, нөхцөлд хүн, тээврийн хэрэгсэл, зам-орчны олон хүчин зүйл хамаардаг гэж шинжлэх ухааны түвшинд томъёолон авч үздэг байна.

2016 онд бүртгэгдсэн зам тээврийн нийт ослын 97.4 хувь нь жолоочийн буруутай үйлдэл буюу жолоочийн хууль, дүрэм зөрчсөн, сахилга хариуцлагагүй үйл ажиллагаатай холбоотой гэсэн статистик мэдээ байна. Энэ онд бүртгэгдсэн зам тээврийн ослын шалтгааныг өмнөх 2015 онтой харьцуулан авч үзвэл:

² Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт 2016 УБ.,



А/д	Он	Жолоочийн буруугаас	Замын нөхцлөөс	Явган зорчигчийн буруугаас	
1	2015	Улсын хэмжээнд	43570	49	1542
		нийт осолд эзлэх хувь	96.5	0.1	3.4
		Нийслэлийн хэмжээнд	39906	14	1467
		нийт осолд эзлэх хувь	96.4	0.1	3.5
2	2016	Улсын хэмжээнд	45508	38	1166
		нийт осолд эзлэх хувь	97.4	0.1	2.5
		Нийслэлийн хэмжээнд	40256	25	1094
		нийт осолд эзлэх хувь	97.3	0.1	2.6

Зам тээврийн осол, гэмтлийн шалтгаан түүнээс урьдчилан сэргийлэх арга зам нь улс орон бүрт өвөрмөц байх боловч ерөнхий зарчим нь адил байна. Зам тээврийн осол гэмтлийн гол эрсдэлтэй / шалтгаан/ хүчин зүйлүүд нь:

- Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ автомашин жолоодох
- Хамгаалалтын бүс, малгай хэрэглэхгүй байх,
- Хурд хэтрүүлэх
- Замын аюулгүй байдал хангалттай биш байх зэрэг байна

Зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, осол гэмтэл түүний үр дагаврыг бууруулах тодорхой үйл ажиллагаануудыг хэрэгжүүлж үр нөлөөг тооцох нь

чухал байдаг.

Энэ үйл ажиллагаанд хурд хэтрүүлэх болон согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодохыг бууруулах, мотоциклын хамгаалалтын малгай, суудлын даруулга, хүүхдийн хамгаалалтын хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлэх арга хэмжээнүүд багтдаг байна.

Зам тээврийн ослын шалтгааныг өнгөрсөн онд бүртгэгдсэн ослын шалтгаантай харьцуулан үзвэл жолоочийн буруутай үйлдлээс шалтгаалсан осол 4.4 хувийн өсөлттэй, явган зорчигчийн буруутай үйлдлээс гарсан осол 24.4 хувиар, замын нөхцлөөс шалтгаалсан осол 22.4 хувийн бууралттай байна.

2015 оны жолоочийн буруутай үйлдлээс гарсан ослын үзүүлэлттэй харьцуулан үзвэл согтуугаар үйлдэгдсэн осол 23.5 хувиар буурсан байхад явган зорчигч согтуугаар замын хөдөлгөөнд оролцсоноос үүдэлтэй осол 13.7 хувиар өсчээ.

Монгол Улсад замын хөдөлгөөнд оролцогчдод мэдлэг, хандлага, дадлыг олгох механизм байхгүй учраас замын хөдөлгөөнд оролцогчдын мэдлэг хангалтгүй, мэдсэн ч биелүүлэхийг хүсдэггүй байдал үргэлжилсээр байна.

Жолооч замын хөдөлгөөний дүрмийг тодорхой хэмжээгээр судалсан байхад замын хөдөлгөөнд оролцогч явган зорчигч, тээврийн хэрэгсэлээр зорчигч нь замын хөдөлгөөний дүрэмд заасан эрх,



үүргээ судлах боломжгүй, түүний талаар мэдлэг дутмаг, мэдлэг олж авах боломж бололцоо байхгүй гэж хэлж болохоор, сургуулийн өмнөх насны болон сургуулийн насны хүүхдүүдэд Замын хөдөлгөөнд оролцох мэдлэг, замын хөдөлгөөний боловсролыг олгож, зөв оролцох дадлыг эзэмшүүлэх шаардлагатай байна.

Жолоочийн буруутай үйлдлээс шалтгаалсан зам тээврийн осол

2016 онд бүртгэгдсэн зам тээврийн ослын шалтгааны 97.4 хувь нь жолоочийн буруутай үйлдлээс үйлдэгдсэн үзүүлэлт гарч байна. Уг шалтгааныг нарийвчлан авч үзвэл:

- хажуу хоорондын зай тохируулаагүйгээс 23767 буюу 50.9%,
- уулзвар гарц нэвтрэх журам зөрчсөн 7030 буюу 15.0%
- эгнээ байр буруу эзэлсэн 5250 буюу 11.2%
- ухрах үйлдэл буруу хийсэн 2766 буюу 5.9 хувийг эзэлсэн байна.

Өмнөх нийгмийн тогтолцооны үед буюу 1975-1995 онд бүртгэгдсэн жолоочийн буруутай үйлдлээс шалтгаалсан ослын тоо баримтаас харахад жолоочийн буруутай үйлдэл дотроо хурд хэтрүүлэх, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох, анхаарал болгоомжгүй /холын замд автомашин жолоодож байгаад нойрмоглох/-гээс гарсан осол давамгайлж байсан байна.

Тэр үеийн зам тээврийн ослын шалтгааныг өнөөгийн буюу 1996-2016 онд гарсан зам тээврийн ослын

шалтгаантай харьцуулан авч үзэхэд жолооч архи согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох, анхаарал болгоомжгүй хөдөлгөөнд оролцох, хурд хэтрүүлэхээс гаргасан осол өнөөг хүртэл хэвээр байгаа ба энэ шалтгааныг арилгах асуудал нэн чухал нь харагдаж байна.

Хурд хэтрүүлэх нь олонхи улс орны зам тээврийн осол гарах үндсэн хүчин зүйл болдог ба энэ нь шинэ, залуу жолооч нартай холбоотой байна. Хурдыг 10км/цаг-аар бууруулахад зам тээврийн осол 4-5 хувь буурдаг гэж олон улсад үздэг байна.

Осол гарах үед автомашины хурд 30 км/цаг түүнээс бага хурдтай байхад осолд өртсөн явган зорчигч /бусад оролцогчид/-ын авсан гэмтэл нь үхэлд хүргэх эрсдэлд хүргэдэггүй. Өөрөөр хэлбэл автошинаар хурд багатай явах тусам хохирол бага учирдаг байна.

Анхаарал болгоомжгүй замын хөдөлгөөнд оролцох нь автомашин жолоодон замын хөдөлгөөнд оролцож буй жолооч нь гар утсаар ярих, нүүрээ будах /эмэгтэйчүүд/, тамхи асаах, хүүхэдтэйгээ зууралдах зэргээр анхаарал сарнихад жолоочийн хөдөлгөөн удаашрах, гэрэл дохио анхаарахгүй, эгнээ байр эзлэхдээ бусдыг анзаарахгүй байх, хажуу хоорондын зайг тохируулахгүй байх зэргээр жолоочийн ур чадварт нөлөөлдөг байна.

Ослын шалтгааныг судлан авч үзвэл хот болон орон нутгийн замд



гарч байгаа зам тээврийн осол, зөрчил хоорондоо ялгаатай байдал ажиглагдаж байна.

Улаанбаатар хотод:	Орон нутагт:
Хажуу хоорондын зай тохируулаагүй	Хажуу хоорондын зай тохируулаагүй
Уулзвар гарц нэвтрэх журам зөрчсөн	Анхаарал болгоомжгүй хөдөлгөөнд оролцсон
Эгнээ байр буруу эзэлсэн	Зогсоох арга хэмжээ аваагүй
Ухрах үйлдэл буруу хийсэн	Хурд хэтрүүлсэн
Анхаарал болгоомжгүй хөдөлгөөнд оролцсон	Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон
Бусад	Бусад

Улсын хэмжээнд хурд хэтрүүлсэнээс бүртгэгдсэн ослын 67.7 хувь нь орон нутгийн замд гарсан осол байхад согтууруулах ундааны зүйл хэрэглэснээс шалтгаалсан ослын 60,3 хувь нь нийслэлийн замд гаржээ.

Жолоочийн буруутай үйлдлээс гарсан ослын шалтгааныг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулан авч үзвэл, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсоноос шалтгаалсан осол 30 хувиар, хурд хэтрүүлсэнээс 48 хувиар буурсан байхад бүрэн бус тээврийн хэрэгсэлээр хөдөлгөөнд оролцсоноос шалтгаалсан осол 18.4 хувиар, аюул саад тулгарсан үед зогсоох арга хэмжээ аваагүй 27.6 хувиар, анхаарал болгоомжгүй хөдөлгөөнд оролцсон осол 8.4 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй гарчээ.

Явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан осол

Замын хөдөлгөөний дүрмийг биелүүлэх, хэрэгжүүлэх нь зөвхөн жолоочид биш замын хөдөлгөөнд оролцогч³ явган зорчигч⁴, тээврийн хэрэгсэлээр зорчигчид ч хамааралтайг Замын хөдөлгөөний дүрэм, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулинд зааж өгсөн байдаг. Явган зорчигчийн буруугаас шалтгаалсан ослын хэлбэрээр нь ангиллан авч үзвэл:

явган хүний гарцын шугам, гарамгүй газраар зам хөндлөн гарах

- гэрлэн дохио зөрчиж зам хөндлөн гарах
- ойртон ирж яваа тээврийн хэрэгслийн урдуур зам хөндлөн гүйх
- зогсож буй автомашины урдуур буюу автобусаас буугаад урдуур нь замын зорчих хэсэгт орох
- замын зорчих хэсэг дээр буюу зорчих хэсгийн захаар дагаж явах
- согтууруулах ундааны зүйл хэрэглэж биеэ авч явах чадваргүй үедээ замын зорчих хэсэг дээгүүр явах, хэвтэх

³ Замын хөдөлгөөний дүрэм. "Замын хөдөлгөөнд оролцогч" гэдэг нь замаар яваа жолооч, явган зорчигч болон тээврийн хэрэгсэлээр зорчигчийг хэлнэ. Явган зорчигч нь жолоочийн нэгэн адил замын хөдөлгөөнд оролцогч

⁴ Замын хөдөлгөөний дүрэм. Явган зорчигч-замаар явган яваа /зам дээр ажил, үүрэг гүйцэтгэж байгаагаас бусад/ хүн. Жагсаалаар яваа болон тахир дутуу хүний тэргэнцэртэй, мөн тэрэг түрж, чарга чирч, мотоцикл, мопед, унадаг дугуйг хөтөлж замаар яваа хүмүүсийг явган зорчигчид хамааруулна



- замын голоор тавьсан тусгаарлах хайс, хашлага дээгүүр давах, доогуур нь шургах
- замын хөдөлгөөнд оролцохдоо анхаарал болгоомжгүй оролцох /зам хөндлөн гарахдаа гар утсаар ярих, чихэвчний хөгжим сонсох, мессеж бичих/
- сургуулийн өмнөх насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулах /эцэг эх, асран хамгаалагчийн буруугаас/ зэргээс автомашинд дайрагдах, мөргөгдөх хэлбэрээр хохирох тохиолдол бүртгэгдсэн байна.

Явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан зам тээврийн осол 2016 онд улсын хэмжээнд 1166 буюу нийт бүртгэгдсэн осолд 2.5 хувийг, явган зорчигч өртсөн осолд 42.9 хувийг эзэлсэн байна.

Явган зорчигч амь насаа алдсан нь явган зорчигчийн өөрсдийн буруутай үйлдлээс шалтгаалсан 32 хэргийг хэргийг хэрэгсэхгүй болгосон байна. Дээрх тоон үзүүлэлтээс харахад явган зорчигчдын замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг дутмаг, замын хөдөлгөөнд соёлтой оролцохыг хүсэхгүй, тэдэнд оногдуулах хариуцлага хэрэгжихгүй байгаагаас явган зорчигч амь насаа алдах, гэмтэл бэртэл авч хохирч байна.

Явган зорчигчдын замын хөдөлгөөнд оролцож байгаад хяналт тавих, тэдний замын хөдөлгөөнд оролцох мэдлэг, дадлыг дээшлүүлэх,

жолооч нарт замын хөдөлгөөний дүрмээ биелүүлэх дадал, хандлагыг бий болгох сэтгэл зүйн сургалт, мэдээлэл, сурталчилгаа явуулахад анхаарал хандуулах зайлшгүй шаардлагатай байгаа нь 2016 онд замын хөдөлгөөнд оролцож яваад 148 явган зорчигч амь насаа алдсан тоон үзүүлэлтээс харагдана.

Улсын хэмжээнд 2016 оны байдлаар 380 ослын тохиолдолд явган зорчигч согтуугаар /согтуу зам дээр хэвтэх, унтах, автомашин зогсоох гэж байгаад ойчих, зорчих хэсэг дээр бие засах, гарцгүй газраар автомашины урдур тэнцвэрээ олохгүй гүйх, унах/ замын хөдөлгөөнд оролцож амь нас, эрүүл мэндээрээ хохирчээ.

Явган зорчигч согтуугаар замын хөдөлгөөнд оролцсон нь нийт явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан ослын 32.6 хувийг эзэлжээ.

Түүнчлэн замын нөхцөл, техникийн гэмтлээс шалтгаалсан зам тээврийн осол шалтгаан нь дараах нөхцөл байдлаас үүдэлтэй гэж үзэж байна. Тухайлбал:

Замын нөхцөл:

- Замын гадаргуу, нөхцөл
- Замын гэрэлтүүлэг, чимэглэл
- Замын тэмдэг, тэмдэглэгээ ойлгомжгүй байснаас
- Бусад гэж ангилан авч үзэж байна.

Техникийн гэмтэл саатал:

- Жолоочоос хамааралгүй техникийн гэмтэл /жолооны



хүрд гацах, тоормос гэнэт барихгүй болох, гэрэл дохионы саатал, хөдөлгүүрийн гэмтэл гэх мэт/ үзүүлэлтийг тооцож байна.

Замын нөхцөл: Замыг шинээр барьж байгуулах, засварлахдаа технологийн шаардлагыг чанд мөрдөж иж бүрнээр /замын инженерийн байгууламж, хөдөлгөөн зохицуулах хэрэгсэл гэх мэт/ нь шийдвэрлэж байх шаардлагатай гэж олон улсад үздэг байна. Зам-орчин нь өөрөө замын хөдөлгөөний нэг бүрдэл болдог.

Замын нөхцлөөс шалтгаалан гарсан осол улсын хэмжээнд 38 бүртгэгдсэнээс нийслэлд 25, орон нутагт 13 байна. Дээрх хүчин зүйлд техникийн гэмтэл, гадны гэрэл /замын гэрэл/, зам орчны нөхцлийг багтаан авч үзэж байгаа ч авто зам, замын байгууламж хариуцсан байгууллагад ослын акт тавигдаж арга хэмжээ тооцсон бүртгэл хангалтгүй байгаагаас замын нөхцлөөс гарсан ослын үзүүлэлт бага бүртгэгдсэн хэвээр байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдал, шуурхай байх үндсэн нөхцлийн нэг нь зам, замын дэд бүтэц байдаг. Замын эвдрэл, гэмтэл нь хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөө үзүүлж, зам тээврийн осол, хэрэг гарах шалтгаан нөхцлүүдийн нэг болдог байна.

Өнөөг хүртэл замын эвдрэл гэмтэл, онгорхой нүх, овоолсон шороо, зузаан мөстсөн замын хэсэг, замын бусад хангалтгүй нөхцлийг

тойрох гэсэн автомашины жолооч хөдөлгөөний чиглэлээ гэнэт өөрчлөх, тойрч эсрэг урсгалд орсноос гарсан ослын тохиолдолын бурууг жолооч, бусад хөдөлгөөнд оролцогчдод хариуцуулж байна.

Замын нөхцлөөс шалтгаалсан зам тээврийн ослын хохирлыг тухайн зам, байгууламжийг хариуцсан байгууллага, аж ахуйн нэгж бүрэн хариуцдаг учраас энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллага, аж ахуйн нэгжийн хариуцлага маш өндөр байдаг гэж Европын Хөдөлгөөний аюулгүй байдлын асуудал эрхэлсэн тээврийн хорооны тайланд дурьджээ.

Замын хөдөлгөөнд оролцогчдод сайхан зам дотроо аюулгүй зам хэрэгтэй байдаг учир замын байгууламж хариуцсан албад, гадна талбай, зогсоолын талбай зэрэг нийтэд үйлчлэх эзэмшлийн зам, талбайгаа цэвэрлээгүйгээс уг байгууллагын эзэмшлийн газарт замын нөхцлөөс үүдэлтэй осолд аж ахуйн нэгж байгууллагад хариуцлага хүлээгэвэл зам, замын нөхцөл нь чанарын өндөр түвшинд хүрэх нэг механизм болно гэж судлаачийн хувьд үзэж байна.

Замын стандарт, нөхцөл муу, тээврийн хэрэгслийн чанар хангалтгүй (86% нь 10-с дээш жилийн насжилттай) манай оронд бүх зам тээврийн ослын шалтгааныг жолоочийн буруу хэмээн явцуу хүрээнд хариуцлага оногдуулах байдлаар шийдвэрлэж байгаа нь тогтолцооны хувьд онцгой анхаарах



асуудлыг нэг гэж үзэж болох юм. Дэлхийн өндөр хөгжилтэй улс орны бодлогод зам тээврийн осол гарахгүй байх "нөхцөл"-ийг хангах, бүрдүүлэхэд түлхүү чиглэж байгаа бол манай улсад нөхцөлөө хангалттай бүрдүүлэхгүйээр "хяналт тавих, хариуцалага тооцох" чиглэл давамгайлж байна.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн автомашин мөргөлдсөн зам тээврийн ослын хэлбэр

Улсын хэмжээнд тээврийн хэрэгсэл тээврийн хэрэгсэлтэй мөргөлдөх, шүргэлдэх хэлбэрээр дийлэнх буюу 41959 гарсан нь нийт тохиолдлын 89.8 хувийг эзэлж байна. Нийслэлийн болон орон нутагт бүртгэгдсэн ослын хэлбэрийг тус бүрээр нь авч үзвэл:

Улаанбаатар хотод:

- Мөргөлдөх -38055 буюу 92.0%
- Явган зорчигч мөргөх –2442 буюу 5.9%
- Онхолдох – 127 буюу 0.3%
- Зорчигч унагах – 33 буюу 0.1%
- Дугуйтай хүн мөргөх- 126 буюу 0.3%
- Тээврийн хэрэгсэлээр үл хөдлөх зүйл мөргөх- 552 буюу 1.3 %

Орон нутагт:

- Мөргөлдөх – 3904 буюу 73.1%
- Явган зорчигч дайрах – 277 буюу 5.2%
- Онхолдох – 753 буюу 14.1%
- Зорчигч унагах – 20 буюу 0.4%
- Дугуйтай хүн мөргөх- 9 буюу 0.2%
- Тээврийн хэрэгсэлээр үл хөдлөх зүйл мөргөх –219 буюу 4.1%

- Мал амьтан дайрах - 155 буюу 2.9 хувь тус тус бүртгэгдсэн байна.

Дээрхи хэлбэрүүдийг нэгтгэн авч үзвэл нийслэл хотод автомашин мөргөлдөх, явган зорчигч мөргөх хэлбэрээр дийлэнх зам тээврийн осол гарсан, орон нутагт автомашин мөргөлдөх, онхолдох хэлбэрээр осол гарсан нь харагдаж байна..

Хүүхэд өртсөн зам тээврийн осол

Улсын хэмжээнд 2016 онд хүүхэд өртсөн зам тээврийн осол 1087 бүртгэгдсэн үүнээс тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг 274 гэмт хэрэг бүртгэгдсэн байна.

Гэмт хэргийн улмаас улсын хэмжээнд нийт 50 хүүхэд амь насаа алдаж, 1065 хүүхэд гэмтэж, бэртсэнээс 255 хүүхэд хүнд, хүндэвтэр гэмтэл авчээ. Улсын хэмжээний үзүүлэлтийг өнгөрсөн онтой харьцуулахад нас барсан хүүхэд 7.0 хувиар, гэмтсэн хүүхдийн тоо 0.4 хувиар буурчээ.

Гэмт хэргийн улмаас нас барсан хүүхдийн 90 хувь буюу 45 хүүхэд орон нутгийн замд амь насаа алдсан байна. Зам тээврийн осолд өртсөн хүүхдүүд ихэвчлэн гэр, сургууль, цэцэрлэг гэсэн маршрутаар явж байгаад зам тээврийн осолд өртдөг байна.

Энэ маршрутаар явахдаа анхаарал болгоомжгүй хөдөлгөөнд оролцох, зам хөндлөн гарахдаа гарц, гарамтай хэсгээр гарахгүй байх,



асран хамгаалагчгүй хөдөлгөөнд оролцох, ойртон ирж буй тээврийн хэрэгслийн урдуур гүйх зэргээр өөрсдийн замын хөдөлгөөний мэдлэг дутмагаас осолд өртдөг хэдий ч жолоочийн хариуцлагагүй үйлдэл, замын байгууламжаас хамаарч осолд өртөх явдал байна.

Гэмт хэргийн улмаас нийт нас барсан хүний 12.5 хувийг, нийт гэмтсэн хүний 18 хувийг хүүхэд эзэлж байна. Зам тээврийн осолд өртсөн хүүхдийн 38,4 хувийг 0-7 хүртэл насны хүүхэд, 46.6 хувийг 8-14 насны хүүхэд, 15 хувийг 15-17 насны хүүхэд эзэлсэн байна. Зам тээврийн осолд өртсөн хүүхдийн хүйсийн байдлаас үзэхэд 39.8 хувь нь эмэгтэй, 60.2 хувь нь эрэгтэй хүүхдүүд зам тээврийн осолд илүү өртөж байна.

Бүртгэгдсэн зам тээврийн осолд өртсөн хүүхдийн 68.7 хувь нь явганаар, 27.1 хувь нь тээврийн хэрэгслээр зорчигч, 4.2 хувь нь унадаг дугуйгаар замын хөдөлгөөнд оролцож байхдаа осолд өртөж хохирсон байна.

Хүүхдийг замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулахад зайлшгүй шаардлагатай зүйлсийн нэг автомашин доторх аюулгүй байдлыг хангаж хүүхдийн зориулалтын хамгаалах бүс, хамгаалалтын суудал хэрэглэж хэвших, зөв тээвэрлэхээс хамааралтай юм. Ослын улмаас амь насаа алдсан хүүхдийн 90 хувийг орон нутагт бүртгэгдсэн осол эзэлж байна.

Нийслэлд осолд өртсөн хүүхдүүд нь явганаар хөдөлгөөнд оролцогч хүүхдүүд байгаа нь цэцэрлэг, сургуульд бага насны хүүхдүүдэд замын хөдөлгөөний мэдлэг, боловсрол олгох, замын хөдөлгөөнд зөв оролцох хандлага, дадал хэвшээгүйтэй холбоотой гэж үзэж байна.

Нийслэлд осолд өртсөн хүүхдүүдийн 72.6 хувь нь явган зорчигч, 22.8 хувь нь тээврийн хэрэгслээр зорчигч, 4.6 хувь нь унадаг дугуйгаар зорчигч хүүхэд байна. 2016 онд унадаг дугуйгаар зорчигч хүүхдүүд зам тээврийн осолд өртсөн тохиолдол 67.9 хувиар өссөн байна.

Нийслэлд хүүхэд өртсөн ослын судалгаанаас үзвэл: явганаар замын хөдөлгөөнд оролцож гэмтсэн хүүхдийн 31.5 хувь нь насанд хүрсэн харгалзах хүнтэй замын хөдөлгөөнд оролцсон бол 62.8 хувь нь харгалзах хүнгүй ганцаараа, 5.7 хувь нь насанд хүрээгүй найз, ах, эгч дүү нартайгаа хөдөлгөөнд оролцож зам тээврийн осолд өртсөн байна.

Хүн бүр замын хөдөлгөөнд явганаар оролцдог учир хүүхдийг багаас нь замын хөдөлгөөнд ялангуяа явганаар хөдөлгөөнд оролцох мэдлэг, хандлага, дадлыг эзэмшүүлэхэд илүү анхаарал хандуулах шаардлагатай байна.

2016 оны байдлаар зам тээврийн ослын үзүүлэлтүүд улс, нийслэлд буурсан үзүүлэлттэй байна. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай шинэчилсэн хууль



хэрэгжиж хуулийн арга хэмжээ, торгуулийн дүн өссөн, жолоочийн зөрчлийн оноо тооцох журам 2016 оны 2 дугаар сарын 01-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбон үзэж байгаагийн зэрэгцээ гудамж замын болон камерын хяналт тавьж байгаа нь үр дүнд хүрч байна.

Дүгнэлт

Монгол Улсад бүртгэгдсэн зам тээврийн ослын шалтгаан нөхцлөөс харахад жолоочийн буруутай үйлдлээс ослын дийлэнх хувийг эзэлсээр байна. Жолоочийн буруутай үйлдэл дотроо хажуу хоорондын зай тохируулаагүй, эгнээ байр, уулзвар гарц нэвтрэх журам зөрчсөн, ухрах үйлдэл буруу гүйцэтгэснээс гарсан осол давамгайлж байна.

Хурд хэтрүүлсэн болон согтууруулах ундааны зүйл хэрэглэснээс шалтгаалсан зам тээврийн осол буурсан үзүүлэлттэй ч орон нутагт согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн, мөн хурд хэтрүүлсэнээс гарсан осол нилээдгүй хувийг эзэлж байна.

Түүнчлэн замын стандарт, нөхцөл муу, тээврийн хэрэгслийн чанар хангалтгүй (86% нь 10-с дээш жилийн насжилттай) манай оронд бүх зам тээврийн ослын шалтгааныг жолоочийн буруу хэмээн явцуу хүрээнд хариуцлага оногдуулах байдлаар шийдвэрлэж байгаа нь тогтолцооны хувьд онцгой анхаарах асуудал гэж үзэж байна.

Дэлхийн өндөр хөгжилтэй улс орны бодлогод зам тээврийн

осол гарахгүй байх “нөхцөл”-ийг хангах, бүрдүүлэхэд түлхүү чиглэж байгаа бол манай улсад нөхцөлөө хангалттай бүрдүүлэхгүйгээр “хяналт тавих, хариуцлага тооцох” чиглэл давамгайлж байна.

Мөн хүүхэд өртсөн зам тээврийн осол өнгөрсөн оны үзүүлэлтээс өссөн байгаа нь цэцэрлэг, сургуулийн насны хүүхдийн тоо урьд оныхоос ихэссэнтэй шууд холбож байна. Зам тээврийн осолд өртсөн хүүхдүүд ихэвчлэн “гэр-сургууль-цэцэрлэг” гэсэн маршрутаар замын хөдөлгөөнд оролцох, зам хөндлөн гарахдаа зорчих хэсгийн гарц, гарамтай хэсгээр зам хөндлөн гарахгүй байх, асран хамгаалагчгүй хөдөлгөөнд оролцох, ойртон ирж буй тээврийн хэрэгслийн урдуур гүйх зэргээр зам тээврийн осолд ихээхэн өртөж хохирч байна.

Орон нутгийн замд хүүхдийн хамгаалалтын бүс, хамгаалалтын суудал хэрэглэж хэвшээгүй, хэрэглэхгүй байгаагаас тээврийн хэрэгслээр зорчигч хүүхдүүд амь насаа алдсаар байна.

Орон нутагт хүүхдүүд тээврийн хэрэгслээр зорчиж байх үедээ амь насаа алдаж байгааг амь насаа алдсан хүүхдийн 88,9 хувь нь орон нутгийн замд гарсан ослоос шалтгаалжээ. Хүүхдийн зориулалтын суудал хэрэглэж хэвшсэнээр нярай хүүхдийг зам тээврийн осол гэмтлээс 70 хүртэл хувиар, бага болон өсвөр насны хүүхдийг 54-80 хүртэл хувиар бууруулах боломж харагдаж байна.

Явган зорчигчийн замын



хөдөлгөөний дүрмийн мэдлэг дутмаг, замын хөдөлгөөнд соёлтой оролцдоггүй, согтуугаар хөдөлгөөнд оролцож байгаа нь зам тээврийн ослын хохирогч болсоор байна. Явган зорчигчид хүлээлгэх хариуцлагын тогтолцоог нэг мөр зохицуулж өгөхгүй бол явган зорчигч замын хөдөлгөөнд зөв оролцох хандлага, дадал эзэмшихгүй байна.

Сүүлийн үед зорчигчийн хөдөлгөөнд оролцох эрх, үүргийг тодорхой зааж өгөх, сургалт явуулах, мэдээлэл ихээр өгөх, дугуйгаар зорчих замыг тодорхой болгох гэх мэтчилэн асуудлуудыг хөндөх нь зүйтэй.

Цаашид орон тоо, хүн хүчний асуудлыг шийдвэрлэн судалгааны ажилтан, судалгааны баг ажиллаж зам тээврийн осол, зөрчлийн нөхцөл байдлын судалгааг социологийн болон асуумж, тооллого гэх мэт аргачлалаар хийж ослын нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгөх зайлшгүй шаардлагатай байна.

Санал

Дээрх асуудлыг нэгтгэн авч үзээд Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлтэнд дүн шинжилгээ хийж, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, бууруулах ажлыг үр дүнтэй зохион байгуулах, хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын гэмт хэргийн гаралт түүнээс үүдэн гарах хор уршиг, хохиролыг бууруулахад чиглэгдсэн бодлого боловсруулан, төлөвлөх, зохицуулалт хийх үүднээс

дараах саналыг дэвшүүлж байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомжид замын хөдөлгөөнд оролцох явган зорчигчдод хүлээлгэх хариуцлагыг нарийвчлан тодорхойлж оруулан тусгаж өгөх;

Бага насны хүүхэд харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцсоны улмаас осол, зөрчилд орсон тохиолдолд эцэг эх, харгалзан дэмжигчдэд нь хүлээлгэх хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх;

Дугуйгаар зорчих замыг шинээр байгуулж, эрх зүйн орчныг бүрдүүлэх ажлыг эхлүүлэх;

Ашигласан ном зүй

Хууль тогтоомж

- Монгол Улсын Үндсэн хууль
- Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хууль
- Монгол Улсын засгийн газрын 153-р тогтооль

Ном, сурах бичиг, гарын авлага

- Монгол улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт 2010-2015 он
- МУИС Статистикийн онол 2011 он
- МУИС Статистик анхан шат + excel програм 2014 он
- МУИС Нийгмийн статистикийн үндэс 2002 он

Бусад эх сурвалж

- Замын цагдаагийн албаны ажлын тайлан
- Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тайлан 2015



ЭВТАНАЗИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТУЛГАМДСАН АСУУДАЛ



*А.Сугармаа
Магистрант*

Хувь хүний оршин буй эгэл амьдралын цар хүрээнээс хальсан бүх нийтийн буюу нийгмийн анхаарал хандуулах ёстой асуудлууд өнөө хэр дэлхий нийтэд оршсоор байна.

Эдгээрээс яах аргагүй анхаарал хандуулбал зохих асуудлуудын нэг бол эвтанази бөгөөд энэ нь өөрөө нийгэм—эрх зүйн орчинд буй эмзэг сэдвүүдийн нэг юм.

Ёс суртахууны үүднээс хүний амьдралын үнэ цэнийг хамгаалах асуудал (цаазаар авах ял, үр

хөндөлт, хүнийг хувилан олшруулах г.м.) нь хүний нийгмийн цаашлаад даяарших орчин цагийн ярвигтай асуудал юм. Улс орон болгон эдгээр асуудлуудад өөр өөрийн байр сууринаас хандаж үзэл бодлоо илэрхийлэхийн хажуугаар зохих шийдэлд хүрэх арга замуудыг мөн хайсаар иржээ.

Тийм ч учраас эвтанази нь өнөө хэр анагаах ухаан-ёс зүйн, шашин-зан заншлын болоод хууль зүйн салбаруудын хүрээнд “Зөвшилцөлд” хүрээгүй байгаагаас хуульч, эмч, улс төрч, шашны зүтгэлтнүүдийн хооронд үзэл бодлын маргаантай сэдэв хэвээр байна. Хүмүүний амьдрал бол ариун нандин, халдашгүй дархан гэж нэг хэсэг нь үзэж байхад нөгөө хэсэг нь амьдрал өөрөө зовлон шаналалын улмаас утга учраа алдах ёсгүй хэмээн мэтгэлцдэг. Euthanasia гэдэг нь эртний Грек гаралтай үг ба Eu нь сайн сайхан, thanatos нь үхэл гэсэн утгатай юм.

Монголын Улсын эрүүл мэндийн тухай хууль болон эмнэлгийн эрх зүйн бусад актуудад эвтаназийг хориглосон заалт байхгүй, эмчилгээнээс татгалзах эрхийг нээлттэй байдлаар зохицуулсан атлаа эрүүгийн эрх зүйн үүднээс авч үзвэл эвтаназид хориглосон



утга агуулгыг илэрхийлсээр ирсэн. Хэрэв эмч үйлчлүүлэгч буюу түүний ойр дотны хүмүүсийн зөвшөөрлийн дагуу эвтанази хийвэл Монгол улсын 2002 оны эрүүгийн хуулийн 91.1-д зааснаар онц хүнд гэмт хэрэг өдүүлсэнд тооцогдож 10-15 жилийн хорих ял авах болно. Улсын Дээд Шүүхийн 2010 оны нэгдсэн тайлбарт хохирогчийн зөвшөөрөлтэйгээр түүний амь насыг егүүтгэснийг энэ зүйл хэсгээр зүйлчилж байхаар тусгажээ. Эрх зүйн орчны талаарх эмч, эмнэлгийн ажилтан болон үйлчлүүлэгчдийн асран хамгаалагчдын мэдлэг, хандлагыг тодорхойлж Анагаах ухаан, хууль зүйн талаас нэгдсэн ойлголт нэн шаардлагатай байгаа өнөө цагт тусгайлсан судалгаа хийж дүгнэлт хийх нь чухал.

Эвтаназийн эрх зүйн зохицуулалт, харьцуулсан эрх зүйн судалгааг явуулсны үр дүнд эмч, эмчлүүлэгчид болон тэдний ар гэр, асран хамгаалагчийн эвтаназийн талаарх мэдлэг, хандлага болон тулгамдсан асуудлыг тодорхойлох, эрх зүйн шалгуур үнэлгээний эргэлтэнд оруулах шаардлагатай байна.

Үүний тул:

Эмч нарын эвтаназийн талаарх мэдлэг, ёс зүйн болон эрх зүйн хандлагыг тодорхойлох;

Практикт эмч нар эвтаназийн тохиолдлыг хэрхэн шийдвэрлэж буйг түүвэрлэн судалж, эвтаназийн тулгамдсан асуудлыг тодорхойлох;

Эдгэршгүй архаг өвчний төгсгөлийн шатанд буй үйлчлүүлэгч болон түүний хууль ёсны асран хамгаалагч нарын эвтаназийн талаарх ойлголт, ёс зүйн болон эрх зүйн хандлагыг үнэлэх, тулгамдсан асуудлыг гаргаж тавих

Эвтаназийг эрүүгийн эрх зүйн судлагдахуун болгож авч үзэх, бусад институттай харьцуулах улмаар уг ойлголтын нийгмийн хор аюулыг үгүйсгэх учир шалтнааныг тодруулах

Эвтаназид хамаарах үндэсний эрх зүйн зохицуулалтыг олон улсын эрх зүйн заалтуудтай харьцуулан судлах нь нэн тэргүүнд тавигдах зорилт юм.

Эвтаназийн эрх зүйн зохицуулалтыг Нидерланд, Бельги, Швейцар, Франц, Герман, Люксембург, АНУ-ын Калифорни, Орегон, Колорадо, Вермонт, Монтана, Вашингтон, Австралийн хойд бүс, Израйль, Япон, Мексик, Энэтхэг, Румын, Сингапур, Итали, Ирланд болон ОХУ, тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн орнуудыг жишиг болгон авч үзэв.

Эдгээр орнуудаас Голланд, Бельги, Люксембургийн вант улс болон Швейцарь нь дэлхий дээр идэвхтэй эвтаназийг албан ёсоор зөвшөөрсөн орон юм. Харин европын бусад орнууд болох Франц, Германд, Унгар, Норвеги, Австри, Дани (1992он), Испани, Швед(2010), Чех, Япон, Энэтхэг, Колумб нь идэвхгүй эвтаназийг хуульчилсан байна.



2001 онд эвтанадийг Нидерланд улсад хуульчилж өгснөөр тус улсын Эрүүгийн хуулийн 293.2, 294.2 дугаар зүйлүүдэд өөрчлөлт орж шинэ эрүүгийн хууль, мөн эвтанадийн тухай акт "Termination of life on Request and Assisted suicide"¹ нэрээр 2002 оны 4 сарын 1-нээс мөрдөгдөж байгаа бөгөөд Нидерланд улсад хүүхдэд эвтаназийг гүйцэтгэхдээ эмч "Гронингены протокол"² –ийг баримталдаг.

Бельги улс анх 2002 онд Бельги улс эвтаназийг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэж үзсэн³ бөгөөд 18 насанд хүрсэн байх шалгууртай хуульчилж байсан бол 2017 оны 2 сард хүүхдэд эвтанази хийхийг зөвшөөрсөн байна⁴.

Швейцарьт эмнэлгийн нөхцөлд эвтаназийг гүйцэлдүүлэхийг 2005 оноос зөвшөөрсөн юм. Мөн дараах нь буюу 2007 оны 2 сарын 5-нд эдгэршгүй хүнд өвчтөнүүдээс гадна сэтгэцийн хүнд өвчтөнүүдэд эвтаназийг зөвшөөрсөн хууль батлагджээ. Швейцарьт сүүлийн үед "үхлийн жуулчлалын" урсгал ихсэх хандлагатай болсон бөгөөд Telegraph⁴-д өгүүлснээр бол 2009 онд

Швейцарийн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын зүгээс "үхлийн жуулчлал"-ыг зогсоох болоод эвтаназийг хэт туйлшруулахаас сэргийлэх зорилгоор зарим нэг хуулийг чангатгасан байна.

АНУ-д XIX зууны 70-аад онуудад эвтаназийн асуудал хөндөгдөж байсан боловч түүнийг эсэргүүцэгч талуудын нөлөөлөл хүчтэй байсны улмаас дэмжигдээгүй иржээ. Ингээд 1977, 1998, 2009, 2013 болон 2016 онуудад АНУ-ын зургаан мужид (Калифорни, Орегон, Вашингтон, Монтана, Колорадо) эвтаназийг хуульчилсан байна.

АНУ-ын мужуудаас 1977 онд Калифорнид Эвтаназийн тухай хууль батлагдсан боловч уг хууль батлагдсанаас хойш Калифорнид нэг ч удаа эвтаназийн тохиолдол бүртгэгдээгүй байна. Яагаад гэвэл эвтаназийг гүйцэтгэхийн тулд сэтгэцийн эмчийн дүгнэлтийг үндэслэх ёстой. Гэтэл Америкийн Сэтгэцийн эмч нарын Холбооны зүгээс сэтгэцийн эмч нарыг эвтаназийн асуудалд оролцохыг эрс хоригложээ. Өөр нэг нөхцөл нь эвтаназийг зөвхөн мэргэжлийн эмч хийх ёстой. Америкийн Эмч нарын холбооноос "Эмч бол алуурчин биш" хэмээн тунхагласантай холбогдуулан тэд эвтаназийг гүйцэтгэх эрхгүй болжээ.

АНУ-д эвтаназийн асуудлаар хийгдэж буй эрх зүйн зохицуулалт нь тухайн мужаас шалтгаалаад өөр өөр байдаг. 1997 онд гарсан АНУ-

¹ Termination of life on Request and Assisted suicide, <http://www.nvve.nl/assets/nvve/english/euthlawenglish.pdf>

² New England Journal of Medicine, The Groningen Protocol - Euthanasia in Severely Ill Newborns, Volume 352:959-962

³ Loi relative a l'euthanasie (The Act concerning Euthanasia), 28 May 2002, in force 23 Sept 2002

⁴ <https://sites.psu.edu/mehealth/2015/04/06/international-perspectives-on-euthanasia/>

⁴ Telegraph сэргүүл «Switzerland aims to stop 'suicide tourism'» от 29.10.200943 <https://sites.psu.edu/mehealth/2015/04/06/international-perspectives-on-euthanasia/>



ын дээд шүүхийн тайлбарт: “Үндсэн хуулинд хууль зүйн үндэслэл бүхий амиа егүүтгэлийг зөвшөөрсөн горимын цогц байхгүй, мөн түүнчлэн эвтаназийг хуульчлах нь ч хууль бус үйл ажиллагаа биш юм”⁵ гэжээ. АНУ-н олонх мужуудад эвтаназийн талаарх хуулийн төсөл няцаагдсан боловч, зөвхөн Орегон мужид энэ хуулийг дэмжиж баталсан байна. Анх эвтаназийн тухай тогтоолын төслийг “Death with Dignity Act” нэрээр 1994 онд санаачилж байсан хэдий ч энэ нь 1998 онд тогтоол болон батлагдаж хэрэгжиж эхэлсэн юм⁶.

Харин Орегонд Эвтаназийн хууль анх батлагдан гарсан жилд буюу 1998 онд нийт 15 эвтаназийн тохиолдол (нийт үхлийн 0.05%) гарсан. Энэ тоо аажимдаа өссөөр 2004 он гэхэд жилд 37 тохиолдол буюу мужийн хэмжээнд нийт үхлийн 0.12%-ийг эзлэх болсон байна.

Өнөө үед АНУ-ын Орегон, Колорадо, Вермонт, Монтана, Калифорни болон Вашингтонд эвтаназийг хэрэгжүүлж байна. Вашингтонд 2009 оны 3 сарын 5-ны өдөр эдгэршгүй хүнд өвчтэй үйлчлүүлэгчийн өвчин шаналалыг ангижруулах үүднээс эм, тариа хэрэглэж үхлийг түргэсгэх зөвшөөрлийг эмч нарт олгосон байна.

Мексикт идэвхтэй эвтанази

зөвшөөрөгдөөгүй боловч 2008 оны 1 сарын 7ны өдрөөс хуульд эдгэршгүй өвчтэй хүн өөрөө хүсвэл, ухамсарт ухаангүй хүний ойрын хамаатан амьдрал тэтгэж буй аппаратнаас салгах буюу эмчилгээг зогсоохыг зөвшөөрснөөр идэвхгүй эвтаназийг зөвшөөрчээ. 2009 оны 9 сарын 1ний өдрөөс Мексикийн баруун бүсийн Мечоаканд идэвхгүй эвтаназийг зөвшөөрсөн.

Израйльд хуулийн төсөл анх 2002 онд боловсруулагдсан ба 2003 онд Кнессет урьдчилсан байдлаар хэлэлцэж, хуулийн төслийг төгөлдөржүүлж боловсронгуй болгох парламентын ажлын хэсгийг эрүүл мэндийн салбарын болон хуулийн салбарын хамтарсан байдлаар томилсон байна. 2005 оны 12 сард Израилийн Кнессет (парламент) өвчтөний Зохиомол амьсгалын аппаратанд 12 цаг тутамд идэвхжүүлэлт хийдэг цагийн тохиргоо бүхий механизм суурилуулах тухай зааж улмаар өвчтөний өвчин шаналал эдгэршгүй гэж оношлогдсон тохиолдолд өвчтөний болоод түүний хууль ёсны төлөөлөгчийн хүсэлтээр амьсгалын аппаратыг гар ажиллагааны горимд шилжүүлж, улмаар үйлчлүүлэгчийн зохиомол амьсгалыг зогсоох тухай хуулийг баталж гаргажээ.

Францын сенатаас 2004 онд эвтаназийг хуульчилсан байна. Тухайн үед хуулийн төслийг Францын эмч нарын холбооноос санаачилж сенатад өргөн барьсан ба хуульд зааснаар бол эдгэршгүй

⁵ Washington at al v Glucksberg 117 SCt 2258 (1997) SCt 2293 (1997)

⁶ <http://egov.oregon.gov/DHS/ph/pas/docs/statute.pdf>



хүнд өвчтөний хүсэлтээр амьдралыг дэмжиж буй эмчилгээг зогсоож болох талаар заажээ. Хэрэв үйлчлүүлэгч ухаангүй, тархины бор гадар үхжсэн, ухамсарт үйл ажиллагаа байхгүй байгаа тохиолдолд түүний ойрын төрөл төрөгсөд нь шийдвэр гаргаж болох талаар мөн тусгасан байна. Харин үйлчлүүлэгч насанд хүрээгүй тохиолдолд эмч нарын зөвлөлгөөнөөр асуудлыг шийдэхээр заажээ.

Австралид Эвтаназийн тухай хуулийн төсөл "Rights of the terminally ill act"⁷ нэрээр анх 1995 онд гарч, 1996 оны 7 сарын 1-нээс Австралийн хойд бүс нутагт хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн, гэвч жил хагасын дараа энэ хуулиа хүчингүй болгожээ. Хууль хэрэгжих энэ богино хугацаанд австралийн эмч Филип Ницшке эвтаназийн үхлийн машиныг зохион бүтээжээ. Эдгэршгүй хүнд өвчтэй хүн компьютертэй тоглох ба хожигдсон тохиолдолд компьютер: "Тоглоомыг дуусгах уу?" гэж асуудаг байна. Ингээд зөвшөөрсөн хариултын дараа үйлчлүүлэгчийн венийн судсанд үхлийн тунг тарих дохио электрон машинд очдог байна.

Португалд аль алийг нь зөвшөөрөхгүй ч тодорхой тохиолдолд эмчилгээг зогсоохыг зөвшөөрдөг.

Японд 1962 онд эвтаназийг хуульчилж өгсөн боловч амьдрал

дээр түүнийг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй асуудлууд ихээр тулгардаг.⁸

Энэтхэгийн дээд шүүхээс 42 жил ургамлын амьдралаар буюу ухамсарт ухаангүй комын байдалд байсан өвчтөний амьдрал тэтгэх эмчилгээг зогсоохын тулд идэвхгүй эвтаназийг 2011 оны 3 сарын 7-ны өдөр хүлээн зөвшөөрч идэвхгүй эвтаназийн удирдамжийг баталжээ. Энэ удирдамжинд зааснаар идэвхгүй эвтанази гэдэг нь тухайн өвчтөний амьдралыг тэтгэж буй эмчилгээ болон аппаратыг салгахыг хэлэх бөгөөд эвтанази хийх шийдвэрийг өвчтөний эцэг эх, эхнэр/нөхөр, ойрын хамаатан, тэдгээрийн хэн ч байхгүй бол өвчтөний найз эсвэл эмчлэгч эмч гаргаж болно.

2016 оны 6 сарын 17-ны өдрөөс Канадад эвтаназийг хуульчилж зөвшөөрсөн бөгөөд эхний 7 сарын байдлаар 740 гаруй хүн эвтанази хийлгэсэн байна.

ХБНГУЛсад идэвхгүй эвтаназийг 2009 оны зунаас Германд албан ёсоор зөвшөөрчээ. Уг хуулийн дагуу бол идэвхгүй хэлбэрийн эвтаназийг зөвшөөрснөөс бус харин идэвхтэй эвтанази буюу эмчийн тусламжтайгаар нас барахыг хориглосон байна.

ОХУ болон Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн орнуудаас одоогоор албан ёсоор эвтаназийг

⁷ "Rights of the terminally ill act" <http://www.nt.gov.au/lant/parliament/committees/rotti/illregs.pdf>

⁸ Крылова Н.Е. Уголовное право и биоэтика: проблемы, дискуссии, поиск решений. - Инфра-М, Москва, 2006.



хүлээн зөвшөөрсөн улс байхгүй, мөн судалгаанд хамрагдсан эдгээр ойрхи дорнодын арван хоёр орнуудаас зөвхөн гурван орны эрүүгийн хуульд эвтаназийн тохиолдолд харьцангуй хөнгөн шийтгэл оногдуулахаар заасан болохыг тогтоов.

Мөн эдгээр орнуудын (Азербайджан 27-р зүйл, Армен 17-р зүйл, Беларус 24-р зүйл, Грузин 15-р зүйл, Казахстан 15-р зүйл, Молдов 24-р зүйл, ОХУ 20-р зүйл, Украин 27-р зүйл г.м.) үндсэн хуулиудад хүний амь насыг сайн дураар егүүтгэхийг хориглосон юм.

Украины иргэний хуулийн 4-р зүйлийн 281-т зааснаар бол “хүсэлтээр нь хүний амийг егүүтгэхийг хориглоно”, мөн Эрүүл мэндийн тухай хуулийн 52-т зааснаар эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд идэвхтэй болоод идэвхгүй эвтаназийг гүйцэтгэхийг хориглосон байна.

Беларусын Эрүүл мэндийн тухай хуулийн 38 дугаар зүйлд мөн эвтаназийг хориглосон заалт байдаг бол Казахстаны Эрүүл мэндийн тухай хуулийн 27 дугаар зүйлд мөн адил эвтаназийг хоригложээ.

Хамтын нөхөрлөлийн арван хоёр орноос зөвхөн Азербайджан (ЭХ-ийн 135) болон Грузин улсууд (ЭХ-ийн 110) эрүүгийн хуулиараа эвтаназийг тусгайлан зохицуулсан бол бусад арван оронд эвтаназийг хүнийг санаатай алах гэмт хэргээр зүйлчилдэг байна.

Итали, Грек, Босниа, Серби, Польш, Унгар, Хятад, Румын, Шотланд, Англи болон Ирланд зэрэг оронд эвтаназийг зөвшөөрдөггүй хэрэв хийвэл хүнийг санаатай алах гэж үздэг. Эвтанази хийвэл дараах байдлаар хорих ял оногдуулдаг байна.

- Ирланд болон Италид 14-15 жил
- Англи, Их Британид амиа хорлоход нь туславал 14 жил, эвтанази хийвэл бүх насаар
- Монголд 10-15 жил
- ОХУ-д 6-15 жил хүртэл
- Австралид 10 жил хүртэл
- Румынд 10 жил хүртэл
- Сингапурт 1 жилийн хорих ял тус тус оногдуулдаг байна.

ХБНГУ-д идэвхгүй эвтанази зөвшөөрдөг бөгөөд идэвхтэй эвтанази хийсэн тохиолдолд 5 хүртэл жилийн хорих ял оноодог.

Дүгнэлт

Нэг. Судалгаанд Улаанбаатар хотын гуравдугаар шатлалын нийт ХСҮТ, УХТЭ, болон ГССҮТ 3 эмнэлгийн эрчимт эмчилгээ, хөнгөвчлөх эмчилгээ болон мэс заслын тасгийн эмч нар, хөнгөвчлөх эмчилгээ, үйлчилгээ үзүүлдэг Грийн Хоум хоспис, Бриллиант хосписын нийт 33 эмч нар хамрагдсан.

Судалгаанд хамрагдсан нийт эмч нар өнөөгийн нийгэм дэх эмнэлгийн эрх зүйн тулгамдаад буй асуудлуудын нэг болох эвтаназийн



талаар хангалттай мэдлэг(79%) мэдээлэлтэй(91%) байна.

Судалгаанд хамрагдсан нийт эмч нарын 76% нь эвтаназийг ёс зүйд нийцтэй, 88% нь нийгэмд хэрэгтэй зүйл хэмээн үзэж байна.

Монгол улсад цаашид эвтаназид эрх зүйн зохицуулалт хийх шаардлагатай гэж 91% хариулсан бөгөөд хуульчилсан тохиолдолд эвтаназийг 73% нь дэмжихээ илэрхийлсэн дүн гарч байна.

Хоёр. Судалгаанд хамрагдсан нийт эмч нарт эмнэлгийн тусламж үйлчилгээний явцад эвтаназитай холбоотой зарим бэрхшээл тулгардагийг онцолсон үүнд:

- Өвчтөн амиа егүүтгэх оролдлого хийж байсан 9%
- Өвчтөний зүгээс өөрт эвтанази хийлгэх хүсэлт тавьж байсан 30%
- Өвчтөний ар гэрийнхэн эвтанази хийлгэх хүсэлт тавьж байсан гэж 48% нь хариулсанаас харагдаж байна.

Судалгаанд хамрагдсан эмч нараас өвчтөн болон ар гэрийнхний хүсэлтээр идэвхгүй эвтанази хийж байсан тохиолдол гарсан, тухайлбал эмч нарын 21 хувь нь эвтанази хийж байсан боловч энэ нь “нуугдмал” хэргийн шинжтэй тэдний 60 хувь нь идэвхгүй эвтаназийг дэмжсэн байна. Үүнээс үзэхэд эмч нарт эвтаназийн хүсэлт ар гэрийнхэн болоод эмчлүүлэгчээс ирдэг бөгөөд тиймээс ч Монгол улсад эвтаназийн

эрх зүйн зохицуулалтыг бий болгох хэрэгтэй гэж дүгнэж байна.

Гурав. Судалгаанд ХСҮТ-ийн хөнгөвчлөх эмчилгээний тасаг, Грийн Хоум хоспис болон Бриллиант хоспист хэвтэн эмчлүүлж буй үйлчлүүлэгч болон тэдгээрийн ар гэр, хууль ёсны асран хамгаалагч 30 үйлчлүүлэгч хамрагдсан.

Эдгэршгүй архаг өвчний төгсгөлийн шатанд буй өвчтөний 13.3 хувь нь болон түүний хууль ёсны асран хамгаалагч нарын 13.3 хувь нь эвтаназийн талаарх өмнө нь сонсож байсан нь мэдлэг болон ойлголт нэн бүрхэг, ам дамжсан шинжтэй, харин судалгааны явцад анхан шатны мэдээлэл, ойлголттой болсон. Тиймээс:

Судалгаанд хамрагдсан эдгэршгүй архаг өвчний төгсгөлийн шатанд буй өвчтөний болон түүний хууль ёсны асран хамгаалагч нарын 80 хувь нь эвтаназийг ёс зүйд нийцтэй

Судалгаанд хамрагдсан эдгэршгүй архаг өвчний төгсгөлийн шатанд буй өвчтөн болон түүний хууль ёсны асран хамгаалагч нараас өөртөө болон өөрийн асран хамгаалалтанд байгаа хүнд эвтанази хийлгэх бодол 33.3 хувьд нь төрж байсан ба ойролцоогоор 27 хувь нь хэн нэгэнд эвтаназийн талаар хандаж байсан нь харагдав.

Судалгаанд хамрагдсан эдгэршгүй архаг өвчний төгсгөлийн шатанд буй өвчтөн болон түүний



хууль ёсны асран хамгаалагч нар Монгол улсад цаашид эвтаназид эрх зүйн зохицуулалт хийх шаардлагатай бөгөөд хуульчилсан тохиолдолд эвтаназийг дэмжинэ гэж дунджаар 83% нь хариулсан байна.

Эндээс үзэхэд эдгэршгүй өвчтөн болон түүний ар гэр, хууль ёсны асран хамгаалагч нар нь эвтанази хийлгэх талаар хүсэл бодолтой байдаг бөгөөд энэ талаар асран хамгаалагч болон эмчид хандаж байсан нь судалгаагаар тогтоогдсон тул энэхүү эмзэг асуудлыг ээлж дараатай, тодорхой чиглэлээр эрх зүйн зохицуулалт хийх шаардлагатай гэж үзэв.

Дөрөв. Эвтаназийн зохицуулалтын хэм хэмжээг бий болгохын тулд “эвтанази”-ийн объект, субъект, болон сэдэлт, зорилгыг сайтар судалж эрүүгийн эрх зүйн хориглолтын хамрах хүрээ, эрүүгийн эрх зүйн бусад институтээс ялгарах онцлог, эвтаназийн ангилал, гүйцэтгэж буй хэлбэрийг тодорхойлох, хүлээлгэх хууль зүйн хариуцлагын үндэслэлийг тогтоох зэрэг асуудлууд тулгарч байна.

Эрүүл мэндийн тухай хууль болон эмнэлгийн эрх зүйн бусад актуудад эвтаназийг хориглосон заалт байхгүй, эмчилгээнээс татгалзах эрхийг нээлттэй байдлаар зохицуулсан атлаа Эрүүгийн хуулиар хориглосон нь эвтаназийн “латентны” буюу нуугдмал хэлбэрийг бий болгосон нь тун

эдрээтэй санагдана.

Хэрэв эмч үйлчлүүлэгч буюу түүний ойр дотны хүмүүсийн зөвшөөрлийн дагуу эвтанази хийвэл Монгол улсын эрүүгийн хуулийн 91.1-д зааснаар 10-15 жилийн хорих ял авах бөгөөд онц хүнд гэмт хэрэгт тооцогдоно. Улсын Дээд Шүүхийн тайлбарт хохирогчийн зөвшөөрөлтэйгээр түүний амь насыг егүүтгэснийг энэ зүйл хэсгээр зүйлчилж байхыг заажээ (1996 оны №2, 12хх).

Тав. Харьцуулсан судалгаагаар эвтаназийн эрх зүйн зохицуулалтыг Нидерланд, Бельги, Швейцар, Франц, Герман, Люксембург, АНУ-ын Калифорни, Орегон, Вашингтон, Колорадо, Вермонт, Монтана мужууд, Австралийн хойд бүс, Израиль, Япон, Мексик, Энэтхэг, Румын, Сингапур, Англи, Итали, Иорданд болон ОХУ, тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн орнуудыг жишиг болгон судлав.

Эдгээр орнуудаас Голланд, Бельги, Люксембургийн вант улс болон Швейцарь нь дэлхий дээр идэвхтэй эвтаназийг албан ёсоор зөвшөөрсөн орон юм. Харин европын бусад орнууд болох Франц, Германд, Унгар, Норвеги, Австри, Дани (1992он), Испани, Швед(2010), Чех, Япон, Энэтхэг, Колумбид идэвхгүй эвтаназийг хуульчилсан байна.

ОХУ болон Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн орнуудаас одоогоор албан ёсоор эвтаназийг



хүлээн зөвшөөрсөн улс байхгүй, мөн судалгаанд хамрагдсан эдгээр ойрхи дорнодын арван хоёр орнуудаас зөвхөн гурван орны эрүүгийн хуульд эвтаназийн тохиолдолд харьцангуй хөнгөн шийтгэл оногдуулахаар заасан болохыг тогтоов.

Итали, Грек, Босния, Серби, Польш, Унгар, Хятад, Румын, Шотланд, Англи болон Ирланд зэрэг оронд зөвшөөрдөггүй хэрэв эвтанази хийвэл хүнийг санаатай

алах гэж гэмт хэрэг гэж үздэг байна.

Идэвхтэй болон идэвхгүй эвтаназийг зөвшөөрөөгүй улс орнуудад хүнийг санаатай алах гэмт хэрэг үздэг бөгөөд эвтанази хийсэн тохиолдолд 1-15 жил хорих ялаар оногдуулдаг байна. Монгол улс эдгээр улсууд дотроос хамгийн олон жилийн хорих ял оноодог улсын тоонд орж байна.



ИХ ЗАСГИЙН УЛАМЖЛАЛ БА XIII-XIV ЗУУНЫ ХУУЛЬ ЦААЗЫН СУРВАЛЖ БИЧГҮҮД



*Б.Анхныбаяр
Магистрант*

Хууль нь бүтээсэн нийгмийнхээ толь болж байдаг, тиймээс тухайн нийгмийн бүхий л талын харилцааны тусгал эх сурвалж нь тухайлбал XIII-XIV зууны үеийн хууль цаазыг нарийвчлан судласнаар яах аргагүй Их Монгол улс болон Монголын эзэнт гүрний эрх зүйн орчинг төдийгүй улс төр, эдийн засаг, соёл урлаг, шашин шүтлэг гэх мэт нийгмийн бүхий л салбарыг шинжлэх судлах боломж бүрдэнэ.

Хэдийгээр энэ үеийн хууль цаазны ихэнх нь анхны эх бичвэр

байдлаараа бүрэн хэмжээгээр ул мөрөө үлдээгээгүй ч гэсэн дам эх сурвалжуудаас хэсэг бусгаараа "олдсон" байна. Өөрөөр хэлбэл, тухайн үеийн түүхэн сурвалжуудад түүний агуулгыг тэмдэглэн үлдээсэн нь багагүй билээ. Үүнд: Монголын нууц товчоон, Дэлхийг байлдан дагуулагчийн түүх, Абул фаражийн түүх, Судрын чуулган, Нум сумтан ард түмний түүх, Юань улсын судар, Гуулин улсын судар, Богд баатар биеэр дайлсан тэмдэглэл / Хар татарын хэргийн товч, Монгол татарын бүрэн тэмдэглэл/, Чань Чун бумба баруун тийш зорчсон тэмдэглэл, Монголчуудын түүх, Дорно этгээдэд зорчсон минь, Орчлонгийн элдэв сонин зэрэг сурвалж бүтээл болон аяллын тэмдэглэлээс хууль цаазын эх хэрэглэгдэхүүнийг нэхэн хайж, тухайн нийгмийг олон талаас харж, тайлбарлах боломж бүрдэж байна. Дээрхи сурвалжууд нь бүтээгдсэн цаг хугацааныхаа хувьд Их Монгол улс, Монголын эзэнт гүрний эрин үед бөгөөд түүнээс хол зөрүүгүй үед Монгол, Араб, Сири, Хятад, Солонгос зэрэг улсуудад бичигдэж үлджээ. Олон орны эрдэмтэд төрийн албан түүхийн хэмжээнд тодорхой баримт сурвалжуудын суурь дээр үндэслэн бичсэн, мөн өөрийн үзсэн харсандаа дүгнэлт хийсэн аялалын



тэмдэглэл тул дурдсан баримт материал нь үнэнд ойрхон байх үндэслэл бий. Гэвч туурвигчдын амьдарч байсан цаг үеийн нөхцөл байдал, тэдний үзэл бодлоос шалтгаалан ташаарсан баримт байж болох талтай эдгээр нь бие биенээсээ шууд ба шууд бусаар хуулбарласан, тоймлосон, нэмж засварласан, баяжуулсан эсвэл хассан хэлбэрээр түүхэнд үлдэхийг үгүйсгэх аргагүй.

XIII-XIV зууны үеийн хууль цаазад тусгагдсан хэм хэмжээнүүд яагаад Монголын түүхийн эх сурвалж болж чадах вэ? хэмээвээс тухайн нийгэмд тодорхой асуудал үүсгэн хэвийн зохицож байсан харилцаа чадахаа больсон, эсвэл төрийн эрх баригчдын өөрсдийнх нь хүсэл сонирхолд нийцсэн, эс нийцсэн харилцаа, түүнчлэн нийт ард түмний уламжилж ирсэн, шинээр бий болсон хэм хэмжээнүүдийг төр зөвшөөрөн хүлээж, албадлагаар хангасан, ингэсэн нөхцөл шалтгааныг тайлбарлах замаар тухайн нийгмийг танин мэдэж болох учраас монголын түүхийн энэхүү мөчлөгийг харах боломж бий хэмээн үзэв. Үүнийг дараах байдлаар тайлбарлавал:

I. Улс төр

Их Монгол улс байгуулагдсанаар хааны эрх мэдлийн бүхнээс дээгүүрт тунхаглахын зэрэгцээ “бүхий л хаад зөвхөн Их хуралдайгаас сонгогдох ёстой”-г тусгаж өгсөн нь улс төрийн хүрээнд гарсан нэгэн томоохон

өөрчлөлт эх сурвалжуудад энэ нь хэд хэдэн янзаар тэмдэглэгджээ. Үүнд:

Монголын нууц товчоо-нд “Миний хаан ширээг үр хүүхдийн минь нэг нь залгамжилж, миний зарлигийг өөрчлөхгүй, задлахгүй, осолдож алдахгүй баримтлаж явтугай.”¹ гэсэн бол Карпини “Олон ноёдын сонгох саналыг авалгүй дур зоргоор авирлаж биеэ магтан сагсууран хаан болохыг санаархсан хэнийг ч болов өчүүхэн өршөөлгүй алахтун.”² хэмээн тэмдэглэжээ.

Их хуралдайн ёслол өөрөө нарийн дэг журамтай түүгээр хэлэлцэх асуудал ч тодорхой байсан тухайлбал хамгийн гол нь хаан ширээнд өргөмжлөх арга хэмжээг энэ ёслолгүйгээр хэн ч “хаан” нэрийг авах эрхгүй гэдгийг хууль цааздаа баталгаажуулж өгчээ.

II. Олон улс харилцаа

Энэ үеийн олон улсын эрх зүйт холбогдох хэм хэмжээг өөртөө агуулсан ба энэ нь хэн хүчтэй нь ялан дийлэх цаг төрийн тайван бус байдалд хамгийн удаан хугацаагаар оршин тогтносон үзэл онолын суурь нь болж дэлхийн дипломатын түүхэнд олон өөрчлөлт шинэчлэлийг авчирч чадснаараа Монголын түүхэн дэх Монголчуудын гадаад улс орнуудтай хэрхэн харилцаж ямар байр суурьтай байсныг илтгэх баримт болон үлджээ. Тухайлбал

¹ Rachewiltz 1972: 153; МНТ 2006: §255

² Карпини 1998: 56



“Гуулин улсын судар”-аас олдоод байгаа “Ману Тайцзу Чингис хааны айлдсан Засаг-т өгүүлэхдээ: “Нэхэн санаваас, элссэн улс болбаас данж барих бөгөөд цэргээр туслах бөгөөд, хүнс нийлүүлэх бөгөөд, өртөө байгуулах бөгөөд, өрхийн цэсийг өргөх бөгөөд, дарагчи тавих боломуй хэмээсэн ажгуу”³ зурвас нь хэдийгээр цаг хугацааны хувьд хожуу боловч албан ёсны түүх байсныхаа хувьд, мөн доторхи агуулгын хувьд “Их засаг”-ын бүрдэл байжээ гэж үзэхээс гадна үүнд тусгагдсан зурвасуудыг ч өмнө Чингис хаан хэрэгжүүлж байсныг бусад сурвалжууд мөн нотолж байгаад л хэргийн гол учир оршино.

Алтан хан “ Чингис хаанд Гүнжү нэртэй охиныг гаргаж, алт, мөнгө, агуурс, эд таваар цэргийн хүмүнд, хүчинд мэдүүлэн, даахуйгаас, Жүндүгээс гаргаж, Чингис хаанд Вангин чинсан хүргэж ирэв. Элсэн ирсэнд, Чингис хаан, эед орж, хот хотод эгээрэн буусан цэргүүдийг хариулж няцав.”⁴

“Хашин иргэний Бурхан элсэн “Баруун гар чин болж хүч өгсү” хэмээн Чаха нэртэй охин Чингис хаанд гаргаж өгөв.”

Энэ мэтээр элсэн орсон улсын тухай Монголын Нууц Товчоо болон бусад сурвалжуудад мөн адил тэмдэглэсэн байдаг бөгөөд товчлохын үүднээс зөвхөн Монголын Нууц Товчооноос авлаа.

Харлуг, Уйгарын шилдэг эрс Хар Эрчис мөрөнд Их монгол улсын морин цэрэгтэй ирэхэд Тангад улс үүргээ биелүүлээгүй учраас 1227 онд мөхсөн юм.

Элссэн улс үүргээ биелүүлээгүй бол хувь заяа нь хэрхэн эргэдэгийн нэг жишээ нь Тангад улс бөгөөд энэ тухай ч дээр үгүүлсэн Хубилай хааны жуу бичигт “Тэнгэрийн ёсон товгүй, Хүмүүний ёсон үнэнчийн эрхимлэх хэмээмүй. ... Өмнө хэлсэн чинь талаар болсоны учир /ял/ асууж байна.” хэмээн тов тодорхой дурджээ.

Дээрхи сурвалжид мөн “өртөө байгуулах” байгуулах тухай дурджээ. Чингис хааныг залгамжилсан Өгэдэй хаан өртөөг ихэд анхааран өргөжүүлснийг сурвалжид хэд хэдэн янзаар тэмдэглэсэн нь бий Тухайлбал: өртөө байгуулах, түүний зохион байгуулалт, өртөөгөөр зорчин явах элч, төлөөлөгчдийн эрх, үүрэгийг тэмдэглэсэн байна.⁵ Тэгэхлээр Монголын эзэнт гүрэн даяар өртөөний сүлжээг нэн нарийн зохион байгуулж үүний нэг жигүүрийг ч гэсэн Гуулин улсын зүгээс хангах үүрэг бүхий байжээ. Евроазийг холбосон морин өртөөний сүлжсэн холбоог урьд өмнө нь хэн ч хийж хэрэгжүүлж чадаагүй бөгөөд Чингис хааны дипломат харилцаанд оруулсан гайхамшигт гавъяанд дурдахгүй өнгөрч үл

³ Rachewiltz 1972: 20; МНТ 2006:§279; Монголын үндэсний нэвтэрхий түүх 1995:138-139 /Юань улсын судар/; Juwaini 1958: I, II, 30, 33, 34, 501, 524, 599; Карпини/ Рубрук 1957:45; Gregory Abul-Farac, 1999: 479

³ Гуулин улсын судар XXVI Сумьяабаатар 2003:232-243

⁴ МНТ 2006:§248



болох билээ. Дэлхийг донсолгосон эзэнт гүрнийг байгуулахад шуурхай найдвартай мэдээ мэдээлэл авах, улс хоорондын элчин худалдаачдын аюулгүй байдлыг хангахад өртөө ихээхэн үүрэг гүйцэтгэсэн бөгөөд үүнийг дагалдаж олон төрлийн харилцаа үүсэж байв. XII зууны эхэн үед өртөө зам байсан боловч бүрэн төгөлдөржиж нийт гүрнийг хамарч чадаагүй бөгөөд зарим зах хязгаар нутагт уургын улаа эсвэл энэ хоёрын холимог хэлбэрийг хэрэглэсээр байжээ.

III. Цэргийн зохион байгуулалт

Их засаг-т цэргийн холбогдолтой хэм хэмжээнүүд нэлээдгүй хувийг эзэлдэг болохыг олон судлаачид хүлээн зөвшөөрдөг. Эдгээрээс Их Монгол улсын цэрэг эрсийг нэгэн тугийн доор нэгтгэхдээ аравтын системээр хуваарилсан тухай сурвалжуудын мэдээг олноор харж болох бөгөөд энэ тухайн үедээ энэхүү цэргийн зохион байгуулалт нь шинэ бөгөөд эрчтэй далайцтай явагдаж, нийгмийн нэгэн шинэ соргог үзэгдэл байснаас л ингэж олон сурвалжид тэмдэглэгджээ. Үүнд: “Улс байгуулалцагсад, зүдрэгсдийг мянгатын ноёд болгож, мянга мянгалж, мянгат, зуут, аравтын ноёдыг тушааж, түмлэж, түмтийн ноёдыг тушааж, түмэт, мянгатын ноёдод соёрхол өгөх ёстой.”⁶ хэмээснийг Жувейни: “Тэд бүгд цэрэг ардаа арван хүн тутмыг нэг жижиг анги болгон зохион байгуулж, дотроос нь нэгийг нь

шилэн томилж нөгөө есөн хүнийг удирдуулна. Мөн арван аравтын ноёдын дотроос нэгийг нь “зуутын ноён” хэмээн томилж, тус зуун хүнийг ноёлуулна. Мянган хүн, түмэн хүн тутмын байдал нь дээрх мэт адил. Түмэн хүний дээр нэг ноён тавьж “түмний ноён” хэмээмүй. ...Ард иргэд заавал өөрийн харьяалагдах зуут, мянгат буюу аравтдаа байваас зохино. Бусад нэгж дор шилжиж үл болно. Тэрчлэн өөр газарт очоод тэндээ хоргодож үл болно. Энэ зарлигийг зөрчиж шилжигсдийг цэрэг, ардын өмнө цаазаар аваачтугай. Хорьж хамгаалагсдыг ч хүндээр шийтгэх хэрэгтэй.”⁷ гэжээ.

Рашид ад Дин “Аравтын ноён, арван ардаа дайчилж, алалдаан тулалдаанд оруулж үл чадваас, гэргий хүүхэдтэй нь хамтаар ял хэлэлцмүй. Дахин арван иргэний дотроос нэгнийг нь сонгон аравтын ноён болгомуй. Зуутын ноёд, мянгатын ноёд, түмтийн ноёд ч бас үүнтэй адил болтугай.”⁸ хэмээжээ.

Бар Хебраеус “10 хүн бүрд нэг 100 хүн бүрт нэг, мянган хүн бүрт нэг, 10000 хүнд нэг толгойлогч байдаг. Аравт, зуут, мянгатаасаа зугтаасан хэнийг ч өөр бүлэгт хамааруулахгүй. Ийм юм хийсэн бол түүнийг ч өөрийн хэсэгтээ авсан ноён ч цаазлана.”⁹ гэжээ.

Карпини мөн адил энэ системийн тухай өгүүлсэн нь: “Цэрэг ангийг

⁷ Жувейни 1981: 32-33

⁸ Rashid al-Din 1983: 355

⁹ Gregory Abul-Farac 1999: 479



доорх маягаар хувиарласан байдаг. Чингис хаан зарлиг буулгаж, арван хүн тутамд нэг ноён байна. Арван аравны ноёнд нэг зууны ноён тавьж захируулна. Арван зууны ноёнд нэг мянганы ноён тавьж захируулна. Арван мянганы ноёнд нэг түмний ноён тавьж захируулна. Түмэн хүний ангийг тэд түмэн гэж нэрлэдэг байна. Бүх цэргийг 2-3 удирдагч ерөнхийлөн захирна. Гэвч тэд нар нь мөн тэдгээрий доторхи нэгнээ дагаж захирагдана.¹⁰ гэж бичжээ.

Рубрук энэ тухай: “Хэн хүн боловч хааны зарлиггүйгээр ямарч газар оронд дур мэдэн суух үгүй. Удирдагчдынх нь суух газрыг хаан өөрийн биеэрээ зааж тогтооно. Удирдагчид нь мянганы ноёнд, мянганы ноён нь зуутын ноёнд, зуутын ноён нь аравтын ноёнд тус тус зааварлана. Үүнээс гадна хэзээ ч, хаана ч атугай хамаагүй хаан зарлиг буулгасан л байвал тэдгээрийг дайн байлдаанд мордуулах буюу эсвэл тэднийг үхэж болохоор явуулах аль нь ч болтугай, тэдгээр нь эрхбиш өчүүхэн ч зөрчилгүй дагаж гүйцэтгэх хэрэгтэй.”¹¹ гэжээ. Цааш нь “Хүн бүгд цөм тогтоосон зуут мянгат буюу аравтынхаа харьяанд л байх хэрэгтэй байжээ. Өөр нэгжид шилжиж болохгүй. Энэ зарлигаас зөрчиж аймшиггүй нэгжид шилжсэн хүнийг цэрэг дайчидын нөмнө авчирч алах ялаар шийтгэнэ. Нэхүүлэгч авчихсан этгээд нь ч хүндээр яллагдана. Иймээс хэн боловч нэг нь нөгөөдөхийгөө

өмгөөлж, далдалж үл болно. Хэрвээ ноён нь ханлиг байвал энэ зурвас засгийг зөрчихгүйн төлөө бүх хүнийг хүртэл цэрэг ангидаа үлдээж далдлуулна гэж байдаггүй хэрэг л. Иймээс хэн хүн өөрийн ноёноо буюу тэргүүлэгчээ тааваараа сольж чадахгүй.”¹² гэснээс үзвэл хүн бүр өөрийн гэсэн харьяалалтай бөгөөд энэ нь хүн бүр харьяа ноёныхоо газар нутаг орныг эзэмшигч байж өөрийн аж ахуй, мал сүргээ өсгөн үржүүлж, хишиг буяныг нь хүртэн амьдарч байжээ.

Ийнхүү дээрээс доош босоо чиглэсэн цэргийн удирдлагатай Их Монгол улсын зэвсэгт хүчний түүхэнд бичигдэх болсон бусад нөхцөл нь цэрэг эрсийнх нь байлдааны бэлтгэл, сахилга бат, тэсвэр хатуужил байсан юм. Энэ тухай олон түүхчид гайхан шагшан магтаж, мөн зэрлэг балмадаар нь ч жигшин зэвүүцэж байснаа сурвалж бүтээлдээ тэмдэглэн үлдээжээ.

Цэргийн эрх зүй хэмээх бие даасан ойлголтыг илэрхийлэх “Их засаг”-дахь зурвасуудыг шинжлэн, дүгнэвээс монгол тугийн дор нэгдсэн морьт цэргээр тухайн цаг үедээ хэтийдсэн хүчирхэг армийг байгуулсан нь монголын төдийгүй дэлхийн цэргийн түүхэнд дахин үл давтагдах байлдааны аян, зэр зэвсэгийн асар их ололт амжилтийг амьдралд нэвтрүүлж, дэлхийн ямар ч улстай эн зэрэгцэх Их Монгол улсын батлан хамгаалах зэвсэгт хүчнийг бий болгожээ.

¹⁰ Карпини/Рубрук 1983: 108

¹¹ Рубрук 1988: 108-111

¹² Жувеини 1989: 52



IV. Эдийн засаг

Дээр дурдснаар Их засаг нь зөвхөн эрх зүйн орчинг бус эдийн засгийн орчинд ч хүчтэй нөлөө үзүүлж байжээ гэдгийг тухайн үед тогтоосон алба татвар, гувчуурын тухай хэм хэмжээнээс харж болох ба Их Монгол улс, Эзэнт Гүрний гол сан хөмрөгийг бүрдүүлж эгэл дорд, эрхэмсэг баян хүн бүхэн Монголын харьяат иргэн гэдгийг мэдрүүлэх, эргүүлээд ард иргэдийн сайн сайхан байдлыг хангахад нь ихээхэн үүрэг гүйцэтгэжээ. Үүнээс гадна тодорхой хүмүүст ч татварын хөнгөлөлт үзүүлж байсан хийгээд татвар, гувчуур татаж буй албан тушаалтны ёс зүйн хэм хэмжээг ч тогтоож өгжээ. Энэ бүхнийг янз бүрийн сурвалжуудаар тодруулбал: Үүнд татварын хэмжээ болон цаг хугацааны тухай "МНТ"-нд

"Хаан эцгийнхээ бэлэнд сууж, иргэн үл зовоон, шөл хоолонд энэ улсаас сүргийн нэг шүдлэн хонь, он онд өгтүгэй! Зуун хониноос нэг хонь гаргаж, мөн зуур үгээгүүн дутуунаа өгтүгэй! Бас ах дүү, олон эр, агт хэшигтэн чуулбаас, ундаан тэр тутам иргэнээс хэр гувчигдахуй? Зүг зүйн мянгад мянгадаас гүү гаргаж, саах саальчин тэргүүтнийг, адуулах нутагчин тэргүүтнийг байнга байлгаж, солилцон гаргаж, унагчин болготугай."¹³

Энэ хүү зурвасыг өөрөөр хэлбэл Өгэдэй хаан анх малаас татвар авдаг болсон тухай Рашид ад Дин

тэмдэглэсэн нь "тэр жилдээ маланд гувчуур ногдуулдаг болсон. Үүнд зуун толгой мал тутмаас нэг толгой малаар гувчуур төлөх, мөн хааны айлдсанаар ядуучуудын төлөө зарцуулах, тэднийг тэтгэхийн тулд арван тагар (taghār) бүрээс нэг тагар будаагаар татвар авах болгосон байна."¹⁴ цааш нь "Гувчуур нэртэй бэлчээрийн татварт бүх төрлийн малын зуун толгой тутмаас нэг толгой мал татварт өгөх ёстой, зуун толгойгоос доош тооны малтай бол юу ч өгөх ёсгүй. Хаан ч хэнээс ч бол төлөгдөөгүй дутуу үлдсэнийг хүн амаас гаргуулан авахгүй."¹⁵ мөн цааш нь Мөнх хаан зарлиг гаргасан нь "Энэ албан татвараас өөр ямар ч гувчуур шаардаж болохгүй."¹⁶ гэжээ.

Энэ тухай мөн Ваг Hebraeus "Бүх монголчууд жил бүр хааддаа сүргээсээ, эд агуурсаасаа адуунаас, хониноос, сүүнээс нь тэр байтугай ноосноос нь хүртэл бэлэг өргөж түүнд тусалдаг."¹⁷ гэсэн мэдээ үлдээсэн бол Карпини бичсэн нь "Олон хангууд нь эрхбиш эзэн хаандаа гүү өргөж, жилээр, хоёр жилээр, гурван жилээр ч гэсэн гүү бариулж цэгээ / айраг/ авчруулж байх хэрэгтэй. Олон ноёдын албат харьяат нар нь мөн нэгэн адил өөрийн эзэн ноёндоо гүү барьж өгөх хэрэгтэй. Учир нь тэдний дунд эрх чөлөөтэй хүн гэж нэг ч байхгүй юм. Товчлон хэлбэл, хаан ба хангууд нь албат иргэдийнхээ эд хөрөнгийг дураараа

¹⁴ Rashid al-Din 1971: 55

¹⁵ Rashid al-Din 1971: 219-220

¹⁶ Rashid al-Din 1971: 231

¹⁷ Gregory 1999: 479

¹³ Rachewiltz 1972: 171; МНТ 2006:5279



авч хэрэглэж болно. Юуг авах дуртай бол түүнийгээ авч, хичнээн авах дуртай төчнөөн авч болохоор барахгүй, тэдний өөрсдийн бие хүртэл цөм эзэн хаан болон олон хангуудад бүрмөсөн захирагдана.¹⁸ гэжээ.

Их Монгол улсын үед ийнхүү эд малаар татвар авахаас гадна мөнгөн татвар оногдуулж байжээ. Энэ нь магадгүй дагаар орсон улсуудад хэрэгжиж байсан болов уу. Анх Жувейни жилдээ нэг удаа төлөх татварын хэмжээний тухайд "Хаан бас зарлиг болж баян хүн нэг бүрээс 10 динар хурааж энэ мэтчилэн харьцаж ёсоор доошлуулан ядуучуудаас 1 динар хураагаад татварлан авсан бүх орлогыг албадан элссэн хашир цэрэг, өртөө улаа хийгээд түшмэдийн амьдралын зарлагад хэрэглэжээ"¹⁹ гэсэн бол Рашид-ад Дин "(Хөдөлмөрийн хөлснөөс нь) хувь гаргаж чаддаггүй ажиллагч бүрийн хувьд гэвэл Мөнх хаан албыг нь жил бүрээр төлж байхаар тогтоосон байна. Хятад мужийн баячууд-арван динар харин ядуу нь чинээгээрээ нэг динар төлж байх, Мавераннахрынх мөн тэр тооны Хорасаны баячууд-долоон динар ядуу нь нэг динар төлж байхаар тогтоожээ. Татвар хураагч, бичигчид нь тал тохой татах дургүй, хээл хахууль авдаггүй бай гэж тэр тушаажээ."²⁰ Эдгээр сурвалжуудад тэмдэглэгдсэн баримтуудаас дүгнэлт хийвэл

Монголын эзэнт гүрний хэмжээнд тухайн бүс нутгийн онцлог болон ард түмний амжиргааны түвшинг харгалзан алба гувчуурыг харилцан адилгүй тогтоож байжээ. Татвар татах давтамж нь жилд 1 удаа, хэмжээ нь 100 хувиас 1 хувь буюу 100 толгой малаас 1 толгой мал, мөн бусад аливаа бараа таваарыг татварлаж болох ба баян хүн жилдээ 7-10 динар ядуу хүн хэр боломжоороо буюу 1 динар татварт төлөх үүрэгтэй байснаас харахад Монголын эзэнт гүрний татварын бодлого нь харьцангуй уян хатан хатан, дарамт шахалт багатай байсан мэт харагдана.

V. Шашин шүтлэг

Хүний үзэл бодол, итгэл үнэмшил гэдэг бол төрөөс тогтоосон хатуу хэм хэмжээний дагуу зохицуулагдахгүй бөгөөд энэ ч боломжгүй юм. Харин түүнийг зөв чигт нь залж, тэтгэн дэмжсэнээр төрд төдийгүй тухайн нийгэмдээ ашигтай олон зүйлийг бүтээж болох юм. Өөрөөр хэлбэл Их Монгол улсын зүгээс шашны талаар баримтлах бодлого нь шашин болгонд хүндэтгэлтэй хандана, үл доромжлоно, ямар ч шашны сүм хийд, тэдний албатуудыг татвараас чөлөөлөж эдийн засгийн хувьд тэтгэн дэмжиж байсан нь түүнийг дагаад нийгэмд олон төрлийн соёл харилцан нэвтрэлцэх боломжийг хангаж өгчээ. Чингис хаан олон шашны эрдэмтэн мэргид, лам хуврага, санваарантай уулзан учир явдлыг хэлэлцэхийн дээр тэдэнд

¹⁸ Карпини/Рубрук 1983: 110-111

¹⁹ Juvaini 1958: I. 599

²⁰ Rashid al-Din 1971: 219-220



илгээсэн илгээлт болох бичиг захидалууд нь эрх зүйн үнэтэй сурвалж болохын зэрэгцээ дээрхи үзэл санаа нь "Их засаг"-т тусгалаа олж, түүнийг залгамжлагч хаадын үед ч баримталж байсан бодлого болохыг сурвалжуудад тэмдэглэсэн байдаг.

Энэ тухай Жувейни "Тэдэнд биеэ тушаагаад захирагдсан хүн бүхэн монголчуудын яаса болон заншил ёсоор амь аврагдан аюул айдасгүй чөлөөтэй амьдрах болно. Түүнээс гадна тэд аливаа мөргөл, аливаа шашныг үл хязгаарлана. Хязгаарлах нь битгий хэл тэд бүх шашныг тэтгэн дэмждэг. "Үнэн аллах өөрийн шашныг ямар ч баялаггүй ард түмнээр дамжуулан бататгах болно." гэсэн Мухаммедын үг түүний баталгаа мөн. Тэд шашин бүрийн хамгийн номтой санваартнуудыг аливаа татвар, алба гувчуурын дарамтнаас чөлөөлж, тэдний шашны эд хэрэглэл, өмч хөрөнгийг бүх нийтийн хэрэгцээнд зориулан, мөн тэдний харъяалалд байсан тариачдыг элдэв татвараас чөлөөллөө гэж зарласан. Мөнх хааны захиргааны үед, Чингис хааны удмын хэдэн хунтайж нар, өөрөөр хэлбэл түүний үр хүүхэд, ач гуч нар исламын сайн талыг дэлхийг захирахад ашиглаж байгаа одоо үед тэднийг муу хэлэх хүн ялангуяа Мухаммедын исламуудын дунд л лав байхгүй. Шашны ач тусыг хүртээд сүсэглэн дагах болсон хүмүүс тоо томшгүй олон болжээ."²¹

гэжээ. Цааш нь "Чингис хаан ямар ч шашин шүтдэггүй хүн байсан болохоороо аль нэг шашныг ялган гадуурхдаггүй, алиныг нь ч онцлон дэмждэггүй, цөмийг нь адилхан үздэг байлаа. Харин бүх шашны эрдэм номтой, үнэнч шудрага санваартнуудыг хүндэтгэдэг, үүнийгээ бурхны хаанчлалд хүргэх баталгаа гэж үздэг байлаа. Түүнчлэн мусульманчуудад ивээлтэй ханддаг шигээ бас христийн болон бусад шашинд ч ивээлтэй ханддаг байв. Түүний хүүхдүүд, ач нар нь ямар шашин шүтэхээ өөрсдөө сонгоно. Жишээ нь тэдний нэг хэсэг нь мусальман шашин шүтлэг болоход нөгөө нэг хэсэг нь христийн шашныг бас шүтдэг болсон. Бас өөр шашин шүтдэг, мөргөлдөө үнэнч хүмүүс ч олон байсан. Тэд хэдийгээр өөр өөр шашинд орсон ч шашинаа улайран өмөөрч хоорондоо хямардаггүй, харин Чингис хааны Яаса хуулийг хэлбэрэлтгүй баримтлан эв эеэ их сахидаг байлаа."²² гэжээ. Юань улсын судар-т энэ тухай Өгэдэй хааны үед:

"Есдүгээр он (1259 он)... анхан Тайзуны үед... Ер өгүүлэх нь өвгөсийн хуулийг дагана. Өөр улсын хуулийг дагаж явахгүй хэмээжээ. Тийм боловч бөө удган ба бэлэгдэх төлөгдөх ёсыг дагаж итгэнэ. Аливаа хэргийг явуулахад эрхгүй хичээнгүйлэн асуух нь лав хоосон өдөргүй. Эгнэгт жиб хүрэхгүй бөлгөө."²³, Bar Hebraeus-ийн мэдээлснээр "Монголчууд

²² Жувейни 2004: I. 20

²³ Юань улсын судар 2002: 67-68



алдартнууд болон цэвэр үнэнч шудрага хэн бүхэн, эрдэмтэн мэргэдийг аль ч үндэстэн ястан байсан хамаагүй хүндэтгэл үзүүлэх ба албан тушаалд дэвшүүлнэ. Муу болон хүний үнэргүйчүүдийг үзэн ядна Энэхүү журамт ёсыг загалмайтнуудын дунд байсныг Монголчууд хаанчлалынхаа эхэн үедээ үзсэн бол тэднийг анхнаасаа л дотночлох л байсан.

Харин тэдний хайр энхрийлэл нь тэр хэмжээний хүчтэй үзэн ядалтаар солигдон энэхүү журамт ёс ба байдлыг таалсан нүдээр харахгүй болж эхэлсэн. Яагаад гэвэл бүгдээрээ мянга мянгаараа мусалман болцгоосон.”²⁴ гэжээ.

²⁴ Gregory 1999: 478-479

Эдгээр сурвалжийн мэдээ нь “Их засаг” дахь шашны холбогдолтой хэм хэмжээг агуулсан сурвалжийн баримт болох ба эдгээрийг бичсэн хүмүүс өөрсдөө ямар шашин шүтдэг байсан хийгээд ямархуу үзэл бодлын үүднээс үүнийгээ бичсэн зэргийг харгалзан үзэх хэрэгтэй.

VI. Зан заншил

Эрт ба эдүгээ цагийн бүхий л ястан үндэстэний хоол, идэж уух арга барил болон хүний хүнсний хэрэглээтэй холбоотой асар их соёл байх агаад түүнийг ч “Их засаг”-т дурдсан байдаг.



ШҮҮХИЙН НОТОНГООНЫ ЗАРИМ АСУУДАЛ



Б.Баярмаа
Магистрант

Түлхүүр үг:

- Гомдол гаргах эрх.
- Шүүхийн хамгаалалт
- Мэтгэлцээний шүүх
- Нотолгооны онол
- Үзэл бодол

Монгол Улсын үндсэн хууль, Монгол Улсын хууль, Олон улсын хууль тогтоомжид зааснаас үзэхэд хүний эрх, эрх чөлөө нь хууль зүйн олон талын баталгаагаар хангагдаж бодитойгоор хэрэгжих үндэслэл бүрдсэн билээ. Энэ нь Үндсэн хуулийн болон Иргэний, Зөрчлийн,

Хөдөлмөрийн, Эрүүгийн гэгдэх салбар хуулиудын хамгаалалтаар зохицуулагддаг юм.

Монгол улсын Иргэний хуулийн 9-р зүйлд заасан үндслэлээр гэхэд иргэн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг хамгаалах баталгаа, шүүхээс иргэдэд үйлчлэх төрийн үйлчилгээгээр хэрэгжиж байна. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 14-т зааснаар иргэд Үндсэн хууль, Олон Улсын хэм хэмжээгээр тогтоосон эрх, эрх чөлөөгөө зөрчигдсөн гэж үзсэн тохиолдолд төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гомдол гаргасан үеэс эхлэн уг асуудлыг шийдвэрлэх, биелэгдэх хүртэл тасралтгүй, шатлан явагддаг шүүхийн олон талт үйл ажиллагааны нэг чухал хэсэг юм. Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа нь:

- Шүүх заавал оролцох
- Иргэн, хуулийн этгээдийн эрх зөрчигдсөн үйл баримтыг тэднээс гаргасан өргөдөл, нэхэмжлэл, хүсэлт, гомдлын дагуу шийдвэрлэх
- Маргааныг Монгол улсын хуульд заасан хугацаа, журмыг баримтлан шийдвэрлэх,
- Маргаант асуудлыг зөвхөн



хуулийн заалт хуулийн заалт хэм хэмжээг үндэслэн төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэн шийдвэрлэх зэрэг онцлогуудтай.

Судалгаанаас үзэхэд сүүлийн 5 жилийн дунджаар Монгол Улсын хэмжээнд жилд 25,000-31,000 орчим иргэний хэргийг шүүх шийдвэрлэдэг бөгөөд хэрэг тус бүрээр хянан шийдвэрлэх ажиллагаа явагддаг гэж тооцоолоход шүүхийн ажилтнууд, шүүгчид, шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаныхан оролцсон олон мянган хүний асар их хөдөлмөр болох нь харагдаж байна.

Иргэд байгууллага зөрчигдсөн эрх, эрх чөлөөгөө хуульд заасан үндэслэлээр гомдол гаргах замаар хамгаалуулах нь тэдний Үндсэн хуулиар олгогдсон эрх төдийгүй, өргөдөл гомдол гаргаж түүнийхээ түүнийхээ үндэслэлийг батлахаар идэвх зүтгэл гаргах нь хүмүүнлэг иргэний нийгмийн гишүүн бүрт олгогдсон боломж, түүнийгээ хэрэгжүүлэх шалгуур юм. Нөгөөтүйгээр нийгэмд буй хууль зөрчиж байгааг илэрхийлсэн дохио, төрөөс хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох үндэслэл тул гомдол гаргасан иргэдэд хүндэтгэлтэй хандах, санал бодлыг тэвчээртэй сонсох, хуульд заасан журмыг чанд баримтлан шалгаж үндэслэлтэй хариу өгөх нь төрийн байгууллага, албан тушаалтны эрхэмлэх үүрэг мөн. Зөрчигдсэн эрхээ төр, эрх бүхий байгууллагад хандан хамгаалуулахаар цаг хугацаа эд

хөрөнгө, сэтгэл санааны эрсдэлд өртөж буй иргэдэд хүндэтгэлгүй хандах, ялгаварлан гадуурхах, чирэгдүүлэх, "заргач" нэр хоч зүүх зэргээр төрийн албаны ёс зүйг зөрчих нь албан тушаалтан хэнд ч болов байж үл болох дутагдал.

Шүүхэд хандаж нэхэмжлэл, өргөдөл, гомдол хүсэлт гаргаснаар иргэдэд Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд заасан үндэслэл журмаар шүүхийн үйлчлэл эхэлдэг бөгөөд энэ нь иргэний нэхэмжлэлийг хүлээн авсан үеэс маргаант хэргийг шүүхээр хянан шийдвэртэл гарсан шийдвэр нь хууль ёсны болж, биелэгтэл явагддаг процесс ажиллагаа бөгөөд, энэ нь иргэний зөрчигдсэн эрх, эрх чөлөөг хамгаалж хангах, дахин зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх зорилготой.

Иргэний хэргийг шүүхээр үнэн зөв шийдвэрлэх, шүүхийн шийдвэрийг бодитойгоор биелүүлж иргэд, байгууллагын зөрчигдсэн эрх, эрх чөлөөг хангах үндэслэл бол шүүхийн нотолгоо, нотлох баримт мөн.

Шүүхийн нотолгоо нь иргэний хэргийн зохигчдын шаардлага, татгалзлалын үндэслэл болсон баримт сэлт, түүнчлэн иргэний хэргийн үнэн зөв бодитойгоор шийлвэрлэхэд ач холбогдол бүхий бусад нөхцөл байдлуудыг тогтоох зорилгоор нотолгооны зүйлсүүдийг (нотлогдвол зохих нөхцөл байдал) тодорхойлох нотолгооны хэрэгслийг



гаргуулж авах, цуглуулах, нотлох баримтуудыг үнэлэх талаар иргэний хэргийн оролцогчдын болон шүүхээс хуульд заасан үндэслэл, журмаар гүйцэтгэж байгаа үйл ажиллагаа мөн. Шүүхийн нотолгоо иргэний эрх зүйн маргаан бүхий үйл ажиллагааг танин мэдэх процесс бөгөөд

- Нотлох баримтуудыг гаргах, цуглуулах
- Нотлох баримтуудыг судалж, шинжлэх
- Нотлох баримтуудыг үнэлэх гэсэн үе шатуудтай

Шүүхийн нотолгоог үндэслэн

1. Нэхэмжлэлийн шаардлагыг хангах, эсхүл хэрэгсэхгүй болгох
2. Хариуцагчийн татгалзлыг хангах, хэрэгсэхгүй болгох
3. Гуравдагч этгээд, иргэний хэргийн бусад оролцогчдын шаардлага, хүсэлтийг хангах эсэх асуудлыг шийдвэрлэдэг. Иймээс шүүхийн нотолгоо нь иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх үйл ажиллагааны гол цөм буюу амин сүнс хэмээгддэг.

Энэ процесст зохигч (нэхэмжлэгч, хариуцагч) гуравдахь этгээд, бусад субъект шүүх (шүүгч) оролцох үйл баримтыг танин мэдэх олон талт үйл ажиллагаа байдгаараа онцлогтой. Шүүхийн нотолгоо нь маргаант асуудалд холбогдох нотлох баримт, нотолгооны хэрэгсэлтэй, түүнийг танин мэдэх, судлах, үнэлэлт дүгнэлт хийх үйл ажиллагаатай холбоотой.

Иргэний Хэрэг Шүүхэд Хянан Шийдвэрлэх (цаашид ИХШХШ гэнэ) тухай 2002 оны хуулийн 37-р зүйлийн 1-д зааснаар нотлох баримт бол хэргийн оролцогчоос өөрийн шаардлага ба татгалзлал үндэслэж байгаа, шүүх хэргийг хянан шийдвэрлэхэд ая холбогдол бүхий хуульд заасан арга хэрэгслээр олж авсан бодит нөхцөл байдлыг тогтооход шаадлагатай аливаа баримтат мэдээллүүд мөн.

Нотлох баримтыг мөн чанар, нотлох байдал, эх үүсвэрийг харгалзан

- Анхдагч ба дамжмал
- Шууд ба шууд бус
- Эд мөрийн ба эд мөрийн бус хэмээн ангилан үздэг

Нотолгооны хэрэгсэл ИХШХШ тухай хуулийн 37-р зүйлийн 2-т нотолгооны хэрэгслүүдийг хуульчилсан. Нотлох баримтыг тодорхойлох ИХШХШ тухай хуульд заасан арга буюу тодорхой хэлбэр, төрлийн баримтууд бол нотолгооны хэрэгсэлд хамаарагдана. Түүнд:

- Зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөх эрх бүхий этгээдийн тайлбарууд
- Гэрчийн мэдүүлэг
- Эд мөрийн баримт
- Бичгийн баримт
- Шинжээчийн дүгнэлт
- Дүрс бичлэгийн баримт
- Кино, фото зураг
- Ул мөрийн хэв, хэлбэр



- Үзлэг, сорин туршилт, таниулалтын болон шүүхээс явуулсан үйл ажиллагаа, бусад үйл явдлуудын тухай тэмдэглэл
 - Бусад баримтууд хамаарагддаг байна.
4. Нотлох баримтуудыг тогтоох агуулга, мөн чанартай байна.

Шүүхийн нотолгооны салшгүй хэсэг бол нотлох баримтыг хамгаалах ажиллагаа бөгөөд иргэний хэргийг шүүхээр хянан шийдвэрлэхэд гол гол баримтуудыг устгах, устаж үгүй болохоос урьдчилан сэргийлэх талаар гаргасан зохих этгээдийн үндэслэл бүхий хүсэлтийг үндэслэн шүүгч захирамж гарган нотолгооны хэрэгслийг нь тухайлсан хамгаалалтанд авч байгаа үйл ажиллагаа юм. Энэ нь

- Нотлох баримтыг зайлшгүй хамгаалуулах тухай зохих этгээд хүсэлт гаргасан
- Эл хүсэлт үндэслэлтэй болох нь тогтоогдсон
- Шүүгч захирамж гарган нотлох баримтыг хамгаалах арга, хэлбэрийг шийдвэрлэсэн
- Нотлох баримтыг хамгаалах үүргийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх албад гүйцэтгэдэг
- Нотлох баримтыг хамгаалахтай холбоотой эрсдлийг юуны өмнө хүсэлт гаргагч, хожим нь буруутай этгээдэд хариуцуулах зэрэг онцлогтой байна.

Шүүхийн нотолгоо нь энэхүү

иргэний процест оролцогсдын мэтгэлцээний илрэл, үр дүн нь шүүхээс оновчтой, үнэн зөв шийдвэр гарах үндэслэл бөгөөд шүүхийн нотолгоо шүүхэд нэхэмжлэл гаргах үеэс шүүхийн шийдвэр гарах хүртэл хугацаанд хэрэгждэг, шүүхээс иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны гол хэсэг буюу цөм нь юм.

Эндээс улбаалан дараах саналуудыг дэвшүүлж байна.

Иргэний нэхэмжлэлийг шүүх хүлээн авсан үеэс шүүхийн нотолгооны мөн чанар, эцсийн үр дагаварыг маргалдагч талуудад тусгайлан танилцуулж баталгаажуулдаг тогтолцоог ИХШХШ-хуульд буй болгох. Энэ нь зохигчийн эрх үүргийг танилцуулах журамтай зэрэгцэн үйлчилдэг байх нь чухал.

ИХШХШ тухай хуулийн 50-р зүйлд нотлох баримтыг хамгаалахтай холбоотойгоор үүсэх эрсдэлийг (Нотлох баримтыг хадгалсан, харуул хамгаалалт авсан, бусад эрсдэл хэн хариуцах вэ гэдэг зохицуулалтыг хуульчлах шаардлагатай байна.)

Шүүх хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий бодит нөхцөл байдлыг тогтооход шаарлагатай хэрэгт хамаарал бүхий нотлох баримт нь шинж чанар, байрлаж буй орчин, цаг хугацаа болон учирч болох эрсдэл зэргээс хамаарч өөрийн нотлох чадамжаа алдах асуудал нэлээдгүй



гардаг байна. Энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шууд сөргөөр нөлөөлөх тул нотлох баримтыг цаг алдалгүй хамгаалах хүсэлт гаргах журмыг ИХШХША-ны оролцогчдод эрх, үүргийг нь танилцах үед ойлгуулах, танилцуулж байх.

Харин Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 50.5-р зүйлд “Энэ хуулийн 50.3-т заасан шүүгчийн захирамжийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нэн даруй биелүүлнэ” шүүгчийн захирамжийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хэрэгжүүлэхээр шууд заасан байдаг. Нэг талаас шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь шүүхийн тогтоол болон шүүгчийн захирамжийг хэрэгжүүлэх үндсэн үүрэгтэй ч хэргийн нөхцөл байдал нотлох баримтыг хамгаалахад учирч болох нөхцөл байдлыг тооцон тус хуулийн 45.3-т заасан “ Шаардлагатай бол эд мөрийн баримтыг эзэмшигч, эсхүл зохих баг, хорооны Засаг дарга, шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, цагдаагийн байгууллага, тэдгээрийн албан тушаалтанд ...” этгээдүүдэд тухайн шүүхийн тогтоол болон шүүгчийн захирамжаар нотлох баримтыг хамгаалах арга хэмжээг авахыг даалгах байдлаар нэмэлт өөрчлөлтийг оруулах.

Иргэний хэргийн нотлох баримтыг хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулж буй эрх зүйн зохицуулалтын талаар судалгааг

хийх явцад хэрэгт хамаарал бүхий нотлох баримтыг хамгаалах ажиллагаатай холбоотой тусгайлан зохицуулалт хийх эрх зүйн зохицуулалтыг шинээр боловсруулж гаргах нь чухал байна.

Тухайн эд мөрийн баримтын шинж чанараас хамаарч хэрхэн хамгаалалт тогтоох талаар нарийвчилсан зохицуулалтуудыг хуульд тусгаж өгөх нь эд мөрийн баримтын нотлох чадамжаа алдахаас сэргийлэх чухал ач холбогдолтой. Хөдөлгөөнт эд зүйл, түргэн гэмтэх эд зүйл, үлдсэн мөр, үнэр гэх мэт эз мөрийн баримтуудыг хэрхэн хамгаалах арга, хэлбэрийг хуульчлах шаардлагатай байна. ОХУ болон БНСУ-д хувьд иргэний хэргийн нотлох баримтыг хамгаалахтай холбоотой тусгайлан журам үйлчилдэг байна. Манай улсын хувьд тус харилцааг зохицуулж буй эрх зүйн зохицуулалт нь хэт ерөнхий байгаа тул тус харилцааг хангалтай зохицуулж чадахгүй байгааг судалгаанаас ажиглагдав.

Энэ бүгдээс үндэслэн хүчин төгөлдөр үйлчилж буй ИХШХГТухай хуулийн 50-р зүйлд буй Нотлох баримтыг хамгаалах гэдэг нэр томъёог эргэн харууштай санагдав. ОХУ, бусад гадаадын хуульд “нотлох баримтыг хангах, хангуулах” гэсэн нэр томъёо байгааг эрхбиш харгалзах нь зүйтэй хэмээн үзэж байна.



НАСАНД ХҮРЭЭГҮЙ ӨВЛӨГЧИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН АСУУДАЛ



*Б.Уранчимэг
Магистрант*

Түлхүүр үг: Насанд хүрээгүй өвлөгч, өвлүүлэгчийн асрамжинд байгаа хөдөлмөрийн чадваргүй иргэн, өвлөгчийн хууль ёсны эрх ашиг, насанд хүрээгүй өвлөгчийн өвлөх эрхийн зохицуулалт

Товч агуулга: Өгүүлэлдээ Монгол Улс дахь өв залгамжлалын харилцаанд насанд хүрээгүй өвлөгчийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал, түүнийг боловсронгуй болгох асуудлын талаар авч үзэв.

Манай улс зах зээлийн эдийн

засагт шилжин орсны үр дүнд иргэдийн эд хөрөнгө шударгаар олж авах, өмчлөх, өвлүүлэх эрх үндсэн хуулиар баталгаажиж иргэд эд хөрөнгөө чөлөөтэй өмчлөх боломж, нөхцөл бүрдэхийн хэрээр өв залгамжлалын харилцааны агуулга улам бүр өргөжиж байна. Өв залгамжлалын харилцаа өсөн нэмэгдэхийн хэрээр практикт хууль ёсны өвлөгч мөн эсэхийг тогтоолгох, өвлүүлэгчийн гэрээслэл хүчинтэй эсэх талаар ээдрээ төвөгтэй асуудал нэлээд гарч ирэх болов. Иймээс насанд хүрээгүй өвлөгчийн хууль ёсны эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалт бүр ч илүү анхаарал татсаар байна. Тухайлбал, Монгол Улсын Иргэний хуулийн 520 дүгээр зүйлийн 520.3-д “өвлүүлэгч нас барахаас өмнө нэгээс доошгүй жилийн хугацаанд түүний асрамжинд байсан хөдөлмөрийн чадваргүй иргэн хууль ёсны өвлөгчид тооцогдох бөгөөд өөр өвлөгч байвал энэхүү асрамжинд байсан этгээд нь тэдгээртэй адил хэмжээгээр өвлөнө” гэж заасан байдаг боловч хөдөлмөрийн чадваргүй иргэн буюу насанд хүрээгүй этгээдийн хувьд өвлүүлэгчийн асрамжинд байснаа эрх бүхий байгууллагаар тогтоолгоогүй, хууль ёсны өвлөгч гэдгээ мэдээгүйн улмаас эрхээ хэрэгжүүлэх боломж алдагдсаар



байна.

Асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь нас барсан тохиолдолд насанд хүрээгүй иргэдийн бие даан эрхээ хэрэгжүүлэх боломж нь хуулиар хязгаарлагдмал тул өөрт оногдох өвийг өвлөхгүй хохирч үлдэх нь цөөнгүй байна. Тиймээс бид насанд хүрээгүй өвлөгч, улмаар бусдын асрамжинд байгаа насанд хүрээгүй өвлөгчийн өвлөх эрх, түүнд тулгамдаж буй асуудлыг судалж, шийдвэрлэх арга зам, эрх зүйн зохицуулалтыг нь боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Иймээс насанд хүрээгүй өвлөгч, өвлүүлэгчийн асрамжинд байсан хөдөлмөрийн чадваргүй иргэний өв залгамжлах эрхийг хуулиар хангасан байдал, түүний хэрэгжилтэд тулгамдаж байгаа асуудлыг судлан, шийдвэрлэх боломж, арга замыг эрэлхийлэхэд энэхүү өгүүлэлээ зориулав.

Нэг. Насанд хүрээгүй өвлөгчийн өв залгамжлалын тухай ойлголт

Хүн хүүхэд төрүүлэх, өсгөж хүмүүжүүлэх үүрэг нь эцэстээ өв залгамжлалтай зайлшгүй холбогддог. Иргэний хуулийн 520 дүгээр зүйлийн 520.1.1-д зааснаар нас барагчийн эхнэр, нөхөр, төрүүлсэн болон үрчилсэн эцэг, эх гэсэн насанд хүрэгчдээс гадна төрүүлсэн, үрчилсэн, нас барсан хойно төрсөн хүүхэд нэгэн адил нэгдүгээр ээлжийн хууль ёсны

өвлөгчид болдог. Хүүхдүүд эрх тэгш өвлөх эрх эдлэх бөгөөд хууль ёсны дагуу аль нэг эрэгтэй хүүхэд, айлын ууган эсвэл отгон хүүхэд хэмээн давуу эрх эдлэхгүй боловч тогтсон уламжлал, заншлын дагуу отгон хүүхэд гал голомтоо залгадаг гэсэн эртний заншлыг өвлөгч нар дагахаар шийдвэрлэж болох бөгөөд өв залгамжлалын эрх зүйд зан заншил, уламжлал шийдвэрлэх нөлөөтэй байдаг.

Монгол Улсын Үндсэн хуульд “Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” гэж заасны дагуу нийгмийн бүхий л орчин, харилцаанд хүүхдийн эрхийг хангах, хамгаалахад чиглүүлж, эрх зүйн цогц орчинг бүрдүүлэхэд төр тодорхой харилцааны хүрээнд хамгаалалт хийхээр тусгагдсан. Тухайлбал, энэхүү харилцааны хүрээнд Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 8-р зүйлийн 8.5-т “Хүүхэд хуульд заасан үндэслэл журмын дагуу өөрт ногдох эд хөрөнгийг өмчлөх, өвлөх эрхтэй” төдийгүй Иргэний хуулийн 17-р зүйлийн 17.2-т “өөртөө хохиролгүй бөгөөд хиймэгц биелэх, ахуйн чанартай жижиг хэлцлээс бусад хэлцлийг тэдгээрийн нэрийн өмнөөс хууль ёсны төлөөлөгч хийх эрхтэй” байхаар тус тус хуульчлан заасан. Түүнчлэн Гэр бүлийн тухай хуулийн 25-р зүйлийн 25.3-т зааснаар “Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхдийн эрх, ашиг сонирхолыг хамгаална”, мөн хуулийн 69-р зүйлийн 69.1.2-



т зааснаар “асрамж, дэмжлэгтэй байгаа хүний эрх ашиг сонирхлыг хамгаалах” үүрэгтэйгээс гадна тус хуулийн 70-р зүйлийн 70.1.1-д зааснаар “асрамж дэмжлэгтэй байгаа хүнтэй хэлцэл хийх”-ийг хориглоно гэсэн нарийвчилсан зохицуулалтыг тусгажээ.

Гэсэн хэдий ч хүүхэд нь насанд хүрэгчдээс зөвхөн насны хувьд ялгаатай бус бие бялдарын хөгжил, ойлголт, оюун сэтгэхүй, мэдлэг чадвар, амьдралын туршлага, эдийн засгийн хувьд ялгаатай юм. Энэхүү ялгаатай байдлаас хамаарч хүүхэд нь томчуудаас хараат байдаг тул төр, иргэн, хуулийн этгээд хэн ч байсан аливаа нэг үйл ажиллагааг явуулахдаа хүүхдийн язгуур эрхийг нэн тэргүүнд хангахад анхаарах үүргийг хуулиар хүлээдэг.¹ Гэвч хүүхдийн энэхүү язгуур эрх ашиг нь хуулийн хүрээнд төдийлөн хангалттай бус байна.

2. Монгол Улсын эрх зүйн тогтолцоонд насанд хүрээгүй өвлөгчийн эрхийн хамгаалал зөрчигдөж буй тухай.

Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн 16-р зүйлийн 3 дахь хэсэгт “Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших,

¹ “төр, иргэн, хуулийн этгээд үйл ажиллагаа явуулахдаа хүүхдийн язгуур эрхийг эн тэргүүнд хангахыг эрхэмлэж, хүүхэд эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг тэгш хангах.” Хүүхдийн эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалт. “хүүхдийн эрх, хууль ёмний ашиг сонирхлыг тэргүүн ээжлигч хамгаалах.” Гэр бүлийн хүчирхийлэлтэй гэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалт.

өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй” гэж иргэний эд хөрөнгө өмчлөх эрхийг баталгаажуулснаас хойш 20 гаруй жилийн хугацаа өнгөрсөн байна. Энэхүү хугацаанд иргэд маань хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө, оюуны үнэт зүйл буюу эдийн бус баялгийг өмчлөх, эзэмших, ашиглах явдал нь жил ирэх тусам өсөн нэмэгдсэнээр өвийн харилцаа өргөжин тэлж байна. Үүнийгээ дагаад практикт өв залгамжлалтай холбоотой иргэний маргаан багагүй гарч байгаагаас хууль ёсны өвлөгчөөр тогтоолгох тухай маргаан нь нилээдгүй хувийг эзлэж байна. Тухайлбал, хууль ёсны өвлөгчдийн эрх ашиг, тэр дундаа насанд хүрээгүй өвлөгчийн эрх ашиг зөрчигдсөөр байна.

Монгол Улсын Иргэний хуулийн 520 дугаар зүйлийн 520.3-д “өвлүүлэгч нас барахаас өмнө нэгээс доошгүй жилийн хугацаанд түүний асрамжинд байсан хөдөлмөрийн чадваргүй иргэн хууль ёсны өвлөгчид тооцогдох бөгөөд өөр өвлөгч байвал энэхүү асрамжинд байсан этгээд нь тэдгээртэй адил хэмжээгээр өвлөнө” гэж заасан байдаг боловч хөдөлмөрийн чадваргүй иргэн өвлүүлэгчийн асрамжинд байснаа эрх бүхий байгууллагаар тогтоолгоогүй, хууль ёсны өвлөгч гэдгээ мэдээгүйн улмаас эрхээ хэрэгжүүлэх боломжоо алдах явдал гарсаар байна.

Асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь нас барсан насанд хүрээгүй иргэдийн бие даан эрхээ



хэрэгжүүлэх боломж нь хуулиар хязгаарлагдмал тул өөрт оногдох өвийг өвлөхгүй хохирч үлдэх нь цөөнгүй тохиолддог байна.

Кейс 1: Эхнэр, нөхөр хоёр авто осолд орж нас баржээ. Тэдний 9 настай хүү А, 22 настай охин Б нар нь хууль ёсны өвлөгчөөр үлдсэн. Б нь насанд хүрээгүй дүүгийнхээ асран хамаалагчаар тогтоогдсон тул өвлүүлэгчдийн өвийг хуваарилах асуудал дээр насанд хүрээгүй А-гийн өмнөөс хууль ёсны өвлөгч болох эгч нь шийдвэр гаргах нь ашиг сонирхолын зөрчилтэй тул асран хамгаалагчийн эрхийг нь хязгаарлаж өв хуваарилах үйл ажиллагаанд А-гийн эрх ашгийг хамгаалах төлөөлөгчийг Нийгмийн халамж үйлчилгээний газраас томилох гаргалгааг хуульчилан зохицуулж болох юм.

Кейс 2: Иргэн А-гийн асрамжинд хөдөлмөрийн чадваргүй насанд хүрээгүй В байсан. А нь нас барснаар өв нээгдэж түүний эд хөрөнгийг хууль ёсны өвлөгчид нь хуваан өвлөх эрх үүснэ. В нь Монгол Улсын Иргэний хуулийн 520 дугаар зүйлийн 520.3-д зааснаар хууль ёсны нэгдүгээр ээлжийн өвлөгчид тооцогддог. В-гийн асран хамгаалагч болох А нь нас барсан тул иргэний эрх зүйн бүрэн чадамжгүй В-гийн эрх ашгийг хамгаалах асуудал үүснэ. Энэ тохиолдолд түүний эрх ашгийг хамгаалахын тулд Нийгмийн халамж үйлчилгээний газраас төлөөлөгч томилох шаардлагатай.

Дээрх хоёр тохиолдлоос үзэхэд, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь нас барсан насанд хүрээгүй өвлөгч, өвлүүлэгчийн асрамжинд байсан хөдөлмөрийн чадваргүй иргэний эрх ашгийг хамгаалах асуудал тулгаран гарч ирж байгааг зохицуулсан эрх зүйн хамгаалалт үгүйлэгдэж байна.

Кейс 3: Гэрээслэгч бүх эд хөрөнгөө өөрийн төрсөн дүүдээ өвлүүлэхээр гэрээслэсэн гэж үзвэл, манай улсын Иргэний хуулиар гэрээслэгч нь бүх хөрөнгөө хууль ёсны өвлөгчид гэрээслэсэн тул бусад өвлөгчид өвлөгдөх зайлшгүй оногдох хувь гэсэн зохицуулалт үйлчилдэггүй байна. Харин ОХУ болон Франц улсын Иргэний хуулинд өвлүүлэгчийн насанд хүрээгүй хүүхдэд гэрээслэлийн агуулгаас үл хамааран өвлөгдөх хөрөнгөөс зайлшгүй оногдох хувийг хуульчилсан байдаг.

Дээрхи жишээнээс харахад Иргэний хуулийн 522 дугаар зүйлийн 522.3-д зааснаар “гэрээслэгч бүх эд хөрөнгөө хууль ёсны өмчлөгч бус этгээдэд гэрээслэх тохиолдолд өвлүүлэгчийн насанд хүрээгүй буюу хөлөлмөрийн чадваргүй, түүнчлэн түүнийг нас барсан хойно төрсөн хүүхэд, түүний асрамжинд байсан хөлөлмөрийн чадваргүй эхнэр / нөхөр/, төрүүлсэн болон үрчилсэн эцэг, эх, хууль ёсны бусад өвлөгчид хуульд зааснаар өвлүүлбэл зохих хөрөнгөний хоёрны нэгээс багагүй хэсгийг заавал өвлүүлнэ” гэж заасан байдаг. Хэрвээ гэрээслэгч нь



хууль ёсны өвлөгчид бүх хөрөнгөө гэрээслэсэн тохиолдолд дээрх зүйл заалт үйлчлэх боломжгүй болж, насанд хүрээгүй өвлөгч, өвлүүлэгчийн асрамжинд байсан хөдөлмөрийн чадваргүй иргэнд өвөөс хувь оногдохгүй байх үндэслэл байна. Ингэснээр зайлшгүй оногдох хувь нь гэрээслэгчийн хэнд эд хөрөнгөө гэрээслэхээс шууд хамааралтай болж байна.

Өвлөгдөх эд хөрөнгийг хүлээн авах эрх шилжихдээ Иргэний хуулийн 529-р зүйлд “өвлөгч нь өв нээгдсэний дараа уг өвийг хүлээн авч чадалгүй нас барсан бол өвлөгдөх эд хөрөнгөөс түүнд оногдох хэсгийг хүлээн авах эрх түүний өвлөгчид шилжинэ” гэж заасан нь зөвхөн өв нээгдсэнээс хойш нас барсан өвлөгчийн хүүхдүүдийн өвлөх эрх ашгийг хамгаалсан заалт болжээ. Гэтэл өв нээгдэхээс өмнө нас барсан, өвлөх эрхээ алдсан, өвөөсөө татгалзсан өвлөгч нарын хүүхдүүдийн төлөөлөн өвлөх эрхийг хангасан эрх зүйн зохицуулалт үгүйлэгдэж байна.

Түүнчлэн өвлөгдсөн эд хөрөнгийг хуваарилах асуудлыг хуульчлан шийдвэрлэхдээ Иргэний хуулийн 532-р зүйлд “зөвхөн төрөөгүй өвлөгчийн ашиг сонирхлыг хамгаалахын тулд өвлөгдвөл зохих эд хөрөнгийг хуваарилахдаа асран хамгаалах байгууллагын төлөөлөгчийг оролцуулна” гэж заасан нь бусад насанд хүрээгүй өвлөгчийн эрхийг хязгаарласан заалт болж байна. Учир нь өв

хуваарилах хэлцэлд насанд хүрээгүй өвлөгчийн эрх ашиг хөндөгдвөл тэдний эрх ашгийг хамгаалахад, мөн асран хамгаалах байгууллагын төлөөлөгчийг оролцуулах талаар хуульчлаагүй орхигдуулсан байдаг.

Өв залгамжлалын практикт хэрвээ гэрээслэгч нь хууль ёсны өвлөгчид бүх хөрөнгөө гэрээслэсэн тохиолдолд Иргэний хуулийн 522 дугаар зүйлийн 522.3-т заасан зүйл, заалт үйлчлэх боломжгүй болж насанд хүрээгүй өвлөгч, өвлүүлэгчийн асрамжинд байсан хөдөлмөрийн чадваргүй иргэнд өвөөс хувь оногдохгүй байх үндэслэл бүрдэж байна. Иймээс өвлүүлэгчийн насанд хүрээгүй хүүхэд, эхнэр \нөхөр\, өвлүүлэгчийн асрамжинд нэгээс доошгүй жил байсан хөдөлмөрийн чадваргүй иргэнд гэрээслэлийн агуулгаас үл хамааран зайлшгүй оногдох хувийг тодорхойлон хуульчлах шаардлага үүсч байна.

Өв залгамжлалын харилцаан дахь насанд хүрээгүй өвлөгчийн хууль ёсны эрхийн хамгаалалтыг зохицуулсан Иргэний хуулийн хэм хэмжээг шинжилж үзвэл, насанд хүрээгүй өвлөгч, өвлүүлэгчийн асрамжинд байсан хөдөлмөрийн чадваргүй иргэний эрх ашгийг хамгаалсан эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага тулгамдсан асуудлын нэг болсоор байна.



ХОРИХ ЯЛ ЭДЭЛЖ БУЙ ЯЛТНЫ ЭРХИЙГ ХАНГАХ ЗАРИМ АСУУДАЛ



Д.Алимаа
Магистрант

Хүн төрөлхтний бүхий л амьдралын туршид хүмүүсийн ялангуяа эрдэмтэн, судлаачдын анхаарлын төвд байсаар ирсэн судлагдахуунуудын дотор хүний эрхийн асуудал нэн чухал байр суурь эзэлдэг. Хүний эрхийн асуудал бол аливаа улс орны төр, эрх зүй, шашин, ёс зүйн өргөн хүрээг хамран хөгжиж ирсэн түүхтэй.

Хүний заяамал эрх тэр хүнийг хорвоод мэндлэхтэй нь цуг ирдэг гэдгийг суут сэтгэгчид нэгэнтээ томъёолсон юм. Өнөө үед хүний нийгмийн дотор хүн хүнээ

ялгаварлан үзэх үзэл байсаар байна. Ялангуяа хорих ялтай хүнийг хүнээс гадуур үзэх үзэл давамгайлсаар байна гэвэл хэтрүүлсэн болохгүй биз ээ. Хорих ял эдэлж байгаа хүний зарим эрхийг хуулиар хязгаарладаг хэдий ч ямар ч эрхгүй субъект биш болохыг өргөн агуулгаар ойлгож болно. Хүмүүс ялтан хүний эрхийн талаар салгаж ойлгодог, салгаж ярьдаг, салгаж тус тусад нь үздэг. Тэд хорих байгууллага ялтны эрхийг зөрчдөг гэж үздэг. Иймд ялтны эрхийн талаар эрүүгийн ял эдлүүлэх эрх зүйн шинжлэх ухааны үүднээс судлахад судалгааны ач холбогдол оршино.

Монгол улс дахь хорих ял эдлэгсдийн эрхийн талаарх нийтлэг ойлголт, үндсэн шинж нь: нэг талаар өөрийн орны чөлөөт иргэдийн, нөгөө талаар бусад улсын туршлага, олон улсын хүний эрхийн гэрээ конвенцийг зайлшгүй харьцуулан судалж, ялтны эрхийн хангалтыг боловсронгуй болгож байх ёстой.

Ялтны эрх, ялангуяа хорих ял эдлэгсдийн эдлэх эрх, хүлээх үүрэг тэдний эрх зүйн байдал нь өөрийн гэсэн өвөрмөц шинжийг агуулдаг.

Монгол улсын өнөөгийн хорих газруудад ялтны эрхийг хангаж буй байдлаас заримыг дурьдвал: Ялтныг хөдөлмөрлүүлэхдээ тэдний



хөдөлмөрлөх эрх албадлагын шинж чанарыг агуулж байгааг давхар анхаарах учиртай. ШШГТ хууль бусад хууль тогтоомжийн агуулгатай харьцуулан судлах нь шинжлэх ухааны төдийгүй практикт ач холбогдолтой.

Ялтны хөдөлмөрлөх эрх

Нийгмийн хөдөлмөрийн нэгэн өвөрмөц хэлбэр бол ялтны хөдөлмөр юм. Ялтны хөдөлмөр нь Монгол Улсын хөдөлмөрийн хууль, шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хууль, бусад хууль тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн актын хэм хэмжээгээр зохицуулагддаг. Тэдний хөдөлмөрийн үндсэн асуудлыг Засгийн газраас тогтоосон үйлдвэрийн чиглэлийн дагуу хорих анги, ялтан нэг бүрийг хөдөлмөрөөр хангах, тэдний хөдөлмөрийг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах, тохирсон цалин хөлс олгох, түүнчлэн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны арга техникийн болон үйлдвэрлэлийн соёл, ариун цэврийн зэрэг олон асуудлыг цогцоор хэрэгжүүлж ирсэн түүхтэй.

Ялтны хөдөлмөр нь тэднийг нийгмээс холдуулахгүйгээр ердийн амьдралд эргүүлэн гаргах ач холбогдолтой. Ялтныг хөдөлмөрт татан оролцуулах өөр нэг зорилго бол хөдөлмөр хийлгэж, тэдний бие мах бодийг чийрэгжүүлэн, эрүүл саруул байлгахад чиглэгдэнэ. Мөн хорих ялаас хугацаанаас өмнө тэнсэн суллах, дэглэм бууруулах

зэрэг эрх зүйн зохицуулалтыг ялтны хөдөлмөрт хандах хандлагатай ямагт холбоотойгоор зохицуулж өгсөн байдаг. 2002 онд баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол улсын хуулийн 126 дугаар зүйлд ялтны хийсэн хөдөлмөрийн үр дүнгээр шагналын хоног олгож байхаар заасан. Ялтан шүүхээс ногдуулсан хорих ялын зохих хувийг эдэлсэн, засарч хүмүүжсэн болохоо зан байдлаараа харуулж, гэмт хэрэг үйлдсэний улмаас учруулсан хохирлоо төлсөн, сахилгын зөрчил гаргаж байгаагүй, хөдөлмөрлөх үүргээ сайн биелүүлсэн ялтны ял эдэлж буй дэглэмийг бууруулах зэрэг саналыг хорих ангийн дарга шүүхэд гаргана.

Ялтны хоол, хүнс, ундны усаар хангагдах эрх

Хорих ангийн хоолны чанар ба хэмжээний талаар хорих ангийн дотоод журамд ялтныг хооллох тухай зохицуулж өгчээ. Үүнд: Ялтан өглөө цай, талх, өдөр орой халуун хоол, цайгаар хангагдаж байх, эмч хоол бэлтгэх, боловсруулах, олгох явц, хүнсний хадгалалт, хамгаалалт, гал зуух, хоолны хэрэгслийн ариун цэвэр, цэвэрлэгээ, эрүүл ахуйн шаардлагад өдөр тутамд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах, хоолны дээжийг заавал авч хадгалан дараа өдөр нь устгах үүрэг хүлээнэ. Ялтанд хоногт олгож буй хоолны дээжийг улирал тутамд шинжилгээнд өгч, илчлэгийг тодорхойлуулах бөгөөд хууль тогтоомжид заасан хэмжээнд



хүрээгүй бол нэмэгдүүлэх арга хэмжээ авна. Мөн ялтан хэрэгцээтэй үед нь уух ундны усаар ангийн захиргаа хангана гэж заасан байна.

Олон жил хорих ял эдэлж буй нэг ялтан ярилцлагын үеэр "Сүүлийн жилүүдэд хорих ангийн хоол сайжирч байгаа. Тухайлбал өдөрт 3 хоол хангалттай сайн өгдөг болсон" гэж дурьджээ. Урьд нь ялтнууд хоолны материалаа өөрсдийн цалин болон гэр бүлээсээ авчруулж, хорих анги дотроо хоол хийж идэх боломжтой байдаг байсан. Ялтнуудын ар гэрт нь зарим талаар маш хүнд дарамт гэж үзэн, одоо хорих ангийн хоолны амт, чанар сайжирч ялтан ар гэрээсээ болон цалингаасаа хоол, унд авах шаардлагагүй болж өөрчлөгдсөн байна.

Хорих ангийн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж ба чанарын талаарх эрхийн хангалт

Судалгаанаас үзвэл хорих ангийн эмнэлгийн ажилтнууд өдөр бүр болон сардаа 1 удаа гэсэн давтамжтайгаар үзэж байна. Эмнэлгийн ажилтнуудын 87,9% нь ялтнууд шаардлагатай тохиолдолд эмнэлгийн тусламж авах бүрэн боломжтой гэж хариулсан байна.

Ялтнуудын 65%-д нь эмнэлгийн тусламж авах шаардлага гарч байжээ. Эдгээр ялтнуудын 81,6% нь эмнэлгийн тусламж авч байсан байна.

Ялтнуудын 80,6% нь хорих

ангид эмнэлгийн үйлчилгээг хэрхэн авах талаар мэдлэг, мэдээлэлтэй гэж хариулснаас үзэхэд энэ талын мэдээлэл хорих ангиудад хангалттай түвшинд байдаг нь харагдаж байна.

Хорих анги, цагдан хорих төв болон нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааг сайжруулах ажил хийгдсээр байгаа бөгөөд ШШГЕГ-ын мэдээллээр "2016 оны байдлаар Тогтоол гүйцэтгэх газрын Нэгдсэн эмнэлгээс нийт 6374 ялтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, 2760 өвчтэй ялтныг хорих ангиудаас Нэгдсэн эмнэлэгт шилжүүлэн хэвтүүлсэн. Мөн эрүүл мэндийн хууль, журам, стандартуудыг 2013 онд шинээр баталж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна".

Бусадтай уулзах, харилцах эрх

Ялтан зохих хяналт, хамгаалалтын дор өөрийн садан / эхнэр, нөхөр, хүүхэд, төрсөн болон хадам эцэг, эх төрсөн ах, эгч, дүү өвөг эцэг, эмэг эх, нэг ам бүлд хамт амьдардаг ач, зээ/, бусад хүнтэй түр, ойрын садантайгаа удаан хугацааны уулзалт хийж болно.

Хорих ял эдэлж байгаа ялтан хууль зүйн туслалцаа авах

Ялтны буюу түүний ойрын садан төрлийн хүмүүсээс олон нийтийн байгууллагаас бичгээр гаргасан хүсэлтийн дагуу ялтанд хууль зүйн туслалцаа үзүүлэхийн тулд өмгөөлөгчтэй уулзуулна.



Хэрэв ялтан өмгөөлөгч авахыг хүсвэл тэднийг тусгай өрөө гаргаж уулзуулах ёстой.

Хорих байгууллагын захиргаа нь хуулийн зөвлөгөө өгөх байгууллагын зөвшөөрөл, өмгөөлөгчийн хувийн үнэмлэхийг үндэслэн ялантай уулзах зөвшөөрөл олгоно.

1993 онд батлагдсан хорих байгууллагын болон хорих ял эдлүүлэх тухай хуульд анх удаа ялтан өмгөөлөл авах эрх зүйн туслалцаа авах эрхтэй гэж заасан. Энэ нь хоригдож байх хугацаандаа давтан гэмт хэрэг үйлдэх буюу нуугдмал хэрэг илэрсэн тохиолдолд дахин мөрдөн байцаалтад буцаж хэргээ шийдвэрлүүлэх үедээ өмгөөлүүлэх эрхээ хангуулдаг гэж үзэж болох хэдий ч ялтанд эрх зүйн туслалцаа авах шаардлага байнга гардаг.

Эмэгтэйчүүдийн хорих ангид: онц хүнд гэмт хэрэгт шийтгэгдсэн буюу онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон эмэгтэй ялтан 0-1 насны хүүхэдтэйгээр хорих анги дээр байж болно гэж заасан боловч тэнд хүүхдийн эрхийн хамгаалалт нь хүүхдийн эрхийн конвенцэд төдийлөн хангалтгүй байна. Тэгвэл ялтан хүссэн үедээ эрх зүйн туслалцаа авах эрх нь амьдрал дээр тэр бүр биелдэггүй.

Ялтныг ангилан хувиарлаж ял эдлүүлэх, ялтны хоолны чанар нэр төрөл хангалт эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, тэд эрх зүйн туслалцаа авах, хуулийн дагуу ялтан чөлөө авах, хөдөлмөрийн хангалт сургалт

хүмүүжлийн ажил, нийгэмшүүлэх ажил зэрэгтэй холбогдолтой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох арга замыг хууль, эрх зүйн актуудад шинэчлэн найруулж оруулах хэрэгтэй байна.

Ялтны эрхийн хангалтын талаар эрх зүйн зохицуулалтыг эрүүгийн ял эдлүүлэх ажиллагааг эрх зүйгээр зохицуулж ирсэн анхны хууль Монгол улсын дотор аливаа хэрэгтэн ялтныг засан сайжруулах ажлын тухай хуулиас өнөөгийн дагаж мөрдөж байгаа ШШГ тухай монгол улсын хууль хүртэл хуульчилж практикт хэрэгжүүлж ирсэн. Гэвч хорих ял эдлэгчид болон цагдан хоригдож буй сэжигтэн, яллагдагч, ялтны эрхийг хорих, цагдан хорих газар тэдгээрийн ажилтнууд зөрчдөг гэсэн ойлголт байсаар байна. Дэлхийн бусад орны хорих, засан сайжруулах газруудад хүний эрхийн наад захын жишиг стандартыг мөрдлөг болгодог. Тэдгээр улс орнууд НҮБ-ээс баталж гаргасан "хоригдолтой харьцах наад захын жишиг дүрэм" болон олон улсын бусад гэрээ конвенцийг мөрдлөг болгон хүний эрхийн наад захын стандарт тогтоож, мөрдөн ажилладаг юм. Тухайлбал нэг хоригдогчид ноогдох өрөө тасалгааны талбайн хэмжээ, хүний биеийн алдагдсан энергийг нөхөж байдаг илчлэгтэй хоол, хүнс, ундны ус, ариун цэврийн асуудал, агааржуулалт гэрэлтүүлэг зэргийн стандартыг тогтоож түүнийгээ дагаж мөрддөг.

Монгол улсын хорих газруудад



хорих ял эдэлж буй ялтны эрхийг хангах талаар зарим асуудал хангалтгүй байгаагийн нэг гол шалтгаан нь: Хүний эрхийн наад захын жишиг тогтоосон стандарт мөрддөггүй зөвхөн хууль, дотоод дүрэм, журам бусад эрх зүйн акт мөрдөж байгаатай холбоотой гэж

үзэж байна. Иймд цаашид аливаа хэлбэрээр хоригдож байгаа буюу баривчлагдсан хүний эрхийг хангахад чиглэгдсэн хүний эрхийн наад захын жишиг стандартыг өөрийн орны онцлогтоо тохируулан боловсруулж, батлуулан, мөрдөж ажиллах нь чухал байна.



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ УЛС ТӨРИЙН ХҮСЭЛ ЗОРИГ



Д.Мөнх-Эрдэнэ
Магистрант

Авлига нь үндэсний хүрээнээс хальж бүх улс, эдийн засагт нөлөөлөхүйц улс гүрэн дамнасан үзэгдэл болсноор түүнээс урьдчилан сэргийлж хянахад олон улсын хамтын ажиллагаа, дэмжлэг туслалцаа зайлшгүй чухал болоод байна. Авлигатай тэмцэх чиглэлээр дэлхий нийт ихээхэн анхаарч байгаагийн нэгэн тод жишээ нь НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2003 онд НҮБ-ын Авлигын эсрэг Конвенцийг баталсан явдал юм. Монгол улс энэхүү конвенцид нэгдэн

орсноос хойш нэлээдгүй цаг хугацаа өнгөрөөд байгаа ч авлигатай дорвитой тэмцэж тодорхой үр дүнд хүрч чадахгүй байгааг дэлхийн улс орнуудын авлигын жагсаалт судалгаа харуулдаг.

Ялангуяа авлига нь бусад гэмт хэрэг, тухайлбал хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, мөнгө угаах зэрэг эцэс дүндээ эдийн засгийн шинжтэй ноцтой гэмт үйлдлүүдтэй холбоотой байдаг нь түүний ямархуу хор уршигтайг харуулж байна.

Олон улсын түвшинд авч үзвэл авлига, хээл хахууль нь Хойд Африк, Өмнөд Ази болон шинэхэн үйлдвэржиж улам бүр хүчирхэгжиж байгаа Зүүн Өмнөд Азийн орнуудад газар авч, Латин Америкийн ихэнх улсуудад төрийн дээд түвшиндээ хүртэл автагдсан эх, дүн мэдээтэй байна. Харин зарим орнууд, тухайлбал Сингапур, Хонгконг хоёр авлигатай үе шатлал, зохион байгуулалттай тэмцэж чадсанаараа үр дүнд хүрч үлгэр жишээ үзүүлэлтээрээ одоо ч тэргүүлсэн хэвээр.

2016 оны байдлаар Монгол Улс “Транспаренси” олон улсын байгууллагаас гаргасан авлигалын газрын зурагт 176 орноос авлигын индексээрээ 87-д жагсаж байгаа



нь авлигатай тэмцэж буй үйл ажиллагааны үр дүн, хэрэгжилт ямар түвшинд байгааг харуулж буй үзүүлэлт. Манай орны хувьд эдийн засаг сул дорой, цалин хөлс болон амьдралын баталгаа хангалтгүй, төрийн алба улс төржилтийн бай болж цаагуураа хувийн сонирхолтой хутгалдсан зэрэг олон шалтгааны улмаас авлига ихээхэн газар авах шинжтэйд тооцогддог.

Авлига улс төрийн хүрээнд ардчилал, сайн засаглалын хөгжлийг боогдуулж, ардчилсан сонгууль, хууль тогтоох үйл ажиллагаа, хууль дээдлэх ёсыг гажуудуулж, гүйцэтгэх засаглалын чадамж, эрчийг сулруулж байна.

Монгол улс 1990 оноос ардчилсан нийгэмд шилжин орсноос хойш авлигатай холбоотой гэмт хэргүүд орчин цагийн ойлголтоор цөөнгүй гарах болсон. Энэхүү шалтгаан, нөхцлийн тодорхой хүчин зүйлийн талаар ажиглалт судалгаанд тулгуурлан авч үзвэл:

Авлигатай тэмцэх улс төрийн хүсэл зориг сул

Төрийн албан хаагчдын цалин хөлс харьцангуй бага

Төрийн байгууллагын олон шат дамжлага бүхий хүнд сурталт тогтолцоо газар авсан

Нэг нь бэлэг өгч, нөгөө нь авч сурсан нийгэмд тогтсон зан суртахуун

Төрийн албан хаагч ёс зүйн хэм хэмжээгээ баримтлахгүй байх,

энэ нь хувь хүний ёс суртахуунтай холбоотой ч авлигад өртөх гол хүчин зүйл болж байна

Эрх зүйн бүрэн бус зохицуулалт “ буюу эрх зүйн хийдэл”

Нөгөө байр, сууринаас хүнээр ажил хөөцөлдүүлж байгаа юм чинь зохих шагнал, урамшууллыг нь өгөх хэрэгтэй гэж иргэд үзсээр байна. Тодорхой асуудал шийдвэрлүүлэх, ямар нэгэн зөвшөөрөл, лиценз хөөцөлдөж буй хэн боловч төрийн байгууллагын олон шат дамжлага бүхий хүнд сурталт тогтолцооноос залхан эцэстээ аль болохоор асуудлыг түргэн шийдвэрлүүлэхийн тулд албан тушаалтанд шан харамж өгөх замыг сонгох нь элбэг тохиолддог.

Манай орны тухайд авлига хөгжин бэхжих үндэс нь банк санхүү, гадаад худалдаа, эрчим хүчний салбарууд дахь нийлүүлэлт, төрөөс хэрэгжүүлж буй уул уурхай тэргүүлсэн томоохон төслүүд болж хувираад байна. Түүгээр ч зогсохгүй төрийн захиргааны төв байгууллагууд авлигад автагдсан байдал нь орон нутаг дахь салбар нэгжид халдварлан тархаж байгаа нь нууц биш. Манай улсад шилжилтийн үеийн нийгэм эдийн засгийн тогтворгүй нөхцөл байдалтай холбоотойгоор төрийн хяналт мэдэгдэхүйц суларснаас орон нутаг дахь өөрөө удирдах ёсны болон төрийн захиргааны байгууллагууд аливаа шийдвэрийг төвөөс хамаарал багатайгаар



гаргах болсон. Энэ нь төвдөө захирагдахгүй, тэднээс эмээлгүйгээр ашиг хонжоо олох, авлига авч болох нэгэн шалтгаанд зүй ёсоор тооцогдсоор байна.

Авлигын асуудлыг дан ганц Авлигатай тэмцэх газрын үүрэг мэтээр ойлгож, тайлбарлах хандлага Монголын нийгмийн сэтгэл зүйд түгээмэл болсон нь ажиглагддаг. Хэдийгээр энэ байгууллагын үндсэн чиг үүрэг нь улс орны хэмжээнд "... авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах, нэгдсэн хөтөлбөр боловсруулах, арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтэнд нь хяналт тавих..." мөн боловч төр засгийн эрх барьж буй хүчнүүд, тэдгээрийн удирдагчдын улс төрийн хүсэл зориг, дэмжлэггүйгээр авлигатай амжилттай тэмцэж чадахгүй гэдгийг амьдрал харуулсаар байна.

Авлигатай тэмцэхэд олон түмнийг оролцуулах, ялангуяа иргэний нийгэм болон хэвлэл, мэдээллийг идэвхжүүлэх нь ихээхэн ач холбогдолтой ч улс төрийн хүсэл зоригийн асуудал голлох байр суурьтай хэвээр байна.

Улс төрийн хүсэл зориг гэдгийг бид дан ганц "улс төрчдийн" буюу тухайн улс үндэстний улс төрийн амьдралд ил тод оролцож байгаа хүмүүсийн хүсэл зориг гэж ойлгож болохгүй нь ойлгомжтой. Харин мэргэжлийн бүлгүүд, хувийн

хэвшлийнхэн, үйлдвэрчний эвлэл, шашны байгууллагууд болон иргэний нийгмийн бусад бүлгүүд зэрэг нийгмийн амьдралын бүх хүрээний хүсэл зоригийг хамааруулан авч үзэх өргөн утгатай ойлголт юм.

Улс төрийн хүсэл зориг заавал хамгийн дээд удирдлагаас гарах албагүй, гэхдээ тэндээс илэрхий дэмжлэг авахаас нааш улс оронд шударга ёсны хэрэгжилтийг хариуцсан албан тушаалтнууд өөрсдийгөө хамгаалалт, дэмжлэгтэй гэж үзэхгүй нь ойлгомжтой.

Улс төрийн албан тушаалыг хувь хүний баяжих хялбар арга зам гэж үздэг улс оронд авлигатай тэмцэх улс төрийн хүсэл зориг улам бүр хомсдох нь зүйн хэрэг. Ийм улс оронд улс төрчид албан тушаалаа ард түмэнд үйлчлэх биш өөртөө үйлчлэхэд, улс үндэстэндээ ашиг хонжоо олоход биш хэн нэгний гэр бүл, тойрон хүрээлэгчдээ баяжуулахад ашигладаг.

Улс төрийн хүсэл зориг төр засаг өөрчлөлт шинэчлэлийн замд орсноор бий болдоггүй. Хүмүүсийн зан төлвийг өөрчлөхөд цаг хугацаа, шат дараалласан цогц арга хэмжээ шаардагдах нь зүйн хэрэг. Төр засагт авилгалыг бууруулах сонирхол байвал иргэний нийгэм идэвхтэй хамтран ажиллагч нь болж тодорхой үр дүнд хүрэх зорилго бүхий үйл ажиллагааг нэхэж, өөрчлөлт шинэчлэлтийг шаарддаг.

Монгол улсын авлигатай



тэмцэх улс төрийн хүсэл сонирхлыг тодорхойлохын тулд монголын төрийг сүүлийн 10 гаруй жил дангаар болон эвсэн барьж байгаа МАН, АН гэсэн улс төрийн хоёр хүчний УИХ-ын болон Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдсөн мөрийн хөтөлбөр, эрх барьж байх үедээ авлигын эсрэг гаргасан хууль тогтоомж, хөтөлбөрүүд болон практик үйл ажиллагаатай холбоотой баримт бичгүүдийг жичлэн авч үзэхэд монголын төр өөрийн санаачилгаар авлигатай тэмцэх үйл ажиллагаагаа улам идэвхжүүлэх шаардлагатай нь ажиглагддаг.

Манай улсын хувьд авлигаас урьдчилан сэргийлэх ажилд тэр бүр ач холбогдол өгдөггүй, хууль тогтоомжийн хэрэгжилт чамлалттай, хөрөнгө нөөц болон улс төрийн хүсэл зориг дутагддаг тал бий. АТГ-ын хараат бус байдлын хангалт чамлалттай, эрх зүйн зохицуулалт учир дутагдалтай байгаа зэрэг нь авлигын эсрэг тэмцэл, үр дүн үзүүлэлтэнд нааштай ахиц өөрчлөлт гарч чадахгүй байгаагийн үндсэн шалтгаан болж байна. Иймээс авлигатай тэмцэх олон улсын чиг хандлагатай нийцүүлэн түүнтэй тэмцэх бодлого, хууль эрх зүйн орчинг улс төр, эдийн засгийн орчинтойгоо уялдуулан стратегийн шинэ бодлого боловсруулан гаргаж үйл ажиллагаагаа эрс идэвхжүүлэх шаардлага тулгарч байна. Авлигын эсрэг тэмцлийн шинэ стратеги боловсруулахдаа авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл

ажиллагааг олон жил тогтвортой хэрэгжүүлэхээр шат дараалсан арга хэмжээ авах нь зүйтэй юм.

Авлигатай тэмцэх эрх зүйн орчинг бүрдүүлэхэд дан ганц авлигын эсрэг хууль, эрүүгийн болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулиудад нэмэлт өөрчлөлийн хүрээнд хязгаарлах нь чамлалттай. Манайд бизнесийн үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээг зохицуулсан олон норм, стандарт батлагдан үйлчилж байгаа нь хүнд суртлыг нэмэгдүүлэх, авлига хээл хахуулийн хөрсийг бүрдүүлэхэд нөлөөлдөг нь нууц биш. Тухайлбал эдгээр норм, стандарт нь өөр хоорондоо зөрчилдөн биелүүлэхэд хүндрэл учруулж, улмаар төрийн зарим албан хаагчид дур зоргоороо аашлах, өөрийн үзэмжээр хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, мушгин гуйвуулах, бизнес эрхлэгчдийг дарамтлах нөхцлийг бүрдүүлэх явдал олонтой.

Манай улсын хувьд зах зээлийн эдийн засгийн нийгэмд шилжиж орсноор хөгжлийн ололт, үе шатаар эдийн засгийн шинэ төрлийн гэмт хэргүүд бий болж авлига, хээл хахуулийн арга хэлбэр нарийсч нийгмийн бүхий л салбарт амь бөхтэй, заримдаа бодит аюул учруулахаар өсөх хандлага ч ажиглагддаг.

Иймд авлига манай оронд газар авч, нийгмийг бухимдалд автуулж, хөгжлийг сааруулах, төрийн байгууллагын үйл ажиллагаа,



иргэдийн хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулж байгаа гол шалтгааны нэгэнд зүй ёсоор тооцогддог.

Улс төрийн хүсэл зориг болон хууль дээдлэх зарчмын хэрэгжилт хангалтгүй, хүнд суртал газар авсан, гарсан дүрэм журам хариуцлага сул байдгаас болж авлига тулгамдсан сөрөг асуудал болсоор байна. Энэ нь улс төр, нийгэм, эдийн засаг, ёс суртахууны шалтгаан нөхцлүүдийг ул үндэстэй судлан шинжилсний үр дүнд авлигын гэмт хэрэгтэй явуулах тэмцэлд зөв оновчтой, үйлчлэл, үйл ажиллагаатай бодлого боловсруулан хэрэгжүүлэх мөнхүү чиглэлээр цаашид байнгын ажиглалт, судалгаа явуулж байх шаардлагатайг дахин харуулж байна.

Авлигын гэмт хэргийг илрүүлэх үйл ажиллагаа нь ихээхэн цаг хугацаа шаардсан, байнгын

тогтмол хяналт, шургуу ажиллагаа, мэргэжлийн ур чадвар, сэтгэлгээ, мэдлэгт, тулгуурлан мэдээллийн найдвартай эх сурвалж, нотлох баримтыг ашиглан илрүүлдэг ээдрээ төвөгтэй процесс ажиллагаа. Авлига, хээл хахуулийн гэмт хэргийг илрүүлэх дадлага, туршлага эзэмших, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх талаар шат дараалсан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх нь туйлын чухал асуудал. Авлига, хээл хахуулийн гэмт хэргийг илрүүлэхийн зэрэгцээ урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх арга замуудыг эрэлхийлэх нь авлигын гол хор уршигийг арилгах үр дүнтэй арга хэмжээ. Иймээс авлигатай хийх тэмцэл үр дүнтэй болох эсэхэд улс төрийн тууштай бодлого, улс төрчдийн хүсэл зориг шийдвэрлэх ач холбогдолтой гэдгийг дахин онцлох нь зүйтэй биз.



МОНГОЛ ОРОН ДАХЬ НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ ЁСНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДЛУУД



И.Баасанжав
Магистрант

Монгол Улсад нутгийн удирдлагын үйл ажиллагааны нэг чухал зарчим нь хүн амын өөрөө удирдах ёс юм. Өөрөө удирдах ёс гэдгийг нь нэгд, оршин суугчид өөрсдийн амьдралын чухал асуудлаа өөрсдөө бие даан шийдвэрлэх эрх, хоёрт, уг эрхийг хэрэгжүүлэх чадвар, гуравт, эрх эдлээд үүргээ хүлээх хариуцлага хэмээн тодорхойлж үздэг. Тиймээс ч нутгийн өөрөө удирдах ёсны агуулга мөн чанарыг энэхүү гурван үзүүлэлтээр тодорхойлох нь арга зүйн хувьд оновчтой,

ингэх нь өөрөө удирдах ёсны бодит байдлын талаар тодорхой ойлголт өгч, цаашид бэхжүүлэх арга замыг тодорхойлоход тулгуур болох үндэслэлтэй юм. Нутгийн өөрөө удирдах ёсны утга агуулга юуг илэрхийлж байна вэ гэдэг асуулт гарцаагүй тавигдаж таарна. Харьцуулсан эрх зүйн үүднээс өөрөө удирдах ёс амьдрал практикт хэрхэн хэрэгждэг талаар ажиглалт судалгаа хийж үзэхэд энэхүү ойлголт нь:

- Оршин суугчдын оролцоотойгоор асуудлыг хэлэлцэн шийдвэрлэдэг шууд ардчиллын хэлбэр,
- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон гүйцэтгэх засаглалаараа дамжуулан өөрсдийгөө төлөөлөн орон нутгийн эрхийг барих үйл ажиллагаа,
- Шууд ардчиллын зарчмыг хэрэгжүүлэн гүйцэтгэх засаглал болон өөрөө удирдлагын албан тушаалтнаа оршин суугчид нь шууд сонгох зарчим,
- Нутгийн удирдлагын эрх, бие даасан байдлыг төрийн хууль тогтоомжоор баталгаажуулах зэрэг үйл ажиллагааны цогц шинжийг агуулж байна.

Манай орны хувьд шууд ардчилалыг хэрэгжүүлэхдээ нутгийн өөрөө удирдах ёсны анхан



шатны байгууллага баг, хорооны иргэд нийтийн хурлаа хийж ажил амьдралынхаа асуудлыг хэлэлцэн шийдвэр гаргаж хэрэгжүүлж байхаар хуульчлагдсан. Гэвч бодит байдалд баг, хорооны хурлын ирц хангалтгүй, Засаг даргаа сонгох үед ихэвчлэн төрөл садан нь цуглаж, хамгийн олон хамаатан садантай хүн дарга болох нь энүүхэнд. Энэ нь юуны өмнө баг, хорооны хурлын өнөөгийн дүр төрхийг харьцуулж байна. Хэрвээ иргэдийн нийтийн хурал тухайн баг, хорооны иргэдийн аж амьдралд мэдэгдэхүйц үр нөлөөтэй, ач холбогдолтой байдаг бол хурлын ирц нь хангалттай, засаг даргаар төрөл садангийн үзүүлэлтээр бус чадвартай хүнийг сонгох боломж нөхцөл бүрдэх учиртай. Эндээс үзэхэд багийн иргэдийн нийтийн хурал гэдэг шууд ардчиллын хэлбэрийг манай орны нөхцөлд хэрхэн хэрэгжүүлэх вэ, тэр нь ямар үзүүлэлтээр илэрхийлэгдэх гэдэг асуудал зүй ёсоор тавигдана.

Тухайлбал:

- Хөдөөгийн сумдад малчид ихэвчлэн өрхийн аж ахуй эрхэлдэг, мал малын "захтай" байдаг учраас чөлөө бага,
- Хүн ам тархай байршилтай тиймээс нэлээд хугацаанд хол замыг туулж хуралдаа ирэхэд хүргэдэг,
- Ихэвчлэн "дээрээс" бэлтгэсэн асуудлыг тулган хэлэлцүүлэх замаар шийдвэр гаргаж ирсэн уламжлалт арга барилаас

төдийлөн салаагүй, тэр нь иргэдийн идэвхид сөргөөр нөлөөлдөг.

Ялангуяа эхний хоёр нөхцөл нь манай иргэдийн санаа зоригоос үл шалтгаалах шинжтэй цаашдаа ч хурал ямар байх нь тодорхойгүй, тиймээс байнгын эрэл хайгуул хийх шаардлага тулгарч байна. Түүнчлэн шууд ардчиллын хэлбэрийг яагаад сумын төвшинд хэрэгжүүлэхгүй байна гэдэг асуудал бас гарч ирнэ. Нэгдлийн үед нэгдлийн бүх гишүүдийн хурал хийдэг байсан уламжлалыг орчин цагийн нөхцөлд нийцүүлэн хэрэглэх боломж бий хэмээн бид үздэг. Ер нь "сумын" гэгдэх шууд ардчилал нь зөвхөн удирдлага зохион байгуулалт, эрх зүйн учир холбогдлоор хязгаарлагдах учиргүй. Сумын иргэд нь адилсал бүхий бүхий хүмүүсийн нийтлэг. Тийм учраас өөр хоорондоо харьцах, бие биеийн ажил амьдралын тухай мэдэх, энэ үндсэн дээр хамтын чармайлт гаргах хэрэгцээ шаардлага байнга гардаг. Гэтэл сумын Иргэдийн Хурлыг зөвхөн ИТХ-аар хязгаарлах нь энэхүү шаардлагыг хязгаарлахад хүргэдэг. Өнөөгийн нөхцөлд багийн төв орох айлуудын өөр хоорондын зайнаас болоод харилцаа холбоо нь тохиолдлын шинжтэй, заримдаа бүр хол хөндий байгаа нь нь сумын хөгжилд сөрөг нөлөө үзүүлэх нэг гол хүчин зүйл. Эхлээд эрхийн тухай авч үзье. Монгол Улсын Үндсэн хууль /1992 он/, "Засаг Захиргаа Нутаг Дэвсгэрийн Нэгж түүний



удирдлагын тухай хууль /2006 он/" болон бусад холбогдох хуулиудад Нутгийн өөрөө удирдах ёсны эрхийг баталгаажуулсан үндэс суурь болж байдаг энэхүү эрх зүйн үндсээр хэрхэн хэрэгжүүлж байгааг Орхон аймаг, Эрдэнэт хотын нутгийн удирдлагын байгууллагуудын үйл ажиллагаанд тулгуурлан ажиглалт судалгаа хийж үзэхэд ИТХ-ын үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан учраас хэлэлцсэн асуудал, давтамж зэрэг нь чухамдаа өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг харуулах чухал болох нь харагдаж байна. Хуралдаанаар орон нутгийн ажил амьдралын чухал асуудлыг онож хэлэлцэх тодорхой шийдвэр гаргаж хэрэгжүүлэх, иргэдийн санал, хүсэлтийг хуралдааны шийдвэрт тусгах зэрэг нь иргэд өөрөө удирдах эрхээ эдлэх чухал нөхцөл арга зам болж байна.

Монгол улс Нутгийн Өөрөө Удирдах Ёсны тухай асуудлыг Үндсэн хуулиндаа нэгэн бүлэг болгон тусган хэрэгжүүлж байгаагаараа дэлхийн жишигт нийцэхээр байна. Нутгийн өөрөө удирдах ёсны тухай асуудлыг Үндсэн хуулиндаа ийнхүү бүхэл бүтэн бүлэг болгон авч үзсэн улс орон харьцангуй цөөн. Монгол улсын Үндсэн хуулийн 4-р бүлгийн 57-р зүйлд "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалзан тухайн нутгийн Хурал, иргэдийн саналыг үндэслэн Улсын Их Хурал шийдвэрлэнэ" гэж заасныг энд

онцлох нь зүйтэй биз ээ.

Энэ нь Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагыг тодорхойлж өгсөн, нутаг дэвсгэрийн нэгжүүдийг өөрчлөх асуудлыг гагцхүү УИХ шийдвэрлэнэ гэдгийг тодруулж өгсөн чухал заалт, ингэснээрээ тус улс засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хувьд нэгдмэл нэг тогтолцоотой байна гэдгийг хуульчилж өгсөн юм. Монгол улсын Үндсэн хуулийн 58-р дугаар зүйлд "Аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн" гэж тодорхойлжээ. Энэ нь зарим маргаан үүсгэхэд хүргэдэг тал бий. "Цогцолбор" гэсэн үг нь орон нутаг, нийгмийн бүхий л асуудлыг бие даан шийдвэрлэж байх эрх зүйн үндсийг тогтоож бүрдүүлсэн онцлогш агуулгатай. Монгол улсын Үндсэн хуулиар аймаг, нийслэл, сум, дүүрийн хилийн цэсийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр УИХ баталдаг онцлогтой. Монгол улсын Үндсэн хуулийн 59-р зүйлийн 1-рт "Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ", "Нутгийн өөрөө удирдах байгууллага бол аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, баг, хороонд иргэдийн нийтийн хурал, тухайн хурлын хуралдааны чөлөө цагт түүний Тэргүүлэгчид мөн",



"Аймаг, нийслэлийн төлөөлөгчдийн хурлыг дөрвөн жилийн хугацаагаар сонгоно. Эдгээр Хурлын болон сум, дүүргийн Хурлын төлөөлөгчдийн тоо, сонгох журмыг хуулиар тогтооно" гэсэн онцгой ач холбогдолтой заалт бий. "Нутгийн өөрөө удирдах ёс" энд хэрэглэгдсэн үгний агуулгыг явцууруулж Нутгийн Өөрөө Удирдах Ёсыг хэрэгжүүлэгч нь орон нутагт зөвхөн ИТХ, ИНХ гэсэн ойлголт ч бий. Зүй нь энэ заалтыг нэлээд өргөн утгаар нь авч үзэх учиртай болов уу. Европын хартид уг асуудлыг нутаг дэвсгэрийн нэгж дэх хамтлагууд гэсэн ойлголтоор буюу тухайн нутаг дэвсгэрт байгаа өөрөө удирдах ёсны бүх байгууллагууд нь орон нутгийнхаа удирдлагыг хэрэгжүүлэх юм гэсэн зарчмын шинжээр томъёологдсон гэж үздэг. Манай Үндсэн хуулийн 60-р зүйлд орон нутгийн байгууллагуудын үүрэг чиглэлийг тодорхойлж, орон нутаг дахь гүйцэтгэх засаглалын үйл ажиллагааны онцлогийг дараах байдлаар тодорхойлж өгсөн байна. Үүнд: "Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрт төрийн удирдлагыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны засаг дарга хэрэгжүүлнэ. Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны хурлаас нэр дэвшүүлж, аймаг, нийслэлийн засаг даргыг Ерөнхий сайд; сум, дүүргийн засаг даргыг харьяалах аймаг, нийслэлийн засаг дарга; баг, хорооны засаг даргыг харьяалах сум, дүүргийн засаг дарга тус

тус дөрвөн жилийн хугацаагаар томилно", Ерөнхий сайд буюу дээд шатны нэгжийн засаг дарга доод шатныхаа нэгжийн засаг даргад нэр дэвшигчийг томилохоос татгалзвал энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан журмаар дахин нэр дэвшүүлж томилтол өмнөх засаг дарга бүрэн эрхээ хэвээр хадгална. Засаг дарга тухайн хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхийн хамт засаг төрийн төлөөлөгчийн хувьд харьяа нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, засгийн газар, харьяалах дээд шатныхаа байгууллагын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлыг засгийн газар, дээд шатны засаг даргын өмнө хариуцна гэж тодорхойлсон байдаг.

Түүнчлэн аймаг, нийслэл, сум, дүүргийн засаг даргын ажлын алба нь тамгын газар бөгөөд тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг засгийн газар нэг бүрчлэн буюу нэг маягаар тогтооно гэсэн нь орон нутгийн ажил амьдралд дээд шатны байгууллагууд ихээхэн нөлөөтэй байхаар нөхцөл харагдаж байна. Уг нь энэ асуудлыг тухайн орон нутгийн ИТХ нь орон нутгийн төсөвтөө багтаан бүтэц орон тоогоо өөрсдөө тогтоож байх нь ардчилсан нийгмийн суурь зарчимд нийцэх бөгөөд орон нутгийн эрх мэдэл, үүрэг хариуцлага тэр хэмжээгээр дээшилнэ. Үүнд нэг л зүйл ажиглагдаж байна. Тухайн суманд байгаль хамгаалагч нэг ч байж болно, тав ч байж болно, гагцхүү түүнийг тухайн орон нутгийнхан



өөрсдөө шийдэх нь зүйтэй юм. Төсөв санхүүгийн хүнд байдалтай байсан 1990-ээд оны шилжилтийн үед юм бүхнийг дээрээс зохицуулж байх шаардлага байсантай холбоотойгоор орон нутгийн эрхийг хязгаартай байлгах, дэг журамтай болгох зорилгоор хийгдсэн энэ мэт жижиг асуудал Монголын НӨУЁ-ны тогтолцооны бас нэг онцлог юм. Цаашдаа уг асуудал орон нутагтаа шилжих үндэслэлтэй болж ирнэ. Монгол улсын Үндсэн хуулинд Нутгийн Өөрөө Удирдах Ёсыг цогцолбор байдлаар хэрэгжүүлэхээр тусгагдсан олон чухал заалт байгаагийн нэг нь 62 -р зүйл бөгөөд, үүнд "Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэхийн хамт улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулна", "Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно. Хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно" гэж эрх үүргийг зааж өгсөний зэрэгцээ "Улсын их хурал, засгийн газраас шаардлагатай хэмээн үзсэн тохиолдолд өөрийн

бүрэн эрхэд хамаарах зарим асуудлыг шийдвэрлүүлэхээр аймаг, нийслэлийн хурал, засаг даргад шилжүүлж болно" гэж заасан байна.

Үндсэн хуулийн эдгээр зарчмыг хэрэгжүүлэх үндсэн дээр Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд Нутгийн Өөрөө Удирдах Ёсны олон чухал зарчим томъёологджээ. Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 8-р зүйлд "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан зохион байгуулж үйл ажиллагаандаа ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх зарчим баримтална" гэж заасны зэрэгцээ Нутгийн Өөрөө Удирдах Ёс гэдэг нь Монгол орны хувьд ямар байх вэ? гэдгийг томъёолохдоо "Нутгийн өөрөө удирдах ёс нь чөлөөт сонгуулиар сонгогдсон төлөөлөгчтэй, түүнд тайлагнадаг гүйцэтгэх байгууллагатай, тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн асуудлыг иргэдийн ашиг сонирхолд нийцүүлэн хуулийн хүрээнд бие даан шийдвэрлэх эрх зүйн бодит чадвар мөн" гэжээ. Энэ заалт нь Европын хартийн заалтаас нэлээд ялгаатай байдал ажиглагддаг.



Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль бүхэлдээ Нутгийн Өөрөө Удирдах Ёсны байгууллага гэж ямар байгууллага байх, ИТХ-д сонгох төлөөлөгчдийн тоо, тэр байтугай хурлын даргыг сонгох, чөлөөлөх тухай, түүнчлэн хурлын төлөөлөгчдийн бүрэн эрх зэргийг нарийвчлан тодорхойлж өгсөн зэрэг нэлээд онцлог бий. Тухайлбал, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 12-р зүйлд хурлын төлөөлөгчдийн бүрэн эрхийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын төлөөлөгч нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ, асуудал хэлэлцэн шийдвэрлэхэд таслах эрхтэй оролцох, хэлэлцэж байгаа асуудлын талаар асуулт тавьж хариулт авах, санал дүгнэлт гаргах, санал хураалгах, хуралд тодорхой асуудал хэлэлцүүлэхээр санаачлах, санал оруулах, хурлын дарга, хурлын тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, тэргүүлэгчдийг сонгох, хороо байгуулах, тэдгээрт сонгогдох, бүрэлдэхүүнд нь өөрчлөлт оруулах тухай санал, дүгнэлт гаргах, хурлаас байгуулсан байгууллага, сонгосон буюу томилсон албан тушаалтны илтгэл, сонгол хэлэлцүүлэх санал гаргах гэж дэлгэрэнгүй зааж өгчээ. Сум, дүүргийн Хурал нь Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, яам, агентлаг, дээд шатны Хуралд болон төрийн эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтанд

хуулиар харьяалуулснаас бусад тухайн нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн болон зохион байгуулалтын ямар ч асуудлыг хэлэлцэж бие даан шийдвэрлэх эрхтэй бөгөөд дараахь асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж хэрэгжүүлнэ хэмээн тодорхойлсон байна. Үүнд :

Нэгдүгээрт, Хурлын төлөөлөгчдийн бүрэн эрхийн тухай асуудал,

Хоёрдугаарт, Хурлын дарга, Тэргүүлэгчдийг сонгох, өөрчлөх асуудал,

Гуравдугаарт, Хурлын хороо, түр хороо байгуулах, түр хороог татан буулгах, хорооны дарга, бүрэлдэхүүнийг сонгох, өөрчлөх, ажлынх нь тайланг хэлэлцэх,

Дөрөвдүгээр, Засаг даргыг томилуулах, чөлөөлөх болон огцруулах санал гаргаж аймаг нийслэлийн Засаг даргад уламжлах,

Тавдугаарт, Сум, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах, тайланг хэлэлцэж үйл ажиллагаанд нь үнэлэлт, дүгнэлт өгөх, тухайн Хурлын төлөөлөгчөөс Засаг даргад тавьсан асуулгын хариуг хэлэлцэж, шаардлагатай бол зохих шийдвэр гаргах,

Зургаадугаарт, Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг Засаг дарга хэрхэн зохион байгуулж байгааг шалгах, үнэлгээ өгөх,



Долоодугаарт, Хурлын төсвийг батлах, нутаг дэвсгэрийн эдийн засаг,

Наймдугаарт, нутаг дэвсгэрийн хөгжлийн дунд хугацааны бодлого болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах зэрэг олон зүйл, заалтыг оруулсан байдаг. Түүнчлэн, орон нутгийн өмчийн талаар, орон нутгийн өмчийн зүйлсийн өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх, орон нутгийн нийтийн зориулалттай өмчид хамаарах эд хөрөнгийн жагсаалтыг батлах, хууль тогтоомжид заасан журмын дагуу түүнийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах, орон нутгийн нийтийн зориулалттай өмчлөлийн зүйлсийг хуульд заасан нөхцөл, журмын дагуу иргэн /Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн/, орон нутгийн бусад өмчийн хуулийн этгээдэд эзэмшүүлэх, ашиглуулах, орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журмыг Иргэний хуульд нийцүүлэн тогтоох, орон нутгийн өмчийн эд хөрөнгийг нийтийн зориулалттай өмчид, эсхүл өөр өмчид шилжүүлэх журмыг тогтоох, орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн эд хөрөнгө, хувьцааны өөрт ногдох хувийг тодорхойлох, түүнчлэн тухайн орон нутгийн төсвийн хөрөнгө, бэлтгэл нөөц, бусад үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах журмыг хууль тогтоомжид нийцүүлэн тогтоох, орон нутгийн өмчит хуулийн этгээд

байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, дүрмийг батлах, орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эд хөрөнгөөс бусад өмчийн этгээдтэй хамтран хуулийн этгээд байгуулах, хөрөнгө оруулах, оруулсан хувь хөрөнгөө татан авах асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх, /орон нутгийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх журам, төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалт, цалин хөлсний норм, нормативыг тогтоох; орон нутгийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналт шалгалтыг зохион байгуулах; орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах, бий болгох талаар тухайн хурлаас засаг даргад олгох эрх хэмжээг тогтоох, хяналт тавих; орон нутгийн өмчийн төлөөлөгчийн эрх хэмжээ, ажиллах журмыг тогтоох,

Есдүгээрт, хуулиар тусгайлан эрх олгогдсон тохиолдолд захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлж, мөрдүүлнэ гэж заажээ. Энэхүү хуулийн нэг томоохон онцлог бол иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны тухай нарийвчлан зааж Засаг дарга, түүний бүрэн эрхийг нэг бүрчлэн томъёолж өгсөн байдаг.

Эдгээрээс аймаг, нийслэл, сум, дүүргийн засаг даргын бүрэн эрх нэлээд өргөн хүрээтэй байхаар зааж өгснөөрөө онцлог юм. Монгол



оронд нутгийн өөрөө удирдах ёсыг хэрэгжүүлэхэд тулгамдаж байгаа үндсэн асуулт бол хуулийн эдгээр заалтад байгаа эрх мэдлийн төвлөрөл бөгөөд төвлөрөлийг сааруулах, орон нутагт төсөв санхүүгийн болон бусад эрх мэдлийг шилжүүлэх явдал байна.

Хуулийн эдгээр заалтаас үзэхэд Нутгийн Өөрөө Удирдах Ёсны байгууллага эрх мэдэл ихтэй, шийдвэрлэх асуудал арвин байгаа мэт харагдах боловч дэлхийн улс орнуудын хөгжил дэвшилд хүрсэн үндсэн шалтгаан болсон өөрөө удирдах ёсыг байгууллагуудын эрх хэмжээнд хараахан хүрэх болоогүй байна. Юуны түрүүнд баг, хорооны ИНХ-ын эрх хэмжээг өргөтгөх шаардлага байгааг дээр дурдсан. Баг хорооны иргэдийн идэвх санаачлагыг өрсүүлж, хамтач бүтээлч ажиллагааг дээшлүүлэхэд тэдэнд төсөв хөрөнгийн эрх мэдлийг шилжүүлэх учиртай. Төсвийн шинэ хууль /2013 он/-аар Орон нутгийн хөгжлийн санг байгуулж нэлээд их хөрөнгө мөнгийг ИТХ, ИНХ-уудад иргэний оролцооны аргаар шийдвэрлэж байх хууль эрх зүйн үндэс тавигдсан боловч сүүлийн үед энэ чиглэлд төсөв хөрөнгө хуваарилагдаж баг хороодод очих нь зогсонги болов. Улсын хэмжээнд 2013 онд 247.0 тэрбум, 2014 онд 140.0 тэрбум, 2015 онд 75.0 тэрбум, 2016 онд 37.0 тэрбум төгрөг ОНХ-ийн сангаас олгосон нь жил тутам буурсан үзүүлэлт юм.

Багийн иргэд хамтын хөдөлмөрийн үр дүнд хадлан тэжээл сайжруулж, хоршоо нөхөрлөл байгуулж, сангийн хөрөнгөөр орон нутагтаа бас нэг сан байгуулж, түүгээрээ хөгжил дэвшилд хүрэх өргөн бололцоо харагдаж байна. Сум, дүүргийн ИТХ-ын өмнө тулгамдаж буй чухал асуудал бол Нутгийн Өөрөө Удирдах Ёсны сургалт, сурталчилгаа, судалгаа дутагдалтай судалгаанд суурилсан хөгжлийн төлөвлөлтөө оновчтой хийж чадахгүй явсаар өнөөг хүрчээ.

Сум дүүргүүд иргэд олон түмэн, оршин суугчдынхаа оролцоотойгоор, ялангуяа бизнес эрхлэгч, баялаг бүтээгчдийнхээ оролцоо, санаачлагад тулгуурлан хөгжлийн төлөвлөлтөө хийж, ойрын болон дунд цаашдаа стратеги бизнес төлөвлөгөөгөө шинэчлэн хийх шаардлага тусгагдаж байна.

Аймаг, нийслэл, төв суурин газрууд томоохон бизнес икватор төвүүдийг байгуулах, аймаг тус бүр 2-3 аж үйлдвэр, бизнесийн цогцолбортой өөрөө хэлбэл, тухайн аймаг, хотыг "саалийн үнээ"-тэй болгох хөгжлийн маш тодорхой бодлого барьж ажиллах шаардлагатай байна. Дорноговийн аж үйлдвэрийн парк, Өмнөговийн эрдэс баялгийн цогцолбор, Дархан, Сэлэнгийн үр тарианы аж ахуйн нэгдэл, Эрдэнэтийн уулын баяжуулах үйлдвэр, Архангай, Булган, Хэнтий аймаг түшиглэсэн аялал жуулчлалын цогцолбор гэх мэтийг энд нэрлэж болох юм.



Зөвхөн уул уурхай, эрдэс баялгаас хараат бус өөр олон салбарын эдийн засгийн цогцолборууд босгож болно. Жишээ нь Говийн аймгууд байгалийн нарны гэрлийн эрчим хүчийг өргөнөөр ашиглаж, цахилгаан энергийг хөрш орнууддаа экспортлох боломж бий. Баруун бүсийн аймгуудад мал нядалгааны орчин үеийн өндөр технологийн паркууд байгуулж дэлхийн зах зээл дээр махан бүтээгдэхүүний экспорт хийх ирээдүй байна.

Баруун бүсийн аймгуудад олон улсын торгоны замын их урсгал ойрхон өнгөрч байгаа, түүнчлэн Тува-Эрдэнэтийг холбосон төмөр зам тавигдах ирээдүй байгаа.

Эцэст нь дүгнэж хэлэхэд Монгол оронд Нутгийн Өөрөө Удирдах Ёсны зарчмыг хэрэгжүүлэхэд орон нутгийн бие даасан бүтээлч сэтгэлгээ, чөлөөтэй үйл ажиллагаа, эрх зүйн таатай орчин чухал бөгөөд тулгамдсан асуудал болоод байна. Үүний тулд орон нутагт зориулсан хөрөнгийг аль нэг яамдаар дамжуулах биш, яамны сайдын нэг багцад өгөх биш аймаг, орон нутагт өөр нь шууд шилжүүлэх шаардлагатай.



ХАЛААСНЫ ХУЛГАЙН ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ АРГА ЗАМУУД



*Н.Алтангэрэл
Магистрант*

Эрүүгийн хуулийн “Бусдын өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг” бүлэгт заасан Монгол улсад түгээмэл үйлдэгддэг нийгмийн хор аюул ихтэй гэмт хэргийн нэг бол бусдын эд хөрөнгийг хулгайлах явдал юм. Сүүлийн 5 жилийн судалгаагаар Монгол улсад үйлдэгдэж байгаа нийт гэмт хэргийн 60 гаруй хувийг бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг дангаар эзэлж байгаа нь үүнийг нотолж байна.

Түүнчлэн сүүлийн үед хулгайн гэмт хэргийн тоо өсөхийн зэрэгцээ

түүний улмаас нийгэм, төр, иргэд, аж ахуйн нэгж байгууллагад учруулах хохирлын хэмжээ нэмэгдэж, орон байрны болон малын хулгай, халаасны болон тээврийн хэрэгслийн хулгайн гаралт өсч, илүү зохион байгуулалттай, мэргэшсэн шинжтэй болж байгаа нь анхаарал татаж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох, урьдчилан сэргийлэх талаар бодитой, үр дүнтэй арга замыг тодорхойлох шаардлагыг нөхцөлдүүлж байна.

Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн криминологи шинжийн хүрээнд Монгол улсад үйлдэгдэж буй хулгайлах гэмт хэрэг, түүний дотор халаасны хулгайн гэмт хэргийн гаралт, бүтэц, түүнд гарсан өөрчлөлт, хөдөлгөөнд судалгаа хийхэд 2011-2015 онуудад халаасны хулгайн гэмт хэргийн нийт хулгайлах гэмт хэргийн бүтцэд эзлэх хувь нь 0,7-1 дахин өссөн байна.

Сүүлийн 5 жилд халаасны хулгайн гэмт хэргийн улмаас зөвхөн өргөдлөөр авсан бүртгэлээр 654,500,000 төгрөгний хохирол учирч, үүнээс 208,900,000 төгрөгний хохирлыг хэрэг бүртгэлтийн шатанд нөхөн барагдуулсан байна. Дээрх тоо баримт зөвхөн бүртгэгдсэн хэргээс учирсан хохирлын тоо



хэмжээ юм. Гэтэл үүнээс нуугдмал гэмт хэрэг 3 дахин их байдаг гэж үзвэл барагцаагаар 1,963,300.500 төгрөгний хохирол сүүлийн 5 жилд учирсан байх боломжтой. Н и й т хохирлын 31,9% эргэн төлөгдөж байгаа нь иргэд энэ төрлийн хэргийн улмаас их хохирч үлддэгийг харуулж байна.

Халаасны хулгайн гэмт хэрэг нь хүн олноор цугларсан газрууд, үүнд нийслэлийн төвлөрсөн томоохон зах, их дэлгүүрүүд болон Нарантуул худалдааны төв, Дэнжийн-1000, Да хүрээ зах, Баянзүрх хүнсний зах, Меркури, Барс-1, 2, Бөмбөгөр, Хархорин, Теди төв, Тэнгис кино театр, УИД, УВ март, Метромалл, Скай, 3, 4-р хорооллын дэлгүүр болон үзвэр үйлчилгээний газар, автобусанд гэмт этгээд нь хүмүүсийн гадна төрх, биеэ авч яваа байдлаас нь хохирогчийг сонгон авч зориудаар шахах, түлхэх аль эсвэл согтуу хүний дүр эсгэж анхаарлыг нь сарниулж хулгайн гэмт үйлдлээ гүйцэлдүүлдэг байна. Мөн баяр ёслолын үеэр Төв цэнгэлдэх хүрээлэн, морь барианы газар, шоу цэнгээн, ямар нэгэн олныг хамарсан үйл ажиллагаа явагдаж байгаа газруудад үйлдэгддэг.

Халаасны хулгайн гэмт хэрэг үйлдэгддэг цагийг судлах нь тусгай төлөвлөгөөний дагуу нэгдсэн болоод хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулж, уг гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээг явуулахад ач холбогдолтой юм. Халаасны

хулгайн гэмт хэрэг нь өглөө /07:00-10:00/ оройд /17:00-20:30/ хүмүүс ажил тарах үеэр том оврын автобус, автобусны буудлаар ихэнхдээ үйлдэгдэж байна. Бас гадаадын аялал жуулчлалын цаг буюу урин дулааны улирлаар ихээр гарч байна. Жуулчид ирсэн үеэр халдлагын зүйл нь ихэнхдээ зургийн аппарат, камер, гар утас зэрэг болдог. Намар хичээл сургууль цугларах үе, мөн хавар их дээд сургуулиудын хонхны баяр, оюутан сурагчдын төгсөлтийн үеэр, малчид хөдөөгийн иргэд хөдөө орон нутгаас өвлийн бэлтгэлээ хангаж, бараа материал авах, ноос ноолуур тушаах үеэр их гарч байна. Мөн томоохон баяр ёслолын үе буюу Шинэ жил, Цагаан сарын үеэр нилээдгүй гардаг.

Халаасны хулгайч нар юуны өмнө шударгаар хөдөлмөрлөх замаар амьдрах нөхцлөө хангахыг огт хүсдэггүй, бусдын эрх ашиг сонирхлыг үл тоомсорлодог, өөрийн өрөөсгөл хэрэгцээг урьдал болгодог, амар хялбар аргаар эд хөрөнгө олж хэрэгцээгээ хангах зорилготой шунахай сувдаг сэтгэлтэй, бусдыг өрөвдөж хайрлах сэтгэлгүй хүйтэн, цэвдэг, ашиг хонжоо олж байвал юу ч хийхээс буцахгүй хохирогчийг биеэ хамгаалах чадваргүй болон бусдын анхаарлыг нь сарниулж, эсхүл нь түр сарнисан байдлыг ашиглан нууц далд аргаар эд зүйлийг нь хулгайлан авдаг, нэг үгээр хэлбэл аймхай хулчгар, арчаагүй этгээдүүд юм.

Тэд түр зуурын материаллаг



хэрэгцээгээ ямагт оюуны хөдөлмөрөөс дээгүүр тавьдаг ядраг хүмүүс болох нь хулгайлах замаар олсон мөнгө, эд зүйлсийг идэж уух, өмсөж зүүх, наргин цэнгэх төдийхнөөр үрэн таран хийдэг, өөрийнхөө оюуны хэрэгцээг олт анхаардаггүй онцлогтой. Хулгайч нарын оюуны хэрэгцээ сонирхол явцуу түгжигдмэл байхын зэрэгцээ хөрөнгө мөнгө, үнэт эд зүйл хуримтлуулах сонирхол нь бас хөгжсөн байдаг.

Халаасны хулгайчийн дээрх сэтгэл зүйн онцлог, сэдэлт, дур сонирхол нь түүний амьдралыг тэтгэх хэрэгсэл болсон халаасны хулгайн гэмт хэрэг үйлдэх өдөөгч нь болж өгдөг байна. Тэд хулгайлах үйлдлийн үр дүнд гэнэт баяжих хөрөнгөжихийн ид шидийг мэдэрсэн байдаг учраас хохирогчийн халаас, цүнхнээс эд зүйлийг хулгайлж авах шалтаг шалтгаан, аятай нөхцөл бүрийг чадварлаг ашиглах, энэ гэмт хэргийг үйлдэхэд хэзээд бэлэн байдаг сэтгэл зүйн онцлогтой. Хулгайч нарын сэтгэл зүй нь нэг талаас нийгэм ард иргэдийн эсрэг бат тогтсон харш үзэл бодол, дадал зуршилтай нөгөө талаас нийгэмд ашигтай зан төлөвийн эерэг шинжээр хомсхон байдаг. Өөрт тохиолдсон хүнд нөхцөл, зөрчилдөөнтэй тухайлбал наад захын хэрэгцээний зүйлээр дутагдах, гачигдах бэрхшээлийг халаасны хулгай хийх замаар даван туулж болно гэж итгэж байдаг. Удаан хугацаагаар нийгэмд харш амьдралаар амьдрах

нь хулгайчийн танин мэдэхүйн үйл явцыг сааруулдаг. Тэдний сэтгэх үйл явц нь байнга эрхэлдэг гэмт үйл ажиллагааны хүрээгээр хязгаарлагдана.

Хохирогчийн цүнх, халаас, торноос бусдын эд зүйлийг суйлж болон зүсэж нууц далд аргаар өөрийн эзэмшилд авах, гэмт хэргийн ул мөрөө баллах, бусдыг гэмт үйл ажиллагаанд татан оруулах чадвар нь мэргэжсэн шинжтэй болсон байх нь цөөнгүй. Хулгайч нар гэмт үйлдлээ бусдын нүднээс далд нууцаар хийдэг нь тэдний зоригийн шинж сул хөгжсөнтэй холбоотой. Хулгайлах аргаар амьдрах муу зуршилаас салж чадахгүй дахин гэмт хэрэг үйлдэж байгааг зоригийн шинжтэй холбож тайлбарлах нь зүйтэй.

Халаасны хулгайчид "халаасны хулгай бол цэвэрхэн", "азаар багатай, унаа холтой", "гар дээрээсээ шүүрүүлээгүй, гардуулаагүй тохиолдолд хэргээ хүлээнэ гэж хэзээ ч үгүй" гэх мэтээр ярьдаг, ойлгодог. Мөн олон шат дамжлагагүй бэлэн мөнгө орж ирдэг болохоор халаасны хулгайгаа зүйл бүрээр магтдаг байна. Халаасчид бусад гэмт этгээдүүдээс өвөрмөц этгээд үг хэллэгээрээ хоорондоо ярилцдаг, энэ нь гадны ямар нэгэн хүн хэн ч сонссон ойлгохгүй бөгөөд харин өөр хоорондоо бол маш богинохон цөөхөн үгээр халаасны хулгайтай холбогдсон асар их зүйлийг товчхон ойлголцдог.



Халаасны хулгайчид бүгд явах маршрут, хэзээ хаана уулзах зэргээ хулгай хийхээр гарахаасаа өмнө тохиролцож эцэст хаана орогнож байрлахаа нарийн товлодог. Эцэст нь хаана нэг газар товлон уулзацгааж хулгайн мөнгө, эд зүйлээ зарж борлуулж, наргиж шөнөдөө хоноглоно. Нийслэл хотод одоогийн байдлаар халаасны хулгайн гэмт хэрэг үйлддэг болох нь тогтоогдож, сэжигтэний бүртгэлд орсон 780 этгээд, 34 бүлэглэл байдаг. Халаасны хулгайн гэмт хэрэг үйлддэг сэжигтэн нарын 57,6 хувийг эрэгтэйчүүд, 22,3 хувийг эмэгтэйчүүд, 20 хувийг насанд хүрээгүй хүүхдүүд эзэлж байна.

Халаасны хулгайн гэмт хэрэг үйлддэг сэжигтэний бүртгэлд байгаа 780 этгээд дээр судалгаа явуулахад 30 гаруй хувь нь бүрэн дунд боловсролтой, 44 хувь нь бүрэн бус дунд боловсролтой, 25 хувь нь бага буюу огт боловсролгүй хүмүүс эзэлж байна. Уг гэмт хэрэг үйлдэгчдийн дотор огт боловсролгүй /бичиг үсэг тайлагдаагүй/ хүмүүс зохих хувийг эзэлж цаашид өсөх хандлагатай байгаа нь 1990 оноос хойш амьдралын боломжгүйгээс болон эмх замбараагүй байдал газар авснаас хүүхэд сургууль завсардах явдал ихэссэнтэй шууд холбоотой.

2014 онд хулгайн эд зүйлийн 320 буюу 48,6 хувийг гар утас, 308 буюу 46,8 хувийг бэлэн мөнгө, бичиг баримт, 22 буюу 3,3 хувийг валют, камер аппарат, 8 буюу 1,2 хувийг алт, мөнгө, үнэт эдлэл, хөөрөг

эзэлж байна. 2015 онд хулгайн эд зүйлийн 312 буюу 41,3 хувийг гар утас, 375 буюу 49,6 хувийг бэлэн мөнгө, бичиг баримт, 54 буюу 7,1 хувийг валют, камер аппарат, 14 буюу 1,8 хувийг алт, мөнгө, үнэт эдлэл, хөөрөг эзэлж байна.

Суйлж авах, тор, гар цүнх зүсэж авах /бритва хэрэглэх/ нь халаасны хулгайч нарын гол арга байдаг. Эдгээр аргаар үйлдэхдээ бүгд янз бүрийн байдлаар халхавчилдаг. Жишээ нь: хулгайчдын ярьдгаар гителдэх буюу өөр хамт яваа хүмүүс нь биеэрээ хаах, "сайн нөхрөө ашиглах" гэж ярьж заншсанаар гардан үйлдэгч нь өөрөө тор, пиджак бусад эд зүйл гар дээрээ тохож халхавчлан хийдэг байна. Хэрэглэж байгаа гол хэрэгсэл нь бритва юм. Бритвийг маш олон янзаар хугалж заримдаа бүр зориудаар ишилсэн байдаг. Халаасны хулгайн гэмт хэрэг үйлддэг сэжигтэн этгээдүүдийн 20-30 хувь нь зүсэж хулгай хийдэг. Эдгээр нь ихэнхдээ эмэгтэйчүүд байдаг.

Хулгайлах гэмт хэрэг үйлдэгдэх үндсэн нөхцөл, шалтгааныг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тогтоон, гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх ажлыг зөвхөн цагдаа, хуулийн байгууллагын хүрээнд бус өргөн хэмжээнд олон нийтийг хамарсан нэгдсэн цогц арга хэмжээг авах шаардлагатай байна. Миний үзэж байгаагаар халаасны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаа нь эдийн засаг, нийгэм, улс төр, зохион байгуулалт, эрх зүйн,



техникийн болон хүмүүжлийн шинж чанартай дараах арга хэмжээгээр хэрэгжих ёстой. Үүнд:

1. Халаасны хулгайн гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлагын үр нөлөөг дээшлүүлэх, 2017 оны 7-р сарын 01-ээс хэрэгжих Эрүүгийн хуулинд боломжит өөрчлөлт орсон бөгөөд үр дүнг нь тодорхой хугацааны дараа дүгнэж, тусгайлан авч үзэх

2. Халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцдэг Нийслэлийн Цагдаагийн газрын харьяа Халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх 4-р хэлтсийн орон тоог нэмэгдүүлэх, ажлын арга барил, үр дүн зохион байгуулалтыг сайжруулах

3. Халаасны хулгайн гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцлийг нэг бүрчлэн судлах, энэ чиглэлээр дорвитой судалгааг хийх, энэ үндсэн дээр урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх

4. Нэгэнт үйлдэгдсэн халаасны хулгайн гэмт хэрэг, хулгайчдыг халуун мөрөөр нь түргэн шуурхай илрүүлэх, хулгайч бүр гэмт үйлдлийнхээ төлөө заавал хариуцлага хүлээж байх нөхцлийг хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын шуурхай ажиллагаагаар бүрдүүлэх, халаасны хулгайн гэмт хэрэг үйлдэн шийтгэгдэж байсан хүмүүс, хорихоос суллагдсан хүмүүсийн зан байдал, үйл хөдөлгөөнөөрөө хулгайлах гэмт хэрэг үйлдэж болзошгүй хүмүүсийг олж тогтоон, бүртгэлд авч хяналт тавьж ажиллах

5. Халаасны хулгайн гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйлийг зарж борлуулдаг сүлжээг илрүүлж, хулгайн эд зүйл зарагддаг газруудад тавих хяналтыг сайжруулах

6. Халаасны хулгайн гэмт хэрэг голчлон гардаг дүүрэг, зах, томоохон их дэлгүүрүүд олон нийтийн газруудад тавих техникийн хяналтыг сайжруулах, суурин болон зөөврийн камер байрлуулах

7. Их хэмжээний мөнгө, үнэт зүйлийг биедээ авч явахгүй байхыг анхааруулах, иргэдийн сонор сэрэмжийг дээшлүүлэх, төлбөр тооцоог бэлэн бусаар хийх, энэ үүднээс банкны болон цалингийн картуудыг өргөнөөр ашигладаг болгож хэвшүүлэх замаар сэрэмжлүүлэх сургалт сурталчилгааг олон төрөл, хэлбэрээр зохион байгуулах, иргэдийн сонор сэрэмжийг дээшлүүлэх

8. Халаасны хулгайчдыг нэг бүрчлэн бүртгэл судалгаатай болгох, бүлэг хань хамсаатныг болон гэмт хэрэг үйлддэг маршрут хөдөлгөөнд гүйцэтгэх ажлын хяналтанд авч ажиллах

9. Халаасны хулгайн хэрэгт явуулах хэрэг бүртгэлтийн ажиллагааг хуулийн дагуу бүрэн дүүрэн явуулах, гэм бурууг тухай бүр хуулийн дагуу хөтөлж зохих хариуцлага, ялыг ялгамжтай шударгаар оногдуулж байх, тэдэнд ял завшуулахгүй байх

10. Халаасны хулгайн



гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, иргэний нэхэмжлэлийг хангах арга хэмжээг хэрэг бүртгэлтийн шатанд тухай бүр авч хэрэгжүүлэх

11. Хот суурин газруудад баяр ёслолын үе, нийтийн тээврийн хэрэгслийн оргил ачааллын үе, гадаадын жуулчид ирэх үе зэрэг халаасны хулгайн гэмт хэрэг ихэсдэг үед халаасны хулгайч нарыг илрүүлэх зорилгоор тухай бүр шуурхай илрүүлэх, эрэн сурвалжлах хэсгийг ажиллуулах

12. Халаасны хулгайн гэмт хэргийн дотор нуугдмал, илрээгүй гэмт хэрэг ихэнх хувийг эзэлж байдаг учир бусдын эд хөрөнгийг хулгайлсан нуугдмал гэмт хэргийг нөхөн илрүүлэхэд гүйцэтгэх ажлын хүч хэрэгслийг бүрэн дүүрэн ашиглах зэрэг болно.



ҮР ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАЛТ, ТЭЭГЧ ЭХЭД ХОЛБОГДОХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ



П.Анхжаргал
Магистрант

“Би бол ердөө л нэг хүн. Бусад бүх хүмүүсийн адилаар би хэзээ, яаж энэ ертөнцөд гарч ирснээ санахгүй байна. Бид өөрсдийгөө хэдий хойно, бага наснаас гарахдаа, төрсөн маань бүхий л цаг хугацааны эхэнд, аль дээр үед болсон мэт санагдах үед мэдэрч эхэлдэг. Бид жүжгийн эхэнд нь хоцорч ирээд үйл явдлынх нь явцад хоцроод үзээгүй нэгдүүгээр үзэгдэлд юу гарсан тухай таамаглахыг хичээж буй үзэгчид шиг амьдарч байгаа билээ”

Диана Сеттерфилд. Арвангурав дахь үлгэр

Үр шилжүүлэн суулгалтын тухай ойлголт, түүний үүсэл

Үр шилжүүлэн суулгах аргын

үндсэн зарчим нь: Эр, эм бэлгийн эсүүдийн хооронд үр тогтох үйл явц нь эхийн хэвлийгээс өөр газар буюу лабораторийн тусгай нөхцөлд явагддаг бөгөөд үр тогтсон өндгөн эсийг тодорхой хугацааны дараа эхийн умайд суулгаж өгдөг юм. Уг аргын давуу тал нь үр тогтоход саад болох байдлыг шууд даван туулж үр тогтоох арга юм. Тухайлбал, үргүйдлийн гол шалтгаануудын нэг болох умайн гуурсан хоолойн битүүрэл, эндомиетриоз зэрэг эмгэгүүдийн үед үр тогтолт үүсдэггүй. Эдгээр эмгэгүүдийн эмийн болон мэс заслын эмчилгээ нь олон жил үргэлжлэх боловч зарим үед үр дүнгүй ч байх тохиолдлууд бий. Тэгвэл үр шилжүүлэн суулгах аргыг сонгосноор үргүйдлийн асуудлыг 2-3 сарын хугацаанд шийдвэрлэх боломжтой юм. Түүнээс гадна үр шилжүүлэн суулгах оролдлого бүр нь үр тогтсон ч, тогтоогүй ч эмчилгээний шинж чанартай байдаг бөгөөд гэнэтийн байдлаар өөрөө үр тогтож жирэмслэх тохиолдлууд ч цөөнгүй байдаг. Эмэгтэй хүний бие махбодь өөрийн алдагдсан үүргээ сэргээж байгаагийн илрэл болдог.

Тээгч эхийн тухай ойлголт, түүний үүсэл

Тээгч эх гэдэг нь хүүхэд төрүүлэх насны эмэгтэй бөгөөд



төлбөртэй эсвэл төлбөргүй нөхцөлөөр генетикийн эцэг эхийн хүүхдийг төрүүлэхээр зөвшөөрч, тухайн хүүхдийн эх болохгүй байхаар хүлээн зөвшөөрсөн этгээд болно. Хүүхдийг төрсний дараа генетикийн эцэг эх нь түүний хууль зүйн эцэг эх хэмээн бүртгүүлдэг. Ихэнх тохиолдолд тээгч эхийн туслалцааг эмэгтэй хүн эмнэлгийн шалтгаанаар хүүхдээ тээж, төрүүлэх боломжгүй болсон гэр бүлийн хосуудын үргүйдлийн нөхцөлд хэрэглэдэг байна. Үүнийг гагцхүү зохих чиглэлийн гинекологийн эмнэлэгт зохиомол¹ хээлтүүлгийн аргаар хэрэглэх боломжтой байдаг. Анагаах ухааны статистикаар бүх гэр бүл болсон хосуудын 20 хувь нь жам ёсоор хүүхэд гаргах боломжгүй байдаг байна.

Хууль эрх зүйн зохицуулалт дутмаг байгаатай холбоотой дараахь сөрөг үр дагавар бий болж байна:

1. Тээгч эхэд тавигдах тодорхой шаардлагыг хуульчилж, стандарт бий болоогүй байгаа учраас хэн дуртай нь тээгч эх болж, тээгч эх болсныхоо хариуд маш их мөнгө нэхэж, байр, машин унаа тэргийг нэхэх болсон олон олон тохиолдол гарсан байна.
- Мөн ургийн гажигтай хүүхэд төрөх, ямар нэгэн өвчтэй хүүхэд төрж болох магадлал ихтэй аж. Түүнчлэн тээгч эх гэр бүлийг

сүрдүүлэн их хэмжээний мөнгө ч нэхсэн тохиолдол байгаа.

2. Монгол эх хүн, эмэгтэй хүн, 9н сар хэвлийдээ тээсэн хүүхдээ хүнд шууд өгөх нь тийм ч амар биш. Эх үрийн холбоо бол хүйн холбоотой байдаг. Монголчууд бид олон олон ёс заншилтай ард түмэн.
 - Нэг талаас үргүй гэр бүлд тус болж, сайн санаж хүүхдийг нь тээж өгөх ч нөгөө талаас эх хүний сэтгэлээр хүүхдийг өгөхгүй гэсэн маргаан гарвал үүнийг хэрхэн зохицуулах талаар хуульд тусган хуульчлах шаардлагатай. Хууль, эрх зүйн хүрээнд иргэний болон эрүүл мэндийн тухай хуулийн хүрээнд гэрээ хийгдээгүй хувь иргэдийн хооронд хийгдсэн аман гэрээ учир цуцлагдах хоёр талын аль нэг нь тохиролцсон үгэндээ байж чаддаггүй, гэрээ зөрчих зэрэг асуудал мэр сэр үүсэх болжээ. Дотоодод болсон хүндрэлтэй жишээ дурдахад урьдчилгаа хөлс мөнгөө авчихсан байсан тээгч эх хүүхэд төрүүлэх тохиролцооноос няцахдаа үр хөндөлт хийлгүүлсэн, жирэмсний 21 хоногтой байхад зулбасан, тээж төрүүлсэн хүүхдээ эцэг эхэд нь өгөхгүй гэж зүтгэсэн, Давоны синдромтой хүүхэд төрсөнд төрсөн эцэг эх нь голсон зэрэг хэд хэдэн ноцтой маргаан үүсжээ. Энэ бүхнийг яах аргагүй Гэр бүлийн тухай хуулийн

¹ Экстракорпораль гэх...



шинэчлэсэн найруулгад тусгаж өгөх шаардлага тулгарч байна.

3. Тээгч эх гэсэн нэрийн дор гэмт хэрэг үүсэх хандлага бий болсон байна.
- Тухайлбал их мөнгө амлан монгол эмэгтэйчүүдийг гадаад улс оронд аваачин тээгч эх болгож, төрөх хүртэл нь асарч хандаж байсныхаа эцэст төрөөд хүүхдийг нь авсны дараа цагаачилсан хэмээн цагдаагийн байгууллагад мэдэгдэж баривчлуулах, эсхүл гудамжинд хөсөр гаргаж хаях зэрэг гэмт хэргүүд ихээхэн гарах болжээ.

Гадаад орны туршлага:

Энэтхэг Улс: Тус улсад 2002 оноос Төлөөлөн төрөх явдлыг ашиг олох зорилгоор хэрэгжүүлэх боломжтойг хуульчилж өгсөн ба гадаад валют орж ирэх чухал салбарын нэгд тооцогдох болсон байна. Нэгдсэн үндэсний байгууллагын 2012 оны судалгаагаар Энэтхэгт жилд дунджаар 3000 орчим үргүйдлийн эмчилгээний байгууллага тээгч эхээр дамжуулан 400 сая ам.долларын ашиг олдог байна.

Орос Улс: Тус улсад тээгч эхээр хүүхэд төрүүлэн авах боломж нь эхнэр нөхөр, хамтран амьдрагчид, ганц эмэгтэйд байдаг байна. Мөн тээгч эхийг хэрэглэх шалтгаан нь тухайн этгээдэд ямар нэгэн хүүхэд төрүүлэх боломжгүй эрүүл мэндийн шалтгаан байх

шаардлагатай бөгөөд, энэ нь эх өөрөө эрүүл боловч хүүхэд төрүүлэхээс зайлсхийх алхмыг хааж өгдөг байна.

Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс: Нийтийн эрх зүйн тогтолцоотой улс орнуудын гол төлөөлөгч болсон Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант улсын хувьд "Хүний үр тогтоолт үр хөврөлийн тухай хууль" (1990, 2008), "Тээгч эхийн хэлцлийн тухай акт" (1985), "Хүний үр тогтоолт, үр хөврөлийн судалгааны журам" (2001) гэсэн хууль, эрх зүйн актуудаар зохицуулах бөгөөд туслах чанарын эх сурвалжаар бусад хуулиудаар үр шилжүүлэн суулгах харилцааг бүхэлд нь зохицуулсан байна.

Америкийн Нэгдсэн Улс: 51 мужууд тээгч эхийн асуудлыг янз бүрээр зохицуулдаг байна. Зарим муж улсад төлөөлөн төрөхийг мөн энэ талаар зуучлахыг эрүүгийн хуулиараа хариуцлага хүлээлгэхээр зааж хориглосон байдаг бол зарим мужид нь уг гэрээ нь ашгийн төлөө байвал хүчин төгөлдөр бусад тооцож ашгийн бус байвал хүлээн зөвшөөрдөг байна. Гэхдээ "Тээгч эх" нь төрсний дараа хүүхдийг өгөхөөс татгалзвал нөгөө тал гэрээний үүргийг шаардах эрхгүй хэмээн хуульчилсан байдаг байна.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс: Герман улс нь "Үр хөврөлийг хамгаалах тухай" 13 зүйл, 25 заалт, 27 хэсгээс бүрдсэн



хуулийг 1990 онд батлан гаргасан. Тус хуулийн нэгдүгээр зүйлд: Тухайн этгээдийн биш өндгөн эсийг шилжүүлэн суулгахыг эмч, эмнэлгийн байгууллагад хориглож, мөн эмэгтэйд өөр эмэгтэйн өндгөн эсийг шилжүүлэн суулгавал торгох буюу 3 хүртэлх жилийн хорих ялаар шийтгэхээр заасан байдаг. Герман улсын хувьд үр шилжүүлэн суулгах IVF аргыг тодорхой хэмжээнд хүлээн зөвшөөрсөн боловч тээгч эхийн асуудлыг бүрэн хориглодог онцлогтой. Үр хөврөлийг хамгаалах тухай хуулиар үр шилжүүлэн суулгахтай холбогдолтой харилцааг нэлээд нарийн онцлог байдлаар зохицуулсан байна.

Бүгд Найрамдах Солонгос Улс: Амь эрх зүйн хуулийн 66-р бүлэг 1-р зүйлийн 4-д “мөнгө, эд хөрөнгийн ашиг болон түүнээс гаднах шалтгаанаар үр хөврөл юм уу өнгөн эс, эр бэлгийн эсийг өгөх, ашиглах, үүнийг чиглүүлсэн, холбож өгсөн хүнийг 3 жил хүртэл шоронд шийтгэнэ.”

Иргэний хуулийн 103-р бүлэгт тээгч эхийн тухай гэрээ нь нийгмийн эсрэг хуулийн үйлдэл учир гэрээг хүчингүйд тооцно гэж үздэг тул дээрх хуульд уг гэрээ нь хамаарахгүй. Солонгосын хувьд өндгөн эсээ өгсөн тээгч эх нь хуулийн дагуу эх болно. Иргэний хуулийн дагуу эх гэдэг нэр томъёог “төрүүлж өгсөн хүн” хэмээн үздэг тул тээгч эх нь эх болно. Иргэний хуулийн дагуу иргэдийн хооронд хийсэн тээгч эхийн гэрээ нь хүчингүй тул

уг гэрээтэй холбоотойгоор хүнийг шийтгэх, шүүхэд өгөх боломжгүй. Хуулийн дагуу тээгч эх нь хүүхдийн эх учир хүүхдийг тээгч эх хөлсөлсөн эмэгтэй хүний нэр дээр бүртгэх нь хуурамчаар бүртгүүлсэн хэрэг бөгөөд шийтгүүлэх боломжтой. Тиймээс Солонгос-д одоогоор тээгч эх, тээгч эхийг хөлсөлдөг хүн байдаг хэдий ч энэ нь хууль бус бөгөөд тээгч эхийн гэрээ байгуулсан ч хүчингүй.

Франц Улс: Францад бие хүний халдашгүй дархан байдлын тухай 1994 оны 7 дугаар сарын 29-ний n° 94-653 дугаар хуулинд зааснаар өөр хэн нэгэнд үр суулгахыг хориглоно. Иргэний хуулийн 16-7 дугаар зүйлд зааснаар үр суулгах үйл ажиллагааны хүрээнд зөвшилцсон бүх баримт, гэрээ хэлэлцээр хүчингүйд тооцогдоно хэмээн заасан нь шийдвэрлэх шатны шүүхийн шийдвэртэй нийцдэг. Мөн эрүүгийн хуулийн 227 дугаар зүйлийн 12-т зааснаар бие хүн, хүүхэдтэй болохыг хүсч байгаа хос ба тэдний хүүхдийг тээн төрүүлж өгөхийг зөвшөөрч буй эмэгтэй нарын хоорондын зөвшилцөн торхирох нь үйл ажиллагаа нь хууль бус хэмээн тооцож 7500 евроны торгууль оноох ба 6 сарын хорих ялаар шийтгэхээр тусгасан байдаг. Энэ хоригийг тойрч гарахын тулд зарим хосууд үр суулгалтыг хуулиараа зөвшөөрсөн гадаад улс орнуудад зорчдог. Гэвч тээгч эхээс төрсөн хүүхдийн эцэг эхийг тогтоосон гадаад улсын төрсний гэрчилгээ нь Франц улсын иргэний бүртгэлд бүртгэгдэхэд



асуудал үүсгэдэг.

Швейцарь Улс: Швейцарьт холбооны улсын үндсэн хууль нь эмнэлэг зүйн тусламжтайгаар үр суулгах тухай заасан зүйлд тээгч эхийн тухай хориглосон байдаг. Энэ хориг нь холбооны улсын эмнэлэг зүйн аргаар үр суулгах хуулинд тусгагдсан. Мөн Испани, Италид өөр хүнд үр суулгах нь эмнэлэг зүйн аргаар үр суулгах тухай хуулиар хориотой. Гэхдээ Германд эмнэлэг зүйн аргаар нөхөн үржих тухай хуулийг батлаагүй байгаа ба өөр хүнд үр суулгах тухай хориг нь үр хөврөлийг хамгаалах тухай хууль ба хүүхэд үрчлэх тухай хуулинд тусгагдсан байдаг.

ДҮГНЭЛТ

Монгол Улсад 2011 оны 11 дүгээр сард анхны үр шилжүүлэн суулгах төв үйл ажиллагаа явуулж, байгуулагдсанаас хойш эхний хагас жилийн дотор 700 хос хандсан байдаг. Үүнээс хойш үргүйдлийн эмчилгээ, үйлчилгээ илүү дэвшилтэт шатанд гарч заавал гадаадад бус Монголдоо шийдэж эхэлсэн бөгөөд одоогоор үргүйдлийн асуудлыг нэр бүхий эмнэлэг шийдэж байна. Гэвч дээрх харилцааг зохицуулсан хууль тогтоомж өдийг хүртэл бүтээгдээгүй байгаа юм. Иймд судлаач миний зүгээс шинээр эрх зүйн үндсийг бий болгох үүднээс өргөн хүрээнд судалж “захиргаа, иргэн, эрүү”-гийн эрх зүйн үүднээс хэрхэн зохицуулж болох талаар гадаад улсуудын харьцуулсан судалгааг үндэслэн

дээрх саналуудыг дэвшүүлсэн болно.

Иймд судлаач би дараах гол санаануудыг дэвшүүлсэн болно.

Үүнд:

1. Үр шилжүүлэн суулгах, тээгч эхтэй холбогдсон харилцааг зохицуулсан нарийвчилсан хуулийг бүтээх
2. Үр шилжүүлэн суулгах, тээгч эхийн үйлчилгээг үзүүлж буй байгууллагыг албан ёсоор тусгай зөвшөөрлийн үндсэн дээр бүртгэж, нэгдсэн системд оруулах
3. Ийнхүү бүртгэхдээ эмнэлгийн байгууллагаас төсөл ирүүлж, холбогдох баримт бичгийг бүрдүүлсэн өргөдлөө эрх бүхий байгууллагад өргөдөл гарган, бүртгэлийн гэрчилгээ авдаг болох
4. Бүртгэхээс татгалзах үндэслэл болон бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болгох, түдгэлзүүлэх үндэслэлийг тусгах
5. Биологийн эцэг, эх болон тээгч эхийн хооронд тусгайлсан хуулиараа гэрээ байгуулахыг зөвшөөрч талууд харилцан хүлээх үүрэг, гарах эрсдэлийг хуваарилан эмнэлгийн байгууллагын хяналтан дор уг гэрээг байгуулах ёстой. Саналд гэрээнд заавал тусгах зүйлсийг тусгасан бөгөөд гэнэтийн давагдашгүй хүчин зүйлээс хамааран үр зулбах, дутуу



- төрөх, аборт хийлгэх болсноор үүдэх эрх зүйн үр дагаврыг талууд гэрээндээ хамтран хариуцахаар гэрээндээ тусгах хэрэгтэй.
6. Тээгч эхээс төрсөн хүүхдийг байгуулсан гэрээний үндсэн дээр Улсын бүртгэлийн байгууллагад биологийн эцэг эхийн хүүхэд хэмээн бүртгэж, гэр бүлийн харилцаа хүүхэд, биологийн эцэг эхийн хооронд бий болгож, тээгч эх, хүүхдийн хооронд анхнаасаа гэр бүлийн харилцаа үүсгэхгүй байх.
 7. Гэрээний үүргийн зөрчилтэй холбоотой маргааныг Иргэний хэргийн шүүх харьяалан шийдвэрлэдэг болох
 8. Гэрээ байгуулах үед эмч нар үр шилжүүлэн суулгахаас гадна тээгч эхэд сэтгэл зүйн зөв ойлголтыг төрүүлэх үйлчилгээг мөн үзүүлдэг байх
 9. Албан ёсоор бүртгэгдээгүй эрүүл мэндийн байгууллага хууль бусаар үр шилжүүлэн суулгасан тохиолдлыг эрүүгийн хуульд гэмт хэрэг болгон зүйлчлэх
 10. Эрүүгийн хуульд хүний цус, эд эрхтэн гэсэн ойлголтод хүний нөхөн үржихүйн эрхтэн болох өндгөвч, өндгөн эс, үрийн шингэнийг багтаан ойлгож Эрүүгийн хуулийн 101, 102-т заасан гэмт хэргийн цар хүрээг өргөтгөх
 11. Мөн тээгч эх болохыг тулган шаардах, хууль бусаар сурталчилах, ашиг олох зорилгоор дээрх үйлдлүүдийг хийсэн тохиолдолд эрүүгийн эрх зүйн хүрээнд шийдвэрлэж байхаар зохицуулах нь зүйтэй гэж үзлээ.



ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ



*С.Цогтсайхан
Магистрант*

Хүн төрөлхтөн үүсч бий болсон тэр цагаасаа саяхныг хүртэл түүврийн аж ахуй эрхлэн, ан агнаж, газар тариалан, гар урлал эрхлэх гэх зэргээр байгальтайгаа зохицон амьдарч ирсэн билээ. Дэлхийн хүн ам сүүлийн хэдхэн зууны турш эрчимтэйгээр өсөхийн хирээр идэх хоол, өмсөх хувцас болон бусад хэрэгцээ ч мөн адил эрс нэмэгдэх болжээ.

Үүнээс үүдэн дэлхийн өнцөг булан бүрт өмнөхөөсөө илүү ихийг үйлдвэрлэх арга замаа тасралтгүй хайсаар байна. Өдгөө био, нано болон мэдээллийн гээд төрөл

бүрийн өндөр түвшний технологиуд гарч, аливаа бараа бүтээгдэхүүнийг гэрлийн хурдаар үйлдвэрлэх болжээ. Нийгмийн хэрэгцээ шаардлагын үүднээс үйлдвэрлэлийн салбар нь харилцан адилгүй тэлж, хүчин чадал, эдийн засгийн өсөлт, нийгэмд үзүүлж буй нөлөөлөл зэргээс үүдэн үйлдвэрлэлийг дотор нь бичил, жижиг, дунд, хүнд ... гэх мэт төрөлжүүлэн авч үзэх болсон.

Жижиг, дунд үйлдвэрлэл нь улс орнуудын ДНБ, үйлчилгээг нэмэгдүүлэх, хүн амын хөдөлмөр эрхлэлтийг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг билээ. Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжил нь өрсөлдөөнийг бий болгон, монополийг задалснаар шинэчлэлийг хөгжүүлэх гол хөшүүрэг болж өгдөг.

Үндэсний үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх, хүн амын хөдөлмөр эрхлэлтийг сайжруулах зорилтын хүрээнд жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийг дэмжих нь улс орны нийгэм, эдийн засгийн бодлогын хувьд төрөөс нэн тэргүүнд тавих зорилтуудын нэг юм. Нийгэм эдийн засгийн хөгжилд жижиг, дунд үйлдвэрийн эзлэх байр суурийг бэхжүүлж, цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, төрөөс



тодорхой дэмжлэг үзүүлэх, тэдний эрх ашигт нийцсэн бизнесийн таатай орчинг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Монголын бизнесийн салбар дах аж ахуй нэгжүүдийн 90-ээс дээш хувь нь жижиг, дунд аж ахуй нэгж гэсэн ангилалд хамаарч байна.

Засгийн газраас 1999, 2005 онд батлан хэрэгжүүлсэн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр гаргаж 2007 онд “Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль”-тай болсноор эрх зүйн таатай орчин бүрдэж, санхүүгийн дэмжлэгийн эх үүсвэр нэмэгдэн өрхийн болон хувиараа бизнес эрхлэгчдийн дунд албан ёсны жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх сонирхол, үүсгэл, санаачилга идэвхжиж байна. Тус хуулийн үндсэн үзэл санаа нь “... төрөөс жижиг, дунд үйлдвэрийн талаар баримтлах бодлого, үндсэн чиглэлийг тогтоож, тэдгээрийг дэмжих талаар авах арга хэмжээ, хамрах хүрээг тодорхойлон үндэсний эдийн засгийн хөгжлийг хангах...”¹-д чиглэгдсэн юм.

Ер нь манай улс нь зах зээлийн эдийн засгийн шилжилтийн үеэс л жижиг, үйлдвэр эрхлэгчийн асуудлыг төрийн зүгээс зохицуулалт хийж, тус салбарын талаар баримтлах бодлого, үндсэн чиглэлийг тогтоож, тэдгээрийг дэмжих талаар авах арга хэмжээ, хамрах хүрээг тодорхойлон хууль, эрх зүйн орчныг бий болгох ажлыг шат дараатайгаар авч хэрэгжүүлж ирсэн билээ.

Сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлт болон гадаадын хөрөнгө оруулалтаас хамааралтайгаар дотоодын үйдвэрлэлийн салбарт нилээдгүй шинэлэг үзэгдэлүүд гарч, аж ахуй нэгжийн хөрөнгө нэмэгдэж, бүтээгдэхүүн үйлдвэрлийн хүчин чадал өсөж буйтай холбоотойгоор жижиг, дунд үйлдвэрийн эрх зүйн зохицуулалтыг улам боловсронгуй болгох шаардлага тулгарч байна.

Иймээс ч хөгжингүй орны жижиг, дунд үйлдвэрийн хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр авч хэрэгжүүлж буй туршлага, зөвлөмжийн ололтой талыг нарийн судлаж, Монгол улсын жижиг, дунд үйлдвэрийн салбарт тохирох хөгжлийн бодлого, эрх зүйн шинэчлэлтийг эхлүүлэх нь чухал юм

“Жижиг, дунд үйлдвэрийн тухай” хууль нь манай улсын эдийн засгийн хөгжил, жижиг, дунд үйлдвэр эрхлэлтийн түвшин зэргээс шууд хамааралтайгаар өнөө цаг үед энэ салбар дахь харилцааг бүрэн зохицуулахад учир дутагдах нь ойлгомжтой. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр Засгийн газрын зүгээс нилээдгүй арга хэмжээ, төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалтуудыг авч хэрэгжүүлж буй ч бодит нөхцөл дээр зорилтот бүлэг болох жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд хүрч үйлчлэлээ үзүүлэх нь чамлалтай байгаа нь ажиглалт, судалгааны явцад харагдаж байна. Юуны урд жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн ангилалт болон шалгуур

¹ Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 1.1-р зүйл



үзүүлэлт нь ерөнхий байдлаар Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуульд тусгагдсаныг хэлэх нь зүйтэй биз. Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэж буй аж ахуйн нэгжүүдийн дунд явуулсан судалгаагаар жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн ангилалтыг боловсронгуй болгох, үйл ажиллагааны чиглэлээс хамаарсан зааг ялгааг тодорхой болгох санал нэлээдгүй гардаг. АНУ-д гэхэд л жижиг, дунд үйлдвэрийг үйл ажиллагааны чиглэлээс хамааруулан ангилж, тухайн салбарт тохирох шалгуур үзүүлэлтийг оновчтой байдлаар бий болгон хөгжүүлж байна. Эндээс үзсэнч манай жижиг, дунд үйлдвэрлэл эрхэлгчдийн гаргаж буй санал үндэслэлтэй нь харагдаж байна.

Мөн өнөөгийн хэрэгжиж буй хуулиар жижиг, дунд үйлдвэрийн салбарт худалдаа, үйлчилгээнийхнийг хамруулж буй нь үндсэн агууллагаараа жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх бодлого оновчтой бусыг харуулах нэг шалгуур. Иймээс жижиг, дунд үйлдвэрийн салбараас худалдаа, үйлчилгээний салбарыг тусгаарлаж үйлдвэрлэл эрхлэгчийн нөхцөл байдал тулгуурласан жижиг, дунд үйлдвэрийн бодлого, эрх зүйн орчинг шинэчлэх нь зүйтэй хэмээн үзэж байна.

Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн ангилалтыг боловсронгуй болгох үндсэн шаардлага нь төрөөс авч хэрэгжүүлж буй бодлого, эрх зүйн зохицуулалт цаашилаад

тус салбарыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд хүртээмжтэй байдлаар хүргэх л асуудал юм. Манай улсын засгийн газрын зүгээс жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэхэд авч хэрэгжүүлж буй арга хэрэгсэл нь бусад орны авч хэрэгжүүлж буй арга хэрэгсэлтэй нэгэн адил:

Импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх бараа бүтээгдэхүүнийг бий болгох, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх үүднээс жижиг, дунд үйлдвэрийг гаалийн болон татварын хөнгөлөлт чөлөөлөлтөөр дэмжих

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг шат дараатайгаар авч хэрэгжүүлэх гэсэн үндсэн 2 чиглэлээр л дэмждэг явдал юм.

Гэтэл жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэхэд авч хэрэгжүүлж буй дээрх үндсэн 2 чиглэлийн арга хэмжээнд бусад салбарыг хамааруулах хандлага нилээдгүй байгаа тул жижиг, дунд үйлдвэрийн асуудлыг бие даасан байдлаар зохицуулалт хийсэн эрх зүйн орчинг бүрдүүлэх нь зүйтэй юм.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх үндсэн зорилго нь үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжихэд чиглэсэн байдаг. Энэ ч утгаараа Засгийн газраас авч хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалт үндэсний үйлдвэрлэл эрхлэгчид буй Монгол улсын нутаг дэвсгэрт байнга байрлан үйл ажиллагаа эрхэлдэг дотоодын аж ахуйн нэгж, хувиараа аж ахуй эрхэлж буй Монгол улсын



иргэнд хүртээмжтэй байх хэрэгтэй. Судалгааны явцад гадны хөрөнгө оруулалтай компани жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэх сангаас олгож буй зээл тусламжид нилээдгүй хамрагдсан байна.

Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судалсны үндсэн дээр уг эрх зүйн зохицуулалтад тодорхой нэмэлт, өөрчлөлт оруулж боловсронгуй болгох, Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн заалтуудыг нэг мөр ойлгон хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх чиглэлээр тус салбарт тулгамдаж буй асуудлуудыг цаашид ч тусгайлан судлах шаардлагатай.

Юуны урьд тус салбарт дараах өөрчлөлтүүдийг хийх шаардлага судалгааны явцад ажиглагдав. Үүнд:

Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 5 дүгээр зүйлд заасан Үйлдэрлэл эрхлэгч, Худалдаа эрхлэгч, Үйлчилгээ эрхлэгч гэсэн ойлголтуудаас худалдаа эрхлэгч, үйлчилгээ эрхлэгч гэсэн ойлголтуудыг хасч зөвхөн үйлдвэрлэл эрхлэгч гэсэн ойлголтыг үлдээх. Мөн үйлдвэрлэл эрхлэгчийг өрхийн бичил, жижиг, дунд гэж ангилах. Үйл ажиллагааны чиглэлээр нь үйлдвэрлэл эрхлэгчдэд шалгуур тавих.

Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид хамаарахгүй үйл ажиллагааны 8.1.4 заасан “Ашигт малтмал эрэх, хайх, ашиглах” гэсэн хэсэгт “Ашигт малтмал эрэх, хайх, ашиглах, боловсруулах” гэж өөрчлөлтийг оруулах.

Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуульд оюуны бүтээлийг гаргаж буй иргэн, хуулийн этгээдийг жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч гэж авч үзэх эрх зүйн орчинг бүрдүүлэх.

Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн ангилалтанд тавьгдах шалгуурыг боловсронгуй болгож зөвхөн ажиллагчдын тоо болон жилийн борлуулалтын орлогоос хамааралгүйгээр Үйлдвэрийн техникийн хүчин чадал, Зах зээлийн өрсөлдөх чадварын хэмжээ (монопол), Тухайн чиглэлээр зах зээлд эзлэх хувийг шалгуурт оруулж уян хатан ангилалтыг тодорхойлох эрх зүйн боломжийг бий болгох.

Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуульд заасан “контракт, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын тоо нь 19-өөс дээшгүй бөгөөд үйлдвэрлэл эрхэлдэг, 50-250 сая төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлого бүхий жижиг үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгж, иргэн”² жижиг үйлдвэр эрхлэгч гэдгийг бичил үйлдвэр эрхлэгч гэж өөрчлөн жижиг, үйлдвэр эрхлэгчээс ялгаж тодорхойлж өгөх.

Санхүүгийн дэмжлэгт хамрагдах жижиг, дунд үйлдвэрлэгчийн санхүүгийн болон эзэмшигчийн тухай тодорхой зааж өгөх. Санхүүжилтийг ямар нөхцөл шаардлагын дагуу олгох талаар тусгаж өгөх зэргээр “Жижиг, дунд үйлдвэрийн тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулах нь зүйтэй хэмээн үзэж байна.

² Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 5.1.5-р зүйл



МАРКСЫН СҮНСИЙГ ХӨӨХ НЬ: АЛБАН БУС ӨМЧИЙН ЭРХИЙГ ЭДИЙН ЗАСГИЙН ЭРГЭЛТЭНД ОРУУЛАХ БОЛОМЖИЙГ АВЧ ҮЗЭХ НЬ



Ц.Онон
Магистрант

Түүхийн хүрд өөрчлөгдсөн ч хувийн өмч бол капиталистууд ажилчин ангийн хөдөлмөрийг мөлжиж, тэднийг боолчлолд гинжилж, дарангуйлах аргаас өөр юу ч биш гэж үзсэн¹ 1848 оны “Коммунист тунхаг”-таа Карл Маркс хувийн өмчийг бүрмөсөн устгахыг уриалсан тэр хуучин үзэл манай нийгэмд хоргодсон хэвээр байна. Нийгэмд баян ядуугийн ялгаа асар их болсон тул тэр бухимдал хуримтлагдсаар эцэстээ тэсэрнэ. Хуримтлагдсан хорсол бүхэн лонхноосоо задарлаа л гэсэн үг.

¹ Экономикас, 2013 он

Нийт хүн амтай харьцуулахад тун багахан баян хэсэг асар их өмчтэй харагдана. Үлдэх хэсэг нь өмчтэй боловч активаа капитал болгох боломжгүй хуулийн гадна үлдсэн болох нь судалгаанаас харагдлаа. Гэтэл хүн амынхаа 80 хувийг хасч хаячихаар хууль эрх зүйн систем яаж хууль ёсны болох вэ? Шийдэл нь юу вэ гэдэг нь миний судалгааны асуулт юм.

Бид юуг буруу хийчихээ вэ?

Манай улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн боловч өөдрөг тэмүүлэл маань өнөөдөр урам хугаралтанд хүрээд байгаа нь нууц биш. Бид юуг буруу хийчихээ вэ? Эргээд харвал манай нийгмийн тогтолцооны цөм ойлголт доголдолтой ажээ. Энэ бол өмчлөх эрх. Бидэнд ихээхэн хөрөнгө байгаа боловч хөрөнгийн төлөөлөл байхгүй, хөрөнгийн биржид нэвтэрч жинхэнэ утгаар чадаагүй, өмчлөх эрхийг нь албан ёсчлоогүй учраас эдийн засгийн засгийн эргэлтэнд орох бололцоогүй байна. Өмчийн эрхийг зөвхөн эрх зүйн асуудал гэж эдийн засагчид үзсэн, эрх зүйчид нь эдийн засгийн ач холбогдлыг төдийлөн ойлгоогүйгээс манай зах зээлийн эдийн засгийн харилцаанд тулгуурласан шинэ нийгмийн харилцаа доголдсон. Өөрөөр хэлбэл, капиталгүй капитализм



байгуулах гэж зүтгэсэнтэй адил болжээ.

Манай иргэдэд капитализмын үр ашгийг хүртэхэд гол саад нь тэдний капитал бүтээх чадваргүй байдал. Өрнөдийн жам ёсны эрхүүдээс бид амьд явах эрх, эрх чөлөөг чамгүй хэрэгжүүлж буй атлаа өмчлөх эрхийг орхигдуулжээ. Бид өрнөдийн хуулиас нэлээдгүй хуулбарласан, өнөөдөр ч үргэлжлүүлэн "хуулсаар" байгаа боловч тэр нь олигтой хэрэгжиж чадахгүй, биеллээ олохгүй байгаа нь нүднээ ил байна. Иймээс ч иргэд маань өөрийн хөрөнгийг капитал болгон хувиргахад хуулийн үйлчлэлд тулгуурлах боломжгүй байна. Эрх зүйн үйлчлэл өмчлөх эрхийг хамгаалахад төдийлөн хүрч чадаагүйн улмаас эрх зүй, эдийн засаг хоорондоо зөрчилдөж, манай албан эдийн засгийн гуравны нэгтэй тэнцэх далд эдийн засаг үүсэх нэгэн хүчин зүйл болоод байна.

Албан бус өмчийн эрхийн сөрөг нөлөө

Сүүдрийн эдийн засгийг далд эдийн засаг, албан бус эдийн засаг, нуугдмал, параллель, хар, саарал ба хууль бус эдийн засаг гэх зэргээр олон янзаар нэрлэдэг бөгөөд нэгдсэн тодорхойлолт байдаггүй боловч бүртгэлгүй эдийн засаг үлэмж хэмжээтэй байгаа нь бүхний нүднээ ил байна. 2012 оны байдлаар ДНБ-ий 35 орчим хувьтай тэнцүү байна гэж Монгол банкны эдийн засагч Д.Энхзаяа тооцоолсон². Тэрээр бэлэн мөнгөний эрэлтийн

аргачлалыг ашиглан 2000-2012 оны хоорондох сүүдрийн эдийн засгийн хэмжээг ойролцоогоор тооцоолжээ. Бэлэн мөнгөний эрэлтийн аргачлал нь татварын дарамт сүүдрийн эдийн засаг үүсэх гол шалтгаан болох бөгөөд эдийн засгийн далд хэлбэрийн үйл ажиллагаанууд ихэвчлэн бэлэн мөнгөөр хийгддэг гэсэн таамаглал дээр үндэслэдэг. Авилга, хээл хахууль, офшор данс гээд хэрэг дээрээ албан бус буюу дотоодын нийт бүтээгдэхүүний статистик мэдээнд орохгүй байгаа нуугдмал их нөөцийг илрүүлэхэд эдийн засаг, эрх зүйн цогц шинж бүхий нэгдсэн механизм маш чухал юм. Сүүдрийн эдийн засгийн цаад шалтгаан нь хууль, татварын дарамтаас зугтаахаас гадна өмчийн эрхийг албан ёсчлоогүй явдал гэж судлаачийн хувьд үзэж байна. Албан бус эдийн засгийн үндсэн шалтгаан нь зөв институци бүрдээгүй байгаа явдал юм.³

Албан бус өмчийн эрхийг эдийн засгийн эргэлтэнд оруулах боломжийг авч үзэх нь

Албан бус өмчийг том бэрхшээл гэж гэж харахаас том боломжинд тооцвол шийдэлд хүрэх эрмэлзэл нэмэгдэнэ. Манай эдийн засагт нуугдмал асар их нөөц потенциал бий хэмээн судлаачид үздэг. Үүнийг эрх зүйн тусламжтай нээж, үйлчлэл, үзүүлэх хүчин чадлыг тал бүрээс нь дэмжих нь чухал. Эрх зүйн зохицуулалт боловсронгуй бусаас хуулийн гадна үлдсэн бүртгэлгүй

² Д.Энхзаяа. Сүүдрийн эдийн засаг. 2012 он

³ <http://www.economics.harvard.edu/faculty/barro>



өмч асар их байна. Өмчийн эрхийн хамгийн гол үүрэг бол капиталд амь оруулж эдийн засгийн эргэлтэнд оруулах чадвар боловч энэ нь байхгүйгээс Монгол улсад сүүдрийн эдийн засаг давамгайл шинжтэй, үхмэл капиталтай, ингэснээр эдийн засгийн нөөц чадавхиа бүрэн дайчилж чадахгүйд хүрээд байна. Төрийн үзүүлдэг ганц үйлчилгээ нь өмчлөх эрх чөлөөг хүчээр хязгаарлахад оршиж байна гэж эрдэмтэд, хувийн хэвшлийнхэн шүүмжилж байна.

Хямралын сургамж

2012-2016 оны эдийн засгийн хямралын шалтгаан нь манай төр хөрөнгө оруулагчдын өмчийн эрхэнд халдсан явдал юм. Нэгдүгээрт, бид иргэдийнхээ төдийгүй гадаадын хөрөнгө оруулагчдын өмчлөх эрхийг хүлээн зөвшөөрөхгүй байна. Төр зүгээр л нэг өдөр лиценз, өмчийн эрхийг нь хураагаад авчихаж байна. Бид 2012 он хүртэл ашигт малтмалын лицензээр Канад, Австрали, Хонгконгийн хөрөнгийн биржээс асар их хөрөнгө босгосон. Энэ аргын оньсыг ойлгосон хүмүүс асар их баяжсан. Эдийн засгийн тэсрэлтийн үндэс нь лиценз эзэмшдэг компанид хувь нийлүүлэх замаар өмчийн эрхийг авч, компаниа офшор бүсэд бүртгүүлж олон улсын зиндаанд гаргаснаар хөрөнгийн биржээс хөрөнгө оруулагчдыг татаж санхүүжилт босгох боломжтой, хууль хөрөнгө оруулагчид ээлтэй байсан явдал юм. Лиценз эзэмшдэг монгол компаниудад хувь нийлүүлж

хөрөнгө оруулан өмчийн эрхтэй болж, компаниа хөрөнгийн бирж рүү гаргасан нь өмчийн эрхийн төлөөллийн хэрэгслүүдийн ач юм. Хөрөнгө оруулагчдын эрсдэл хүлээж хөрөнгө оруулах гол үндэслэл болсон лицензийг төр 2012 онд хураасан. Одоо нэгэнт арван тэрбумын эдийн засагтай болсон тул энэ орон байгалийн түүхий эдийн экспорт, гадаадын хөрөнгө оруулалт хоёрт тулгуурлах болсон эдийн засгийн хөгжил 17% өсөлтөөс хасах руу унасан. 2017 онд ОУВС Монголыг "дампуурлаа зарла" гэж шахтал эдийн засаг унасан. Хоёрдугаарт, хууль хяналтынхан манай бизнес эрхлэгчдийг шалгаж, сүрдүүлж, өмчийн эрхэнд нь халдсан. Хувийн хэвшил хүчирхэг байх үед эдийн засаг цэцэглэж байсныг бид харсан. Хүмүүс ажилтай байсан, бид бүгдийн аз жаргалын түвшин ч өндөр байсан. Гэхдээ бодлогын маш буруу шийдвэр Монголд гарсны улмаас энэ бүхэн хоромхон хугацаанд үгүй болсон.⁴

Санал

Өмчийн эрх, газрын хуулийн кодификаци хийж, хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн актуудыг агуулгын хувьд боловсруулах үндсэн дээр эмхэтгэн нэгтгэсэн шинэ актыг бүтээн төрөлжүүлэх саналтай байна.

Энэ судалгаагаар албан бус өмч болох байшин газрыг шууд хэрэглээнээс өмчийн эрхийн албан

⁴ -Монгол дахь Америкийн Худалдааны гэнхимын Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн дарга Жэй Лиотта



ёсны бүртгэлд хамруулах замаар санхүүгийн хэрэгсэл болгох санал дэвшүүлж байна. Засгийн газар өмчлөх эрхийг хүлээн зөвшөөрөх нь хуулийн гадна оршин суугчдыг эдийн засгийн амьдралд татан оруулахад дэмжлэг болно. Иргэд өмчтэй болсноор орлоготой болж, нийгэм тогтворжино. Нийгэм тэгш байхын хэрээр эдийн засаг хурдан өсдөг.⁵ Эдийн засаг тэлнэ. Өсөх тусам өрсөлдөөн нэмэгдэнэ. Татвар нэмэгдэнэ. Өмчтэй хүмүүс хариуцлагатай болно.

Хүний араас хөөцөлдөж саналын тоо цуглуулж санал гуйж авдаг улстөрчдийн хувьд ч оноо нэмэх боломж юм. Одоо нэг хүнд ногдох ДНБ 7,642.9 мянган төгрөг бөгөөд энэ үзүүлэлт эрс нэмэгдэх болно.⁶

Товчхондоо бол, Марксын сүнсийг хөөж, өмчлөх эрхийг албан ёсчилж бүртгэж өгч, коммунизм капитализмын дунд гацсан манай эдийн засгийн институци болох өмчийн эрхийг санхүүгийн хэрэгсэл болгох боломжийг иргэддээ олгоё.

⁵ Экономикс. 2013 он.

⁶ <http://www.1212.mn/statHtml/statHtml.do>



АШИГТ МАЛТМАЛЫН ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ



Ч.Даваасүрэн
Магистрант

Монгол улсад уул уурхайн салбар нь эдийн засгийн эрчимтэй хөгжлийн нэг тулгуур болоод байгаа өнөө үед “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг Үндсэн хуулийн зургаадугаар зүйлийн хоёрдох зүйлд төрийн /нийтийн/ өмчийг хуулийн этгээдэд тусгай зөвшөөрлийн хүрээнд ашиглуулах, эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг нь нэмэгдүүлэх чингэхийн тулд тус салбарыг зохицуулж байгаа хууль эрх зүйн орчныг оновчтой болгох, хуулийн хэрэгжилтийг хангах хэрэгцээ шаардлага тулгамдаад байна.

Тус салбарын Монгол улсын эдийн засагт өгч буй үр өгөөжөөс илүүтэйгээр уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжийн буруутай үйлдэл, байгаль орчинд учир буй хор нөлөө зэргээс хамаарч ашигт малтмалын тухай хуульд заасан хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгохыг 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хоргилсон. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгохыг хориглох тухай 1 зүйл Тус хориг 2014 оны 01 сарын 01-нд цуцлагдсанаас хойш 2016 оны 08 дугаар сарын байдлаар АМХЭГ-аас 800 орчим хайгуулын тусгай зөвшөөрлийг олгосон ажээ.

2016 оны 08 сарын байдлаар ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой асуудал тойрсон 34 маргаан захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэгдэж, 50 аж ахуй нэгжийн маргаан шүүхийн шатанд байгаа нь уг харилцааны зохицуулж буй эрх зүйн хэм хэмжээ ч нэгэн адил боловсронгуй болгох шаардлагатай байгааг харуулж байна.

Монгол улсын Ашигт малтмалын тухай 1997 оны шинчлэгдсэн 2006, 2014 онд нэмэлт өөрчлөлтүүд оруулснаар одоо 11 бүлэг, 66 зүйлтэйгээр Монгол улсын нутаг дэвсгэрт ашигт малтмал эрэх, хайх,



ашиглах харилцааг зохицуулж байна. Хэдийгээр тус хууль нь харьцангуй цөөхөн удаа нэмэлт өөрчлөлт орж байгаа ч орчин үеийн уул уурхайн салбарын хөгжил, нийгмийн хэрэгцээ шаардлага, тулгамдаж буй асуудлуудаас үүдэн эрдэс баялгийн салбарын эрх зүйн орчны шинэчлэлийн асуудал эрчимтэй судлагдаж, шинэчилсэн хуулийн төслүүд боловсруулагдаж байна.

Сүүлийн 10 гаруй жилд бий болгож, бага ч гэсэн үр дүнд хүргэсэн журам зааврууд маань шинэ нөхцөл байдлын өмнө дахин хүчин мөхөстөж, бид өөр цар хүрээ бүхий, өөр зохицуулалт шаардах уул урхайн цаг үеийн өмнө зогсож байна. Уул уурхайн асуудлыг өөрчлөгдөж буй үйл ажиллагаа, түүнээс үүсэх нөлөөллийн өргөн хүрээнд авч үзэн эрх зүйн иж бүрэн зохицуулалт хийх цаг үе ирээд байна.

Монгол улсад ашигт малтмалын үйл ажиллагаа явуулах эрх зүйн зохицуулалт нь тухайн салбарын түүхэн хөгжил болон олон улсын хууль эрх зүйн чиг хандлагын хүрээнд хувьсан өөрчлөгдөж, шинэлэг эрх зүйн зохицуулалтууд бий болсоор байна. Тус салбарын эрх зүйн түүхэн хөгжлийн явцад ашигт малтмалын өмчлөл, ашигт малтмалын тухай ойлголт, тусгай зөвшөөрөл, түүнийг эзэмших эрх бүхий этгээд болон түүнд тавигдах шаардлага, тусгай зөвшөөрөл олгох процесс зэрэг харилцан уялдаа

бүхий зохицуулалтуудыг тухайн үеийн нийгмийн тогтолцоотой уялдуулан шинэчлэн боловсруулж хуульчилж ирсэн түүхтэй.

Монгол улс 1990 оноос чөлөөт эдийн засгийн нийгэмд шилжин орсоноор ашигт малтмалын салбар нь манай улсын эдийн засгийн гол салбар болж эхэлсэн. Энэ ч утгаар тус салбарт олон улсын томоохон компаниуд орж ирж үйл ажиллагаа явуулж ихэлсэнээр тус салбарын эрх зүйн орчинг шинэчлэх олон улсын туршлагыг судлан нэвтрүүлэх шаардлага тулгарч эхэлсэн.

Шинэчлэн боловсруулж буй ашигт малтмалын эрх зүйн орчинд олон улсад хэрэгжүүлж буй туршлага, харилцан уялдаатай зохицуулалт хийж буй арга хэлбэрийг нэвтрүүлэх тал дээр анхаарч ажилласанаар 1994 онд шинээр батлан гаргасан Ашигт Малтмалын тухай хуульд “Төрийн эрх бүхий байгууллагаас ашигт малтмалын хайгуул хийх болон ашигт малтмалын орд ашиглах эрх олгосон гэрчилгээг тусгай зөвшөөрөл гэнэ” тусгай зөвшөөрлийн асуудлыг анх тусган оруулсан.

Энэ үеээс эхлэн ашигт малтмалын салбарт үйл ажиллагаа явуулах эрхийг аж ахуйн нэгжүүд тусгай зөвшөөрлийн хүрээнд олж авч эхлсэн. Мөн тусгай зөвшөөрөл шинээр олгохдоо төрийн зүгээс ижил төстэй үйл ажиллагаа явуулж буй компаниуд дунд уралдаан шалгаруулалт явуулах замаар тусгай зөвшөөрөл олгох болсон. Төрөөс олгож буй ашигт малтмалын тусгай



зөвшөөрөл нь:

- “Хайгуулын тусгай зөвшөөрөл” гэж 2006 оны АМТХуулийн дагуу ашигт малтмал эрэх, хайх эрх олгосон баримт бичиг.
- “Ашиглалтын тусгай зөвшөөрөл” гэж 2006 оны АМТХуулийн дагуу ашигт малтмал ашиглах эрх олгосон баримт бичиг хэлбэртэй байна.

АНУ, Канад, Австрали зэрэг уул уурхайн чиглэлээр дэлхийд тэргүүлэгч улсуудын эрх зүйн орчинг судалж үзэхэд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох процесс нь нарийн зохицуулалгдсан төдийгүй тусгай зөвшөөрлийг эзэмшиж буй хуулийн этгээдэд тавьгдах шаардлага нь өндөр байхаар заасан байна. Тусгай зөвшөөрөл олгохдоо тус улсууд нь концессын гэрээний хүрээнд хүртэл хамтран ажиллах байдлаар зохицуулалтыг хийсэн нь төрийн зүгээс эрх мэдлийг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой зохицуулалт болсон байна.

Сүүлийн жилүүдэд манай улсад ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой хэрэг маргаанууд захиргааны хэргийн шүүхээр нилээдгүй шийдэгдэж буйг судалгааны ажлын явцад ажиглагдсан. Хэрэг маргааны гол асуудал нь тусгай зөвшөөрөл олгох процесс ажиллагаатай илүү холбоотой болох нь судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжийн удирдлагууд илэрхийлсэн байна. Үүнд:

- Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгохдоо тухайн талбайн давхцал болон тусгай хамгаалалт, орон нутгийн тусгай хэрэгцээний тусгай хамгаалалдын газарт олгож буй дээр хяналт хангалтгүй
- Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл давхардах, тухайн өргөдөлийн хяналт хангалтгүй хийгдэг.
- Ашигт малтмалын газраас аймаг, нийслэлийн Засаг даргаас санал авах үйл ажиллагаа хуульд заасан хугацаанд явагдаггүй
- Аймаг, нийслэлийн Засаг дарга ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоос татгалзах хуульд заасан үндэслэлээ тодорхой дурьдаггүй, дурьдсан үндэслэл нь субъектив шинжтэй.
- Аймаг нийслэлийн Засаг даргаас санал ирүүлээгүй тохиолдолд хайгуулийн тусгай зөвшөөрөл олгосон байдал нь тухайн нутаг дэвсгэрийн тусгай хэрэгцээний газартай давхардаг асуудал нэлээд гарч байна.
- Засгийн газраас батлан гаргасан ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл зарлах үйл ажиллагааг цахим системээр явуулахад солбицол зөрөх, дугаар буруу огох асуудал цөөнгүй тохиолддог.

Дээрх асуудлууд нь ашигт



малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд гарч буй гол анхаарал татахуйц ээдрээтэй хийдэлүүд бөгөөд тус асуудлуудыг шийдвэрлэх эрх зүйн орчинг оновчтой болгох нь дүгнэлтэд хүрэв.

Тусгай зөвшөөрлийг олгохдоо зөвшөөрөл хүсэгчдэд уул уурхайн үйл ажиллагаа явуулах санхүү эдийн засгийн болон техник технологийн шалгуур тавих нь зүйтэй. Үүнд компанийн эдийн засгийн чадах, хүний нөөц, тухайн талбай хийгдэх ажлын төслийг тусгах.

Хайгуулын тусгай зөвшөөрлөөр олгох гэж буй талбай, ордоо тодорхой хугацааны өмнө урьдчилан зарлаж, нутгийн өөрөө удирдах байгууллагаар албан ёсоор батлагдсан газрын зурагт тэмдэглэж, сонгон шалгаруулалтаар олгодог болох.

Тусгай зөвшөөрөл олгохдоо эзэмшигч этгээдийн санхүүгийн чадвар зэрэг үзүүлэлтээр нь тусгай зөвшөөрлийн тоо, эзэмших хугацаагаар нь хязгаар тогтоох шаардлагатай байна

Ашигт малтмалын тухай хуулийн 19.4-т дурдсан “Аймаг, нийслэлийн засаг дарга энэ хуулийн 19.3-т заасан мэдэгдлийг хүлээн авмагц тухайн талбайн байрших сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын Тэргүүлэгчдийн саналыг авч 30

хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад хариу өгөх бөгөөд энэ хугацаанд хариу өгөөгүй бол тухайн саналыг зөвшөөрсөн гэж үзэн” гэсний “30 хоногийг” “60 хоног дотор” гэж:

Төрийн захиргааны байгууллага нь Ашигт малтмалын тухай хуулийн 19.3-т дурдсаны дагуу аймаг, нийслэлийн Засаг даргад бичгээр мэдэгдэхийн зэрэгцээ тусгай зөвшөөрөл олгогдох гэж буй талаар мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ” гэж 19.3.1 дэх заалт болгон нэмэх

Сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал нь тухайн талбай байрших баг, хорооны Иргэдийн нийтийн хурлын шийдвэрийг үндэслэн аймгийн Засаг дагад санал өгөх” гэж одоо аймаг нийслэл болон сумын ИТ-ын хуралын тэргүүлэгчдийн саналыг үндэслэж байгааг 19.4.1 зэх заалт болгон нэмэх.



ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ АЖИЛЛАГААН ДАХЬ ГЭРЧ ХАМГААЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ ОНОВЧЛОХ АРГА ЗАМ



Э.Солонго
Магистрант

Дэлхий нийт улам бүр даяарчлагдахын хэрээр элдэв сөрөг үзэгдлүүд хаяа хязгаараа тэлж үндэстэн дамнасан гэмт хэргүүд олширч, хүн амын дунд урьд гарч байгаагүй харгис хэрцгий үйлдлүүд ердийн үзэгдэл мэтээр өгүүлэгдэн гарах болсоор байна.

Манай орон Үндсэн хуулиндаа: "Монгол Улсад эрх зүйт төрийг төлөвшүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх хууль зүйн баталгааг бий болгох" тухай тунхаглан тусгасан билээ. Энэхүү

зорилгыг хэрэгжүүлэхийн тулд 1998 оноос "Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр"-ийг бэлтгэн гаргаж олон арван хуулиудыг шинээр батлан мөрдөж эхэлсний нэг нь Монгол улсын Эрүүгийн байцаан шийтгэх \ЭБШ\ 2002 оны хууль бөгөөд энэ хууль нь ЭБШ эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах тухай олон улсын нийтээр зөвшөөрөгдсөн хэм хэмжээг тусгах талаар томоохон алхам хийсэн юм. Тухайлбал: гэрчийн эрхийн асуудлыг онцлон тусгаж процессын баталгааг харьцангуй өндөр түвшинд хангаж чадсанд тооцогддог. Гэсэн хэдий ч өнөөдөр гэмт хэргийн гэрчийг үнэн зөв мэдүүлэг өгснийх нь төлөө айлган сүрдүүлэх, дарамтлах, заналхийлэх, тэдэнд санхүүгийн болон бусад байдлаар нөлөөлөх оролдлого гарсаар байна. Гэмт хэрэгтэн, түүний хань хамсаатнаас айснаасаа эсхүл бусад нөлөөнд автсанаас гэрчүүд мэдүүлгээсээ буцах, мэдүүлэг өгөхөөс татгалзах, худал мэдүүлэг өгсний төлөө гэмт хэрэгтэн болон хувирч байгаа нь өнөөгийн бодит үнэн. Энэ талаар Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх шинэчлэн найруулсан хууль (2017 оны 05 дугаар сарын 17-нд батлагдсан) гаран гартал шүүн өргөн хүрээнд хэлэлцэгдсэн билээ.



Хууль зүйн үндэсний хүрээлэн дангаар болон төрийн бус байгууллагуудтай хамтран хийсэн зарим судалгаагаар гэрч, хохирогчийг элдэв хэлбэрээр дарамталж хэргийн бодит үнэнийг тогтооход илэрхий саад учруулах явдал "хүнд, ноцтой" болон авилга, албан тушаалын нэлээд хэргүүдийг шалган шийдвэрлэх үед цөөнгүй гарах болсныг баримт дүгнэлттэйгээр харуулсан байдаг.

Өчигдөрхөн гэрч гэгдэж байсан этгээд өгсөн мэдүүлгээсээ болж нэг л мэдэхэд сэжигтэн, яллагдагч болон хувирах "сонин үзэгдэл" чухамдаа манай Эрүүгийн хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд цөөнгүй гардаг нь эрх зүйн зохицуулалтын боловсронгуй бусын нэг илрэл хэмээхээс өөр аргагүй. Ийм үед олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг эрх зүйн хөгжлийн чиг баримжаа болгон үр нөлөөтэй баталгаат тогтолцоонд бүрнээ нийцсэн эрх зүйн үндсийг бүрдүүлэх, түүний хэрэгжилт нь бодитой байх нөхцөл боломжийг бий болгох зайлшгүй шаардлага өнөө үед тулгарч байна. Гэмт явдлыг илрүүлэхэд туслалцаа дэмжлэг үзүүлж байгаа этгээдүүдэд зөвхөн ЭБШ ажиллагааны оролцогчийн хувьд төдийгүй иргэнийх нь хувьд Үндсэн хуульд заасан эрх, хууль ёсны ашиг сонирхол, аюулгүй байдлыг хангах нь эрх зүйн механизмыг бүрдүүлэх тулгамдсан асуудлын нэг яах аргагүй мөн.

Гэрчийг болон түүний ойр дотны

хүмүүсийг найдвартай хамгаалах хүртээмжтэй арга хэмжээ авах нь тэднээс үүргээ зохих ёсоор биелүүлэх, цаашлаад байцаан шийтгэх ажиллагааны зорилтыг хангах, мөрдөн шалгах процессын үр нөлөөг дээшлүүлэх, эрүүгийн хэргийг шийдвэрлэх тулгуур үндэслэлийг лавтай бүрдүүлэх, найдвартай арга зам болох учиртай. Зохион байгуулалтай гэмт хэрэг, хүнд болон онц хүнд гэмт хэргийг хянан шийдвэрлэх явцад гэрч, хохирогчид төдийгүй шүүгч, мөрдөн байцаагч, шинжээчид шахалт үзүүлэх явдал жилээс жилд ноцтой шинжтэй болж буй нь нууц биш. Шүүхийн шийдвэр гарсны дараа ч янз бүрийн хэлбэрээр заналхийлж гэрчийг айлган сүрдүүлэх явдал тасрахгүй байна.

Зохион байгуулалттай гэмт хэрэг үйлдсэн этгээд, тэдгээрийн хамсаатнуудын эсрэг мэдүүлэг өгснөөр гэрч, түүний гэр бүл, ойр дотны хүмүүст аюултай нөхцөл байдал үүсч болдгийг гадаад, дотоодын олон арван жишээ баримт бэлхнээ харуулж байна.

Онц аюултай гэмт хэрэг, ялангуяа терроризм, алан хядах, хомороглон устгах шинжтэй болон бусад зохион байгуулалттай гэмт хэргийг илрүүлэхэд чухал ач холбогдол бүхий мэдүүлэг өгөхөд гэрчийн ар гэр, үр хүүхэд, садан төрөл, ойр дотны хүмүүсийн эрүүл мэнд, халдашгүй байдалд заналхийлэл, эд хөрөнгөнд нь аюул учруулж болохуйц байгаа бол түүнийг зохих



ёсоор олон чухал зохицуулалтууд хамгаалалтад авах тухай 2017 онд шинэчлэн батлагдсан Эрүүгийн болон Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх хуульд тусгагдсаныг онцлох нь зүйтэй биз.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай 2013 оны хуулиар уг ажлыг тахарын алба хариуцахаар тусгагдсан байсан, одоо энэ үүрэг цагдаагийн байгууллагад шилжсэн. Гэрчийг хамгаалах байгууллага нь гэрчийг учирч болзошгүй аюулаас шат дараатай арга хэмжээ авах, түүний ашиг сонирхлыг хамгаалах үндсэн үүрэгтэй. Тиймээс ч заавалчгүй хамгаалтанд авах хэд хэдэн нөхцөл хуулиар тавигдах ёстой. Энэ нь шалгаж буй хэрэг Эрүүгийн хуульд заасан хүнд, онц хүнд гэмт хэрэг байх.

- Түүнд: Терроризм, хомороглон устгах, алан хядах болон зохион байгуулалттай ноцтой гэмт хэрэг бүхэлдээ хамрагдах нь ойлгомжтой. Түүнчлэн олон нийтийн дэг журмыг алдагдуулж, хүнд хор уршиг, хохирол бүхий бусад ноцтой гэмт хэргийн гэрчийг ч мөн ялгаагүй хамгаалах асуудал тавигдаж таарна,
- Гэрчийн мэдүүлэггүйгээр тухайн гэмт хэргийн бодит байдлыг тогтоох, гэмт этгээдийг илчлэх боломжгүй байгаа нөхцөлд түүний хамгаалалтыг онцлон анхаарах,
- Гэрчийн гаргаж буй гэмт

хэргийн талаарх нууц мэдээ, баримтууд эрүүгийн хэрэг үүсгэх хангалттай үндэслэл болох,

- Уг ажиллагааг эхлүүлэхээс өмнө зорилгодоо хүрч чадах эсэхээ сайтар нягтлан шалгах учиртай. Өөрөөр хэлбэл, гэрчийн мэдүүлэггүйгээр гэмт хэргийн нөхцөл байдлыг мөрдөн шалгах, эсвэл сэжигтэн яллагдагийг илрүүлэх боломжгүйд хүрэх. Гэрчийг хамгаалахад хөрөнгө хүү шаарддаг учир уг ажиллагааг эхлүүлэхээс өмнө боломжтой бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байх. Гэрч хамгаалалтын механизмыг боловсронгуй болгох талаар эрдэмтэн, судлаачид бүтээл, судалгаандаа анхаарал татахуйц цөөнгүй санал гаргасаар байна.

Тухайлбал, доктор (S.D) Н.Лүндэндорж нарын “Монгол улсад шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь” хамтын бүтээлдээ “Эрүүгийн процессын хувьд яллагдагчийн өмгөөлөгч, гэрч нотлох баримт цуглуулах, гаргах эрхгүй байгаагаас мэтгэлцэх нэг тал хэрэг дээрээ байхгүй байна” гэж үзэж болно.

Тийм учраас яллагдагчийн өмгөөлөгч, гэрч нотлох баримт цуглуулах, гаргах эрхийг нээж өгөх замаар эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд мэтгэлцэх зарчим хэрэгжих нөхцөлийг бүрдүүлнэ¹ хэмээн онцолсон байдаг. Хүчин

¹ Шүүхийн хараат бус байдал. Бодлогын судалгааны тойм. УБ. 2010 он 75 дахь тал



төгөлдөр үйлчилж буй ЭБШ хуулийн зохицуулалтаар гэрч нь нотлох баримт бие дааж цуглуулах эрх үүрэг хүлээдэггүй.

Өөрөөр хэлбэл, ямар нэгэн ашиг сонирхол хамгаалж хувийн санаачлагаараа оролцдоггүй, тухайн ажиллагааг эрхлэн явуулагч-төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтан (мөрдөн байцаагч, прокурор, шүүгч)-д гэмт хэргийн талаар үзсэн, харсанаа үнэн зөв гэрчлэн мэдүүлэх үүрэг юуны урьд хүлээдэг. Тиймээс ч гэрчүүд бие даан процесс ажиллагаа явуулж нотлох баримт цуглуулахад хүрвэл тэднийг хамгаалах ажил илүү тодорхой зохицуулалт шаардахад хүрнэ.

Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаа нь хамгаалалуулагчийн амьд явах, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөө түүнчлэн эрүү шүүлт тулгах болон хүнлэг бус, хэрцгий хандах явдлаас ангид байх, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг хязгаарлах ёсгүй. Мэдээллээр хангагдах, мэдээлэл задрахаас хамгаалагдах, өмч болон ажлын байраа хадгалуулах эрхийг тэрбээр эдлэх нь ойлгомжтой. Гэрчийн аюулгүй байдал сэтгэл зүйн хамгаалалтаар хангахдаа:

- урьдчилан сануулах;
- тодорхой үйлдлийг хязгаарлах;
- биечилсэн хамгаалалт хийх;
- мэдээллийн нууцлалыг хангах;

- нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах;

- аюулгүй газарт түр байрлуулах;

- нүүлгэн шилжүүлэх;

- баримт бичгийг солих;

- гадаад төрхийг өөрчлөх зэрэг арга хэмжээнүүдийн аль тохиромжтойг авч хэрэгжүүлж болох юм.

Харьцуулсан эрх зүйн үүднээс гэрч хамгаалах асуудал эрүүгийн эрх зүйн заавалчгүй байх судлагдахуун-объектод зүй ёсоор тооцогдсоор ирсэн нь мэдээж. Эрүүгийн хэргийг нотлох ажиллагаанд гэрчийн үүрэг, хариуцлага ихээхэн ач холбогдолтой хэмээн үздэг.

Эх газрын эрх зүйн бүлийн орнуудын эрүүгийн процесс ажиллагаанд гэрчийн мэдүүлгийг нотлох баримтын эх сурвалжид зүй ёсоор багтаахын зэрэгцээ түүнийг шүүхийн өмнөх шатанд шалган нягтлах нь зүйн хэрэг. Харин Англо-Саксоны тогтолцоот орнуудад процесс ажиллагаа нь мэтгэлцэх зарчимд тулгуурладаг учир гэрч нь яллах, өмгөөлөх аль ч талд хүмүүнлэг, шударга ёсонд тулгуурлан шүүхийн өмнө ёс суртахуунтай байх андгайгаа өргөн тангаргалаж мэдүүлгээ өгдөг нийтлэг журмыг баримталсаар иржээ.

Н.Лүндэндорж нарын эрдэмтдийн онцолсноор гэрч "хөндлөнгийн шинжтэй" боловч



хоёр талын аль нэгэнд “үйлчлэхээс” өөр аргагүйд хүрдэг. Гэхдээ “бодит үнэний буюу бодит” байдлыг тогтоох гол зорилго, үйл ажиллагааны зарчмаа болгосоор ирсэн Монголын ЭБШ ажиллагаанд гэрчийн мэдүүлгийн “хөндлөнгийн” мөн чанар илүү байвал гэмт хэргийг нотлоход давуу үнэмшилтэй гэгдэх нь ойлгомжтой. Хэдийгээр гэрч, хохирогчийг хамгаалах тухай 2013 оны Монгол улсын хуулинд нийтлэг шинж чанар бүхий зайлшгүй хэрэгжүүлэх зохицуултад тусгасан боловч холбогдох бусад хуулиудад, тухайлбал Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд дараах зохицуулалтыг заавал үгүй тусгах ёстой. Үүнд:

- Шүүх хуралдааныг нээлттэй явуулах заалтыг шүүхийн танхимд хохирогчид болон гэрчүүдийг хамгаалах зорилгоор шүүх хуралдааны зарим хэсгийг хаалттай явуулах буюу кодлох, холбогдох баримтыг тусгай техник хэрэгслийн тусламжтайгаар хуралдааны үед гаргаж тавихыг гэрчийн мэдүүлгийг сонсох заалтад нэмж оруулах.

Ялангуяа тийм арга хэмжээг бэлгийн хүчирхийллийн золиос болсон хохирогч, аль эсхүл гэрч нь хүүхэд ноцтой хэргүүдэд тухайн нөхцөл байдал, ялангуяа хохирогч буюу гэрчийн санаа бодлыг харгалзан авч хэрэгжүүлэх.

- Процесс ажиллагааны зардалд “Гэрч, хохирогч, шинжээчийг хамгаалах, тэдэнд туслалцаа үзүүлэх” тухай зохицуулалт нэмж оруулахын хамт тэдний аюулгүй байдлыг хангах, хамгаалахад зарцуулсан зардлыг ч мөн нэгэн адил заавалчгүй тусгах.
- Шүүх хуралдааны тэмдэглэл хэсэгт: Гэрч, хохирогчийн талаарх мэдээлэл өгөхийг хязгаарлах (тухайн этгээдийн тухай анкетын мэдээллийг эрүүгийн хэргийн материалаас авах, эдгээр мэдээллийг үндсэн хэргээс тусгаарлан хадгалах, уг этгээдэд нууц нэр өгөх зэрэг) заалт оруулах.

ЭБШ ажиллагааны оролцогчдыг хамгаалах зайлшгүй шаардлага тулгарсан тохиолдолд холбогдох хууль журмын дагуу ЭБШ ажиллагааг хэрэгжүүлэгч субъект шат шатандаа тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх тэднийг айлган сүрдүүлэх зорилгоор гэрч, хохирогчийн эсрэг хүч хэрэглэж . Эрүүгийн болон Зөрчлийн хуулиар хориглосон үйлдэл хийж болзошгүй этгээдэд албан ёсоор урьдчилан анхааруулах, шаардлагатай арга хэмжээ авч тухай бүр хэрэгжүүлэх журмыг тогтоож өгөх. Тухайлбал:

- Гэрч, хохирогч, түүний гэр бүл, ойр дотны хүмүүсийн эд хөрөнгийн аюулгүй байдлыг хангах,
- Гэрчийн эсрэг хүч хэрэглэх буюу бусад гэмт халдлага үйлдэх,



- зохион байгуулах боломжийг таслан зогсоох зорилгоор сэжигтэн, яллагдагчийн хувьд таслан сэргийлэх арга хэмжээ авч болох үндэслэлүүдэд дээрх чиглэлээр нэмэлт оруулах.
- Аюулгүй байдлын арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаагаас үл хамааран гэрчийн эсрэг Эрүүгийн хуулиар хориглосон үйлдэл хийхээр заналхийлж байгаа тухай хангалттай үндэслэл байвал эрүүгийн журмаар шалгах нь зүйтэй юм.
 - Гэрчийн нэр, хаягийг хэвлэл мэдээллээр болон нээлттэй шүүх хуралдааны үеэр ил гаргахгүй байх тэдэнд зориулж шүүх хуралдааны тоноглогдсон өрөө тасалгаа байгуулах, гэрч, хохирогч асуултанд хариулах үед хоолойных нь өнгийг өөрчлөх аудио- видео техник ашиглах, гэрч нь шүүх хуралдаанд биечлэн оролцохгүйгээр аюулгүй өөр газраас радио, холбоо, видео-камерын тусламжтайгаар мэдүүлэг өгч болохыг тусгайлан зохицуулах,
 - Мэдүүлгийн тэмдэглэлээс шаардлагатай тохиолдолд гэрч болон ЭБШ ажиллагааны бусад оролцогчдын хувийн мэдээллийг авах, мөрдөн байцаалтын оролцогчдод зохих нууц нэр өгөх, хамгаалагдаж байгаа этгээдийн тухай мэдээллийн бүхий л нууцыг чанд хадгалах (Үүнд мөрдөн байцаах албаны дарга биечлэн хяналт тавьж хариуцах),
 - Таньж буй этгээдийн аюулгүй байдлыг хангах ажиллагаа зайлшгүй үед хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч гэрчийг энэхүү ЭБШ тодорхой ажиллагаанд оролцуулахдаа нууц далд тасалгаанаас явуулах талаар хуульчилж өгөх,
 - Шүүх хуралдаан дээр бусад оролцогчдоос гэрчийг нүүртулан харах боломжийг хязгаарлах, мэдүүлгийг байцаагдаж байгаа этгээдийн хувийн мэдээллийг нийтэд зарлахгүйгээр сонсгох,
 - Оршин суух газрыг өөрчлөх, байнга болон түр хугацаагаар өөр газарт нүүлгэх суулгах, холбогдох бичиг баримт, сургууль, цэцэрлэг, ажлын байраар хангах, холбогдох зардлыг төрөөс хариуцах.
 - Хувийн болон орон сууц, эд хөрөнгөнд харуул хамгаалалт тогтоох (үүнд: харуул, дуут дохиолол суурилуулах гэх мэт),
 - Биеэ хамгаалахад зориулсан зэвсэг, хэрэгслээр хангах (нулимс асгаруулах хий, бороохой гэх мэт арга хэмжээ авах),
 - Онцын шаардлагатай, гарцаагүй нөхцөл тулгарсан тохиолдолд гэрчийн гадаад төрх, нүүр царайг өөрчлөх хүртэлх арга хэмжээ авч байх шаардлагатай.



Өнөөгийн боломж нөхцөлд нийцүүлэн цагдаагийн байгууллагын хамгаалалтанд гэрчийг авахдаа, нууцыг чандлан сахих үүрэг бүхий тусгай алба байгуулахад нь зүйтэй юм. Гэрчид материаллаг, эмнэлгийн, сэтгэл зүйн ба нийгмийн халамжийг шаардлагатай төрийн, сайн дурын, оршин суугаа газрын буюу орон нутгийн эх үүсвэрүүдээс гаргуулах цагдаа, прокурор, шүүх

болон хуулийн бусад байгууллагын болон эрүүл мэнд, нийгмийн салбарын ажилтнуудад гэрч хамгаалахад чиглэгдсэн тусгай сургалт явуулах, гэрчид зохих тусламж үйлчилгээ үзүүлэх талаар удирдамж, зааварчилгаа гаргаж мөрдүүлэх арга хэмжээ авах нь өнөөгийн тулгамдсан зорилтын нэгд зүй ёсоор тооцогдоно.



ДЭЛХИЙН ЗАРИМ УЛС ОРНУУДЫН ТАТВАРЫН ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН: ХАРЬЦУУЛСАН СУДЛАЛ



*Э.Эрдэнэтуяа
Магистрант*

Түлхүүр үг: Татварын тогтолцоо, татварын алба, татварын гэмт хэрэг, татвар төлөхөөс зайлсхийх, эрүүгийн хариуцлага

Товч агуулга: Зах зээлийн эдийн засгийн хөгжлийн явцад дэлхийн хөгжиж буй орнууд жил бүр корпорациудын татвараас зугтах, санхүүгийн хууль бус ажиллагааны улмаас төсөвт орох олон арван сая доллараа алдаж байна. Энэ байдал нь татварын гэмт хэргийг улам өсөхөд хүргээд зогсохгүй, тухайн гэмт хэрэгтэй тэмцэх асуудлыг шинэ хандлагаар

авч үзэх шаардлагатайг харуулна. Энэхүү шаардлагыг харгалзан Ази, Номхон далайн орнуудын төлөөлөл болох АНУ, БНСУ, БНХАУ, ОХУ, Япон зэрэг орнуудын татварын гэмт хэрэгт явуулах тэмцлийн эрх зүйн орчны талаар өгүүлэлдээ тусгав.

Удиртгал

Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжлийн хандлага нь түүнийг дэлхийн янз бүрийн улс орнуудын эрүүгийн эрх зүйн хөгжлийн онцлогтой зохицуулах шаардлага тавигддаг. Ялангуяа өнөөгийн зах зээлийн эдийн засгийн нөхцөлд татварын гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлагын асуудалд дэлхийн улс орнуудын эрүүгийн эрх зүйн нийтлэг хандлага, онцлогийг харгалзах явдал чухлаар шаардагдаж байна.

Энэхүү өгүүлэлээрээ Ази, Номхон далайн зарим орнуудын татварын тогтолцоо, татварын гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн үндсэн асуудлыг харьцуулан судлах зорилго тавьлаа. Зорилгодоо хүрэхийн тулд БНХАУ, ОХУ, АНУ, БНСУ, Япон зэрэг орнуудын татварын тогтолцоо, татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн асуудлыг харьцуулан шинжилж, нийтлэг болон онцлог талыг нь илрүүлэх зорилтыг дэвшүүлэн хэрэгжүүлсэн болно.



1.Татварын тогтолцооны талаар:

Ази, Номхон далайн орнуудын төлөөлөл болох АНУ, БНСУ, БНХАУ, ОХУ, Япон Улсууд нь өөрийн орны Үндсэн хуулиндаа "...иргэд хуулиар оногдуулсан албан татвар төлөх үүрэгтэй" гэж нийтлэг байдлаар заасан байдаг ба татварын тогтолцооны хувьд улсын болон орон нутгийн татвараас бүрддэг байна.

Улс орнуудын татварын гэмт хэрэгтэй тэмцэх нэг гол эрх зүйн эх сурвалж нь татварын хууль тогтоожмууд байдаг.

Аливаа улс орны улсын төсвийг бүрдүүлэхэд татварын алба чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд холбогдох хууль тогтоомжоор татварын харилцаагаа зохицуулж байдаг. Тухайлбал: АНУ нь "Дотоодын орлогын албан татварын тухай", "Өршөөлийн тухай"...хуулиараа, Япон нь 1947 оны "Орлогын албан татварын тухай", "Хуулийн этгээдийн албан татварын тухай", 1959 оны "Төрөөс татвар хураах тухай"... хуулиар, БНСУ нь "Орлогын албан татварын тухай"...хууль гэх мэт.

Япон Улсын татварын хууль тогтоомж нь АНУ дахь хууль тогтоомжоос сул хөгжсөн гэдэг дүгнэлтийг АНУ-ын зарим судлаачид хийсэн байдаг. Энэ байдлыг Америкийн судлаач Жонатан Японы хууль тогтоомж нь аалзны тортой адилаар жижигхэн ялааг бариад, харин том зөгий, хэдгэнэ зэрэг

шавжнуудыг тавиад явуулдаг гэж зүйрлэсэн¹.

Аль ч улсын хувьд татварын гэмт хэрэг үйлдэх гол зорилго нь татварын хэмжээг багасгах буюу татвараа бүрэн төлөхгүй байх, татвараас нуусан хөрөнгөө хувьдаа ашиглах буюу бусад өмч болгож хувиргах явдал байдаг. Тиймээс татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэгтэй тэмцэн, татвар төлөлтийг нэмэгдүүлэхийн тулд Японд цэнхэр дэвтрийн урамшуулалыг бий болгосон бол ОХУ, АНУ-д татварын өршөөлийн тухай хуулийг баталж², тодорхой хугацааны хязгаартайгаар мэдүүлээгүй нуусан орлогоо ил болгож, татвараа нөхөн төлөх боломжийг олгож иржээ.

АНУ-д мөнгөн гүйлгээ хийсэн тохиолдолд тусгай маягт (8300-р) бөглөж тайлагнадаг бөгөөд 200000 ам доллараас дээш татварт ногдох орлогоос зайлсхийсэн бол эрүүгийн хэрэг үүсгэн мөрдөн шалгадаг журамтай.

ОХУ-д татварын гэмт явдалтай тэмцэх ажлыг ОХУ-ын татварын цагдаагийн алба гүйцэтгэдэг³. Харин Хятад болон Япон, АНУ-д татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийг илрүүлэх ажиллагааг татварын алба нь дотооддоо хэрэгжүүлэх эрхтэй байдаг онцлогтой.

¹ ХЗҮХ-ийн ЭЗЗКС-ийн ЭША Одонгэрэл Б. Эдийн засгийн гэмт хэргийн талаарх олон улсын ойлголт, АНУ, Японы туршлагаас илтгэл./power point/

² 2016.10.31-нд авав. <http://kk.docdat.com/docs/index-457185.html/>

³ Батжав Л.Гэмт явдал, түүний шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх асуудал.УБ.,2002.т.243



2. Эрүүгийн хууль тогтомжийн талаар:

Дээрх улсуудын татварын гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлагын асуудлыг судлахын тулд эрүүгийн хууль тогтоомжийг нь харьцуулан судлах явдал чухал юм. Иймээс дурдсан улсуудын эрүүгийн эрх зүйн зохицуулалтын талаар авч үзвэл:

ОХУ-ын Эрүүгийн хуулийн⁴ 8-р бүлгийн 198-р зүйлийн диспозицид татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн объектив талыг "Иргэд албан татвар төлөхөөс зайлсхийх, орлогын тухай мэдүүлээгүй, эсхүл илт худал мэдүүлэх аргаар их хэмжээний татвар төлөхөөс зайлсхийсэн бол" гэж тодорхойлж өгсөн бол 199-р зүйлд "...байгууллага татвар төлөхөөс зайлсхийх... орлого, зарлагын тухай илт худал мэдээллийг санхүү, нягтлан бодохын бичиг баримтанд оруулах замаар их хэмжээний татвар төлөхөөс зайлсхийсэн" гэж тус тус зааж өгчээ.

БНХАУ-ын Эрүүгийн хуулийн⁵ 3-р бүлэг буюу Социалист зах зээл, эдийн засгийн дэг журамд хор учруулсан гэмт хэрэг хэмээх бүлгийн 201, 202-р зүйлд татварын гэмт хэргийг хуульчилсан. Тус хуулийн 201-р зүйлд объектив талын үндсэн бүрэлдэхүүнийг "Татвар төлөгч хүн нягтлан бодох бүртгэлийн данс, тооцоог хуурамчаар үйлдэх, баримт

бичгийг засварлах, орлогоо нуун дарагдуулах, хэмжээг нь хасах, санаатайгаар худал мэдээлэх зэргээр орлого, зарлагынхаа хэмжээг багаар тооцуулбал, орлогынхоо мэдүүлгийг хуурамчаар бүрдүүлэх маягаар татвар өгөхгүй болон бага татвар өгөх гэж оролдвол, нуусан орлого нь 10-100 мянган юань байвал" гэж тус тус тодорхойлсон бол хүндрүүлэх бүрэлдэхүүнийг "нуусан этгээд нь урьд нь татварын хэргээр захиргааны арга хэмжээ авагдаж байсан бол" гэж заажээ. Харин тус хуулийн 202-р зүйлд татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн онц хүндрүүлэх бүрэлдэхүүнийг "...хүч хэрэглэж буюу хэрэглэхээр заналхийлж татвар төлөхөөс санаатайгаар зайлсхийсэн бол" гэж заасан байна.

Японы Эрүүгийн хуулийн⁶ 6-р бүлгийн 234-р зүйлд объектив талын үндсэн бүрэлдэхүүнийг "... татвар ногдох их хэмжээний орлогоо санаатайгаар нуун дарагдуулсан, буруу мэдээлсэн, энэ хэргийн улмаас хор уршиг учирсан" гэж заажээ.

Солонгосын Эрүүгийн хуулийн⁷ 5 бүлэг буюу хэв журмын эсрэг гэмт хэрэг гэсэн сэдвийн хүрээнд татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийг авч үзэж ял оноодог. Тус хуулийн 114.1 болон 114.2-р зүйлд татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн объектив

⁴ http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_10699/ Уголовный кодекс РФ от 13.06.1996 Ганболд

⁵ Дундсан цахим хаяг.

⁶ Ганболд Г.Татварын гэмт явдалтай хийх тэмцэл, онол практикийн зарим асуудал. Хууль зүйн ухааны магистрын зэрэг горилсон бүтээл, Шихихутуг ХЗДС.УБ., 2006. 29 дэх тал

⁷ 2017.04.10-нд авав <https://www.oecd.org/site/aboeecdanti-corruptioninitiative/46816472.pdf> /



талын үндсэн бүрэлдэхүүнийг “хувь хүн болон албан байгууллага татвар төлөхөөс санаатайгаар зайлсхийсэн үйлдэл, эс үйлдэхүй” гэж нийтлэг байдлаар тусгаж өгсөн бол 114.3-р зүйлд хүндрүүлэх бүрэлдэхүүнийг “114.2 дахь хэсэгт заасан торгох, албадан ажил хийлгэх буюу хорих ял шийтгэгдсэн этгээд дахин гэмт хэрэг үйлдвэл” гэж заасан байна.

Татварын гэмт хэргийн талаар АНУ нь дээрх улс орнуудыг бодвол Эрүүгийн хууль тогтоомжиндоо бус Хуулиудын эмхэтгэлийн 26 дугаар бүлэгтээ⁸ тусгаж зохицуулсан байдаг. Тус хуулийн 7201-р зүйлд зааснаар татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн объектив талын үндсэн бүрэлдэхүүн нь “Татварт ноогдуулсан төлбөрөөс санаатайгаар зайлсхийсэн үйлдэл” гэсэн бол 7202-р зүйлийн хувьд “хуульд заасан эрх зүйн дагуу татвар хураах, тайлан гаргах, мөн ноогдуулсан татвар төлөх, санаатайгаар хуурамч тайлан гаргаж, татвараа төлж хураалгахгүй” үйлдэл байдаг. Харин дээрх 2 зүйл заалтанд хүндрүүлэх бүрэлдэхүүнийг “онц хүнд буюу хүнд гэмт хэрэгтэн үйлдсэн” гэж нийтлэг байдлаар тодорхойлж өгчээ. Мөн хуулийн 7203-р зүйлд татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн объектив талын үндсэн бүрэлдэхүүнд “татварын деклараци гаргаж өгөхөөс хоцрох”-ыг хамааруулан авч үздэг бол хүндрүүлэх бүрэлдэхүүнд “Орлогын түхай худал мэдүүлэг гаргаж,

⁸ Title 26- internal revenue code / Subchapter A- Crimes, part 1-General provisions/

татвараас зайлхийх оролдлого хийсэн” байхыг шаарддаг.

Судалгаанд хамруулсан улс орнуудын эрүүгийн хууль тогтоомжийн заалтыг судалж үзвэл, татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн субъектив талын шинж нь гэм буруугийн шууд болон шууд бус санаатай үйлдлээр илэрдэг нь харагдана.

АНУ, БНХАУ, Японы Эрүүгийн хууль тогтоомжид зааснаар татварын гэмт хэрэг үйлдсэн хувь хүн болон байгууллагад эрүүгийн хариуцлага ногдуулдаг бол харин БНСУ, ОХУ-д зөвхөн хувь хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг онцлогтой.

Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлагын хувьд улс орнууд өөр өөр төрлийн ял ногдуулдаг.

Үндсэн бүрэлдэхүүний гэмт хэрэгт ОХУ нь Эрүүгийн хуулийн 198-р зүйлд заасны дагуу “...торгох буюу 240 цаг хүртэл албадан ажил хийлгэх, эсхүл 1 жил хүртэл хугацаагаар хорих ял” оноож байгаа бол 199-р зүйлд заасан гэмт хэргийн хувьд “...тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг нь 5 жил хүртэл хугацаагаар хасах, 6 сар хүртэл баривчлах, эсхүл 3 жил хүртэл хугацаагаар хорих ял” ноогдуулж байна.

БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 201-р зүйлд заасан үндсэн болон хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй гэмт



хэрэгт “3 жил хүртэл хугацаагаар хорих, нуусан орлогыг 5 дахин өсгөж торгууль ногдуулах” ял оноодог бол, онц хүндрүүлэх гэмт бүрэлдэхүүнтэй гэмт хэрэгт 202-р зүйлд зааснаар “3 жил хүртэл хугацаагаар хорих, нуусан орлогыг 1-5 дахин нэмэгдүүлэн торгох”-оор ял ногдуулахаар заажээ.

Япон улсын хувьд Эрүүгийн хуулийн 234-р зүйлд “3 хүртэл жилийн хорих ял оноох, татвараас нуусан зүйлийг хураан авна” гэж заасан.

БНСУ-ын Эрүүгийн хуулийн 114.2-т зааснаар үндсэн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэгт “15 сая вон хүртэлх торгууль ногдуулж, албадан ажил хийлгэх, эсхүл 10 жил хүртэл хугацаагаар хорих ял” оноохоор заасан бол тус хуулийн 114.3-т хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй гэмт хэрэгт оногдуулах ялын санкцыг “торгох, албадан ажил хийлгэх буюу хорих ял шийтгэгдсэн этгээд дахин гэмт хэрэг үйлдвэл тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг нь 10 жилийн хугацаагаар түдгэлзүүлэх” гэж тусгажээ.

АНУ-ын Хуулиудын эмхэтгэлийн 26 дугаар бүлгийн 7201 болон 7202-р зүйлд зааснаар татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн объектив талын үндсэн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэгт “торгууль ногдуулах” ял нийтлэг байдлаар оноож байгаа бол 7203-р зүйлд зааснаар “1 жил хүртэл хорих буюу торгох” ял

оноож байна. Харин хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй гэмт хэргийн хувьд 7201-р зүйлд зааснаар “ял шийтгэсэн таслан шийдвэрлэх тогтоолоор 100,000\$ торгох /хуулийн этгээдийг 500,000\$ хүртэл торгох/, буюу 5 жилээс илүүгүй хугацаагаар хорьж, ял шийтгэгдсэнтэй холбогдон гарсан зардлыг хамтад нь оноож” байгаа бол 7202-р зүйлд зааснаар “хэрэгтэнг ял шийтгэсэн таслан шийдвэрлэх тогтоолоор 10,000\$ торгох буюу 5 жилээс илүүгүй хугацаагаар хорьж, ял шийтгэгдсэнтэй холбогдон гарсан зардлыг хамтад нь оноож” байна. 7203-р зүйлд зааснаар “таван жил хүртэл хугацаагаар хорих буюу 5,000 доллар хүртэл торгох” ял оноодог байна.

Дүгнэлт

Ази, Номхон далайн орнуудын төлөөлөл болох АНУ, БНСУ, БНХАУ, ОХУ болон Япон улсууд нь Үндсэн хууль болон татварын хууль тогтоомжид зааснаар иргэд хуулиар оногдуулсан албан татвар төлөх үүрэгтэй бөгөөд улсын болон орон нутгийн таварын тогтолцоотой байдаг.

ОХУ-д татварын гэмт явдалтай тэмцэх ажлыг ОХУ-ын татварын цагдаагийн алба гүйцэтгэдэг бол БНХАУ болон Япон, АНУ-д татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийг илрүүлэх ажиллагааг татварын алба нь дотооддоо хэрэгжүүлэх эрхтэйгээс үзэхэд, татвар төлөгчид нь татвараа хугацаанд нь төлдөг, татварын боловсрол өндөр, татвар



ЖИЖИГ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ТУХАЙ



Э.Эрхбилгүүн
Магистрант,

Түлхүүр үг- жижиг хувьцаа эзэмшигч, эрх ашиг, эрх зүйн зохицуулалт

Товчлол - Эрдэм шинжилгээний энэ өгүүлэлд жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах Монгол Улсын эрх зүйн зохицуулалт болон түүний практик дах хэрэгжилт, үр нөлөөг Их Британи болон Канад Улсын эрх зүйн зохицуулалттай харьцуулан судалж өнөөгийн зохицуулалтыг оновчлох талаар авч үзэв.

Удиртгал

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын хөрөнгө оруулалт болон үнэт цаасны зах зээлийн салбар хөгжихийн хэрээр шийдвэрлэвэл зохих олон асуудал үүссээр байна. Тэдгээр нь нэлээд ярвигтай, янз бүрийн салбарыг хамарсан маргаан, мэтгэлцээн дагуулсан ба тухайлбал, нэг хэсэг нь хууль эрх зүйн нийтлэг шинжтэй. Тиймээс ч компани, үнэт цаасны зах зээлийн эрх зүйн зохицуулалтыг онцлон авч үзэх шаардлага тулгарч байна. Компани болон хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг оновчтой, үйлчлэлтэй болгох зарим харилцаа нь хууль, эрх зүйн зохицуулалтад ороогүй ялангуяа жижиг хувьцаа эзэмшигчтэй холбоотой асуудлууд урсгалаараа орхигдоход хүрээд байгаа нь судалгаа, шинжилгээ, практик хэрэглээний аль ч чиглэлээр анхаарал татсаар байна. Тухайлбал:

1. Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг зөрчигдөж байгаа талаар;
2. Тэдгээрийн эрх ашгийг хамгаалж буй олон улсын жишиг туршлага, түүнийг Монгол Улсад нутагшуулах, хэрэгжүүлэх арга техникийг юуны түрүүнд нэрлэж болно.



төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн гаралт харьцангуй бага байдаг сайн тал ажиглагдаж байна.

Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэгтэй холбоотой асуудлыг АНУ-д Хуулиудын Эмхтгэлийн 26 дугаар бүлэгт тусад нь тусгаж зохицуулдаг байхад, ОХУ, БНХАУ, Япон, БНСУ-ын хувьд Эрүүгийн хуулиараа зохицуулсан байдаг.

Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн субъектын хувьд АНУ, БНХАУ, Японд иргэн, корпораци, компани /хуулийн этгээд/-ийг авч үздэг бол ОХУ, БНСУ-д зөвхөн иргэн энэ хэргийн субъект болдог байна. Субъектив талын хувьд гэм буруугийн шууд болон шууд бус санаатай үйлдэгддэг.

Эрүүгийн хууль тогтоомжид татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талыг “данс тооцоог хуурамчаар үйлдэх зэргээр татвар төлөхөөс зайлсхийсэн, эсхүл бага хэмжээгээр төлөх, татварын орлогоо мэдүүлээгүй, эсхүл худал мэдүүлэх аргаар их хэмжээний татвар төлөхөөс зайлсхийх” гэх зэргээр нийтлэг байдлаар хуульчилжээ. БНХАУ-д урьд нь захиргааны арга хэмжээ авагдсан бол эрүүгийн ял ногдуулахаар, Японд энэ гэмт хэргийн улмаас хор уршиг учруулсан тохиолдолд ял ногдуулахаар, ОХУ-д их хэмжээний татвар төлөхөөс зайлсхийсэн бол ял ногдуулахаар тус тус хуульчилсан байна. Харин энэ гэмт хэргийн хүндрүүлэх

бүрэлдэхүүнийг “хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж татвар төлөхөөс санаатайгаар зайлсхийсэн (БНХАУ)”, “Энэ хэрэгт урьд нь ял шийтгэгдсэн этгээд уг гэмт хэргийг давтан үйлдвэл (БНСУ)”, “Илт худал мэдээллийг санхүү, нягтлан бодох бүртгэлийн бичиг баримтанд оруулах замаар их хэмжээний татвар төлөхөөс зайлсхийвэл (ОХУ)” гэж тус тус хуульчлан заасан .

Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлагын хувьд улс орнууд өөр өөр төрлийн ял ноогдуулж байгаагийн дотор торгох, албадан ажилхийлгэх, тодорхой албантушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг нь хасах, түдгэлзүүлэх, татвараас нуусан зүйлийг хураан авах, ял шийтгэгдсэнтэй холбогдон гарсан зардлыг хамтад нь оноох, баривчлах, хорих ял тус тус ноогдуулж байна.

Үндсэн бүрэлдэхүүний гэмт хэрэгт хорих ялын хугацаа 1-10 жил хүртэл байгаагийн дотор хорих ялын хугацаа ОХУ-д хамгийн бага буюу 1 жил хүртэл хугацаагаар хорих, БНСУ-д хорих ялын хугацаа хамгийн их буюу 10 жил хүртэл хорих ял ногдуулж байна.



I

Хувьцаа эзэмшигчдийн, ялангуяа жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг ерөнхийдөө 2 янзаар зөрчигддөг. Нэгт, дотоодын нөлөөллөөр буюу уг хувьцаа эзэмшигчийн хувьцааг нь эзэмшиж буй компани нь эсхүл түүний бусад хувьцаа эзэмшигч зөрчих тохиолдол байх бол нөгөө тохиолдол нь гадны нөлөөллөөр буюу ялангуяа хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг брокер дилерийн компани, нотариатч гэх мэт компанийн дотоод этгээд бус гуравдагч этгээдүүд зөрчих явдал юм.

Дотоод нөлөөллөөр буюу компани, түүний хувьцаа эзэмшигчид, эрх бүхий албан тушаалтан жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг зөрчих явдал нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчдийн хувьд түгээмэл тохиолддог. Тодорхойлбол, Монгол Улсад байнга байдаггүй гадаадын иргэд хувьцаа эзэмших тохиолдолд, тэдгээрийн хувьцааг хуурамч баримт бичиг бүрдүүлэн шилжүүлж, Улсын бүртгэлд бүртгүүлсэн¹, эсхүл хувьцаа эзэмшигч болохоор тохиролцож, хувь нийлүүлсэн хөрөнгө шилжүүлсээр байтал Улсын бүртгэлд хувьцаа эзэмшигч гэж бүртгүүлэхээс зайлсхийсэн², компанийн бүх

гишүүдийн 100%-ийн саналаар шийдвэрлэх асуудлыг жижиг хувьцаа эзэмшигчийн оролцоогүйгээр том хувьцаа эзэмшигчид хамтран шийдвэрлэсэн³, том хувьцаа эзэмшигчид нийлэн жижиг хувьцаа эзэмшигчийн хувьцааг түүний зөвшөөрөлгүйгээр компанийн халаасны хувьцаа болгосон, хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмыг биелүүлээгүй⁴ гэх мэт жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг олон янзаар зөрчигдсөөр иржээ. Эдгээр нь зөвхөн нийтэд ил болсон, эсхүл хувьцаа эзэмшигчид нь өөрсдийн эрх ашгийг хөндөгдөж байгааг мэдсэн тохиолдлууд бөгөөд үүнээс бусдаар шүүхийн шатанд очоогүй олон эрх ашиг зөрчигдөж байхыг үгүйсгэх боломжгүй юм.

Шүүхийн шийдвэрүүдээс үзэхэд хувьцаат компанийн жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг мөн хэд хэдэн байдлаар зөрчигдсөн байх бөгөөд үүнд хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохих ёсоор зарлаагүй, хувьцаа эзэмшигчдийн зөвшөөрөлгүйгээр их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн гэх зэрэг олон төрлийн маргаан гарчээ. Түүнчлэн, хувьцааг зөвшөөрөлгүйгээр зарж, борлуулсан асуудал нь нэлээд байгаа бөгөөд тухайлбал хувьцаа эзэмшигчийн гарын үсгийг дуурайлган зурсан⁵,

¹ Баянгол дүүргийн шүүхийн шүүгчийн 2012 оны 06 сарын 08 –ны өдрийн 1123 –р захирамж

² Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүхийн 2006 оны 03 сарын 07 –ний өдрийн 133 тоот тогтоол

³ Баянгол дүүргийн иргэний хэргийн шүүхийн 2011 оны 08 сарын 29 –ний өдрийн 1465 тоот шийдвэр

⁴ Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн 2011 оны 08 сарын 12 –ны өдрийн 702 тоот магадлал


⁵ Нийслэлийн шүүхийн 2009 оны 07 сарын 06 –ны өдрийн 493 тоот магадлал



гэр бүлийн гишүүнийг нь хууран мэхэлж гүйлгээ хийсэн⁶ ⁷, хуурамч итгэмжлэл үйлдэн зарж борлуулсан⁸ гэх мэт арга голлож байна. Эдгээр үйлдлүүдийн эсрэг Санхүүгийн Зохицуулах Хороо (“СЗХ”) –ноос үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудад тавих хяналт, шалгалтыг чангатгаж, илүү нарийн зохицуулалт тусгасан дүрэм, журам баталж, шаардлага тавьж эхэлснээр эдгээр зөрчлийн тоо эрс буурсан гэх ойлголт нэлээд түгээмэл бий.

Монгол Улсын хөрөнгийн биржээс гаргасан хувьцаат компаниудын хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулсан байдлын 2012-2016 онуудын дэлгэрэнгүйг График 1 –т тусгав.

График 1



Дээрх үзүүлэлтээс харахад бүртгэлтэй ХК –ийн тоо багассан ч хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хугацаандаа хуралдуулдаг

⁶ Чингэлтэй дүүргийн шүүхийн 2012 оны 03 сарын 06 –ны өдрийн 0381 тог шийдвэр


⁷ Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүхийн 2008 оны 06 сарын 12 –ний өдрийн 276 тоот тогтоол

⁸ Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүхийн 2009 оны 12 сарын 17 –ний өдрийн 737 тоот тогтоол

компанийн тоо өсөөгүй, нэг хэвэндээ байгаа нь харагдаж байна. Сүүлийн дөрвөн жилд хурал зарлан хуралдуулсан компанийн тоонд огцом өөрчлөлт ороогүй байгаа нь бас л нэг сөрөг үзүүлэлт. Энэ нь хурлаа зарлан хуралдуулахгүй байгаа компаниудтай хариуцлага тооцох асуудал сул байгааг илтгэж байгаа бөгөөд хэрэв өндөр торгууль оногдуулдаг болвол, энэхүү зөрчил багасахад эерэгээр нөлөөлөх учиртай.

Ногдол ашиг авах эрх хөндөгдөх нь. Доорх График 2 –т харуулснаар, ногдол ашиг тараадаг компанийн тоо нийт бүртгэлтэй ХК –ийн 10 хувьд ч хүрэхгүй байгааг харж болно. Компаниудын дунд аль болох ногдол ашиг тараахгүй байх бодлого, чиглэлийг баримталдаг. Гэтэл хөрөнгө оруулагчдын компанид хувь эзэмших хамгийн гол шалтгаан нь ногдол ашиг хүртэх бөгөөд компаниуд ногдол ашиг тараахгүй байна гэдэг нь эргээд хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчдийн уг компанид нэмэлт хөрөнгө оруулахгүй байхад хүргэдэг.

График 2



Үүнээс гадна, ногдол ашиг тараагаагүйтэй холбоотой маргаанд мэргэжлийн, хөндлөнгийн байгууллагын хяналт, оролцоо



бага байдгаас жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг тэр болгон хамгаалагддаггүй. Маргааныг эцэслэн шийдвэрлэдэг шүүх гэхэд л компанийн тайлан баланс, санхүүгийн бусад баримт бичгийг хараад ногдол ашиг хуваарилах боломжтой эсэх, хаана ямар зөрчил, хангалтгүй байдал гаргаж, зориуд зардал ихэсгэх асуудал байгаа талаар тэр бүр илрүүлэх боломж бололцоо муутай, мэдлэг туршлага дутмаг, цаг хугацаанд шахагддагаас зөрчил, дутагдал төдийлөн танигддаггүй.

Манай орны нэг онцлог бол Өмч хувьчлалын хуулийн дагуу бараг хүн бүр аль нэг хувьцаат компанийн хувьцаа эзэмшигч болсон. Гэтэл иргэд маань хувьцаа эзэмшдэгээ мартсан эсхүл ойлгодоггүй, ногдол ашгаа авдаггүй, хуралдаа ч оролцдоггүй. Иймээс ч хувьцаа нь эзэнгүй мэт орхигдсон. Энэ нь тухайн компанийн томоохон хувьцаа эзэмшигч буюу гүйцэтгэх удирдлагад тэдний зүгээс тавих шаардлага, хяналтгүй болгох гол үндэслэл болдог. Ийм нөхцөлд зарим компанийн удирдлага компанийн хөрөнгийг дураараа захиран зарцуулж, үйл ажиллагааг нь зогсоох, тэр ч бүү хэл, худалдаж хувьдаа өөр компани байгуулж завшсан тохиолдол ч бий.

II

Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зохицуулалтыг үндсэн гурван шатанд авч үзвэл,

нэгдүгээрт тодорхой компанийн хувьцаа эзэмшигч болохын өмнө эрх ашгаа хамгаалах зохицуулалт, хоёрдугаарт хувьцаа эзэмшигч болсоны дараа эрх ашгаа хамгаалах зохицуулалт болон, гуравдугаарт хувьцаа эзэмшигч байхаа болих үед эрх ашгаа хамгаалах зохицуулалт гэж тус тус ангилж болох юм.

Компанийн хувьцаа эзэмшигч болохын өмнө эрх ашгаа хамгаалах зохицуулалт, арга техник нь ХХК –ийн жижиг хувьцаа эзэмшигчдэд илүү тохиромжтой бөгөөд энэ үед л эрх ашгаа хамгаалах зохицуулалтыг хийж, ирээдүйн байр сууриа бэхжүүлэх нь хувьцаа эзэмшигчийн хувьд хамгийн чухал асуудал. Учир нь ХХК –ийн жижиг хувьцаа эзэмшигч болохоос өмнө хэлцлийн шатыг, ялангуяа цөөн хувьцаа эзэмшигчтэй компанийн хувьд өөрийн эрх ашгийг хамгаалах зохицуулалтыг бусад хувьцаа эзэмшигчидтэй хэлэлцэж тохирон, улмаар хувьцаа эзэмшигчдийн гэрээ байгуулах, компанийн дүрэмд өөрчлөлт оруулах зэрэг хэд хэдэн чухал зохицуулалтыг хийх боломжтой.

Компанийн хувьцаа эзэмшигч болсоны дараа эрх ашгаа хамгаалах зохицуулалтын хувьд, Хувьцаа эзэмшигчийн дарамт, шахалт, хавчлагын тухай зохицуулалт гэх шинэ зохицуулалт Англи улсад анх хэрэгжиж эхэлсэн бөгөөд Англиар “shareholder oppression” буюу хувьцаа эзэмшигчийн дарамт, шахалт, хавчлага гэж



ойлгож болох зохицуулалтын хүрээ нь өргөн учраас ганцхан үгээр орлуулах боломжгүй. Манайд энэ зохицуулалтыг хэрэглэдэггүй, гэтэл уг зохицуулалтыг хэрэглэдэггүй улс орнууд ховор.

Канадын Бритиш Колумб мужийн Бизнесийн Корпорацийн тухай хуулийн 227 –р хэсэгт дээрх зохицуулалтыг дараах байдлаар тусгажээ.

“1. Компанийн үйл ажиллагаа нь, “дарамт, шахалт үзүүлэхүйц” байдлаар явагдсан, явагдаж байгаа (эсхүл Компанийн захирал бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ тийнхүү байдлаар хэрэгжүүлсэн, хэрэгжүүлж байгаа); 2. Компанийн зарим гүйцэтгэсэн (эсхүл гүйцэтгэхээр завдаж буй) үйл ажиллагаа нь эсхүл хувьцаа эзэмшигчдийн гаргасан (эсхүл гаргах гэж байгаа) шийдвэр нь нэг эсхүл хэд хэдэн хувьцаа эзэмшигчдийг шударга бусаар ялгаварлан гадуурхсан”⁹.

Эхлээд шударга бусаар ялгаварлан гадуурхсан гэдэг ойлголтыг Канад Улсын дээд шүүх тайлбарлахдаа компанийн аливаа шударга үнэнд нийцээгүй үйлдэл нь хувьцаа эзэмшигчийн хууль ёсны эрх ашигт халдаж, компанийг хэрхэн удирдан явуулах талаар гаргасан түүний үндэслэл бүхий хүлээлтийг зөрчсөн үйлдэл гэж тодорхойлсон байдаг.

Дарамт, шахалт үзүүлсэн гэх

⁹ Канад Улсын Бритиш Колумб мужийн 2002 оны Бизнесийн Корпорацийн тухай хуулийн 227 –р зүйл

үндэслэлтэй нэхэмжлэлд дараах арга хэмжээг авч, шийдвэр гаргаж болдог байна. Үүнд:

1. Компани, хувьцаа эзэмшигчид эсхүл захирлын үйлдлийг хүчингүй болгох, хориглох, 2. Компанийн дүрэм, дотоод журмын аль тохирох заалтыг хүчингүй болгох; 3. Ногдол ашиг хуваарилахыг даалгах; 4. Бизнесийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн явуулах костоудиан буюу төлөөлөгч томилох; 5. Орлогч захирал тохилох; 6. Захирлыг албан тушаалаас нь чөлөөлөх; 7. Нягтлан бодох бүртгэл хөтлөхийг шаардах; 8. Хохирлыг нөхөн төлүүлэх; 9. Жижиг хувьцаа эзэмшигчийг компанид эрхэлж байсан албан тушаалд нь буцаан томилох; 10. Компаниас шударга бусаар завшсан мөнгийн эргүүлэн төлүүлэх; 11. Том хувьцаа эзэмшигчийн цалин хөлсийг багасгах; 12. Зарласан хувьцааг хүчингүй болгох; 13. Жижиг хувьцаа эзэмшигчийг нэмж хувьцаа худалдан авахыг зөвшөөрөх зэрэг хувьцаа эзэмшигчийн эрх ашгийг хамгаалсан нилээдгүй олон төрлийн шийдвэрийг гаргадаг байна.¹⁰

Хувьцаа эзэмшигчийн дарамт, шахалт, хавчлагын тухай зохицуулалтын гарал үүсэл нь Их Британи буюу шүүхийн прециденттэй улсаас гарсан бөгөөд Их Британи юм уу Канад Улсад хэрэглэгддэг чигээр нь Монгол Улсын хуульд тусгаж хэрэгжүүлэх нь өөрөө өрөөсгөл

¹⁰ Ладд Хирч, Жэйсон Фултон “хувьцаа эзэмшигч байгаа болихоос өөрөөр хувьцаа эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах тухай” Бизнесийн сэтгүүл 4-р дугаар (2010) х. 3



асуудал. Учир нь энэ зохицуулалтаар Их Британи болон Канад Улсууд гурван зуун жилийн турш хэрэг шийдвэрлэж ирсэн бөгөөд, тухайн шүүхийн шийдвэрүүд нь хууль эрх зүйн үр нөлөөтэй, өөрөөр хэлбэл тухайн зохицуулалтыг нарийн тайлбарласан, яаж хэрэглэхийг заасан, үг утгын санааг тодорхойлсон олон олон шүүхийн шийдвэрүүд дээр үндэслэн дараа дараагийн хэргийг шийдвэрлэдэг. Манайх шиг шүүхийн прецедентийг хэрэглэдэггүй оронд олон жилийн түүхтэй зохицуулалтыг шууд хуульд тусгах нь ихээхэн учир дутагдалтай болох биз.

Гэхдээ энэ нь уг зохицуулалтыг Монгол Улсад хэрэгжүүлэх огт боломжгүй гэсэн үг биш. КТХ-ийн нэмэлт өөрчлөлтөөр уг зохицуулалтыг оруулах боломжтой, түүний утга учрыг Монгол Улсын Дээд Шүүх Монгол Улсын Үндсэн Хуулийн тавьдугаар зүйлийн нэг дэх хэсгийн дөрөвт заасны дагуу тайлбарлах эрхтэй.

Харин гурав дах үе шатны буюу хувьцаа эзэмшигч байхаа болих үеийнхамгаалалтыгхэрэгжүүлэххоёр арга зам байж болно. Нэгдүгээрт, Улсын байцаагч томилохыг шаардах эрх юм. Канад Улсын Бизнесийн Корпорацийн тухай хуулийн дагуу хэрэв аливаа компанийн нийт хувьцааны 5/1 болон түүнээс дээш хувийг эзэмшигч нь компанийн удирдах албан тушаалтан, ТУЗ болон бусад хувьцаа эзэмшигчийг хууль бус үйлдэл хийж байна,

эсхүл хуурамч хууль бус үйлдэл, эс үйлдэхүй хийхийг завдаж байна гэж үзсэн тохиолдолд компанийн бүхий л баримт бичгийг хянаж, шалгуулахаар байцаагч томилохыг шаардсан нэхэмжлэлийг шүүхэд гаргаж болдог байна. Ингэснээрээ хэрэв тухайн компани нь үнэхээр хууль бус үйлдэл хийж байгаа эсхүл хийх гэж байвал холбогдох этгээдтэй хариуцлага тооцох бөгөөд чингэхдээ нэхэмжлэл гаргасан хувьцаа эзэмшигчийг уг асуудалтай холбоотой бүх эрх, үүргээс нь чөлөөлж, түүнд халдашгүй байдлыг олгодгоороо их онцлогтой.

Хоёрдугаарт, Канад Улсын холбогдох хуулийн дагуу хувьцаа эзэмшигч нь дараах шалтгаанаар компанийг татан буулгах нэхэмжлэлийн шаардлагыг шүүхэд гаргах эрхтэй. Үүнд:

1. Хувьцаа эзэмшигчдийн хооронд зохицуулж боломгүй сөргөлдөөн гарч, энэ нь компанийг зөв зохистой удирдахад саад болж байгаа; бол

2. Компанийг байгуулсан гол зорилго, шалтгаан нь үгүй болсон; бол

3. Компанийн ТУЗ –ийн гишүүд нь албан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй, итгэл эвдсэн үйл ажиллагаа явуулж, үүнийг бусад хувьцаа эзэмшигчид мэдсэн хэрнээ зогсоох ямар нэг арга хэмжээ авахгүй байх тохиолдолд." Энэ нь " Стефен Англь, Стефен Т.С.Варнетт "Бритиш Колумб мужийн Компанийн болон Үнэт цаасны тухай хуулийн дагуу хувьцаа эзэмшигчдэд учирсан хохирлыг арилгах аргууд" (2009) х. 31



шүүхээс жижиг хувьцаа эзэмшигчид олгож буй, магадгүй хамгийн боломжит хамгаалалт байж болох юм.

Дүгнэлт

Тухайн улс орон жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хэдий чинээ сайн хамгаалсан зохицуулалттай байна төдий чинээ хөрөнгө оруулалт дэмжигдэх бөгөөд, ялангуяа манай орон шиг үнэт цаасны зах зээл нь төдийлөн хөгжөөгүй оронд ихээхэн хэрэгтэй. Үүнээс гадна зөвхөн зохицуулаад зогсохгүй хэрэгжүүлэх нь чухал ба чингэж байж тодорхой үр дүнд хүрнэ. Хуулиндаа заасан ч ААН, албан газрууд биелүүлэхгүй байх, уг үйлдэлд хариуцлага тооцох механизмгүй бол жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг нь зөрчигдсөн хэвээр, өөрчлөлт шинэчлэлт гарахгүй орхигдоно. Англи, Америк, Хонг Конг, Сингапур зэрэг улсуудын үнэт цаасны зах зээл нь өндөр хөгжсөн, ихээхэн ашигтай салбар. Тэдгээр нь үнэт цаасны зах зээл нь хөгжил буурай бусад орноос юугаараа ялгаатай вэ гэвэл эрх зүйн нарийн зохицуулалттай, хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хатуу хариуцлага хүлээлгэдэг, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг сайтар хамгаалж чадсан гэж эрдэмтэд, шинжээчид үздэг.¹²

Энэхүү өгүүлэлдээ жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг Монгол Улсад хэрхэн зөрчигдөж байгаа талаар авч үзэн, түүнд үндэслэн уг асуудлыг зарим орнуудтай харьцуулан судалж, шалгарсан практикийг Монгол Улсад хэрэгжүүлэх боломж бий эсэхийг харуулахыг хичээв.

Эх сурвалж

1. Баянгол дүүргийн шүүхийн шүүгчийн 2012 оны 06 сарын 08 – ны өдрийн 1123 –р захирамж
2. Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүхийн 2006 оны 03 сарын 07 –ний өдрийн 133 тоот тогтоол
3. Баянгол дүүргийн иргэний хэргийн шүүхийн 2011 оны 08 сарын 29 –ний өдрийн 1465 тоот шийдвэр
4. Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн 2011 оны 08 сарын 12 –ны өдрийн 702 тоот магадлал
5. Нийслэлийн шүүхийн 2009 оны 07 сарын 06 –ны өдрийн 493 тоот магадлал
6. Чингэлтэй дүүргийн шүүхийн 2012 оны 03 сарын 06 –ны өдрийн 0381 тоот шийдвэр
7. Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүхийн 2008 оны 06 сарын 12 –ний өдрийн 276 тоот тогтоол
8. Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүхийн 2009 оны 12 сарын 17 –ний өдрийн 737 тоот тогтоол

¹² Гүйллэн, Капрон "Зах зээлд жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахын үнэ цэнэ", (2015) www.knowledge.wharton.upenn.edu/article/the-value-of-protecting-minority-shareholders-in-the-market



9. Компанийн тухай хууль (2011)
10. Канад Улсын Бритиш Колумб мужийн 2002 оны Бизнесийн Корпорацийн тухай хууль
11. Starcom International Optics Corp. v. Macdonald [1994] B.C.J. No. 548 (QL) (S.C.)
12. Стефен Антль, Стефен Т.С.Варнетт “Бритиш Колумб мужийн Компанийн болон Үнэт цаасны тухай хуулийн дагуу хувьцаа эзэмшигчдэд учирсан хохирлыг арилгах аргууд” (2009)
13. Ладд Хирч, Жэйсон Фултон “хувьцаа эзэмшигч байхаа болихоос өөрөөр хувьцаа эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах тухай” Бизнесийн сэтгүүл 4-р дугаар (2010)
14. Стефен Антль, Стефен Т.С.Варнетт “Бритиш Колумб мужийн Компанийн болон Үнэт цаасны тухай хуулийн дагуу хувьцаа эзэмшигчдэд учирсан хохирлыг арилгах аргууд” (2009)
15. Гүйллэн, Капрон “Зах зээлд жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахын үнэ цэнэ”, (2015) www.knowledge.wharton.upenn.edu/article/the-value-of-protecting-minority-shareholders-in-the-market